



ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД НИЙГЭМ-СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ АРГА ЗҮЙ

НИЙГМИЙН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН
ГАРЫН АВЛАГА

УЛААНБААТАР
2023 ОН

Энэхүү гарын авлагыг
Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк хамтран
Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох
Японы сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй
“G9198/9221-MON: Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх”
төслийн санхүүжилтээр сайжруулан боловсруулж, хэвлүүлэв.



Захиалагч: МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

Санхүүжүүлэгч: АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК, "ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ГЭР
БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ" ТӨСӨЛ G9198/9221-MON

Боловсруулсан: Х.ЭНХЖАРГАЛ, Анагаах ухааны доктор (PhD)
Г.ГАНБАЯСГАХ, Нийгэм судлаач

Хянасан: Н.БАЯРМАА, ХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Р.НАРАНТУЯА, ХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын
шинжээч

Цаасны хэмжээ: 210x290

Хэвлэлийн хуудас: 10.3

"Мөнхийн Үсэг" ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	5
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	7

БҮЛЭГ 1. БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ..... 9

1.1 Бэлгийн хүчирхийлэл гэж юуг хэлэх вэ?	9
1.2 Бэлгийн хүчирхийлэл хүний эрхийн зөрчил болох нь	9
1.3 Бэлгийн хүчирхийллийн талаарх тоо баримт	10
1.4 Бэлгийн хүчирхийллийн төрлүүд	11

БҮЛЭГ 2. ХҮҮХДИЙН ЭСРЭГ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ 13

1.1 Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл гэж юуг хэлэх вэ?	13
1.2 Хүүхэд хүчирхийллээс ангид байх халдашгүй эрхтэй болох нь	14
1.3 Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн динамик	15
1.4 Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн илрэх хэлбэр, түгээмэл шинжүүд	15
1.5 Хүүхдийн ураг төрлийн бэлгийн хүчирхийлэл.....	17
1.6 Хүүхдийн цахим бэлгийн хүчирхийлэл	18
1.7 Бэлгийн хүчирхийллийн хүүхдэд үзүүлэх хор нөлөө	21
1.8 Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн талаарх буруу ойлголтууд	22

БҮЛЭГ 3. НИЙГЭМ-СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ: ҮНДСЭН УХАГДАХУУН.....24

3.1 Нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө гэж юуг хэлэх вэ?	24
3.2 Нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөний зорилго, төрөл, үе шат	24
3.3 Нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөхөд баримтлах зарчмууд, ёс зүйн асуудал	26
3.4 Нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөхөд шаардагдах ур чадварууд	28
3.5 Нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөхөд хэрэглэх аргууд	31

БҮЛЭГ 4. БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД НИЙГЭМ-СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ НЬ34

4.1 Хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөхөд баримтлах өвөрмөц зарчмууд	34
4.2 Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг ойлгох нь	36
4.3 Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөх алхмууд	40
4.4 Хүүхдэд өгөх нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөний арга зүйн онцлог	46
4.5 Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн гэр бүлд зөвлөгөө өгөх нь	51

БҮЛЭГ 5. ХҮҮХДИЙН НАСНЫ ОНЦЛОГТОЙ НИЙГЭМ СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ55

5.1 Бага насны бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, гэр бүлд нь өгөх зөвлөгөө ..	55
5.2 Сургуулийн өмнөх насны хохирогч хүүхэд, тэдний гэр бүлд өгөх зөвлөгөө.....	56
5.3 Сургуулийн бага насны хохирогч хүүхэд, тэдний гэр бүлд өгөх зөвлөгөө.....	59
5.4 Өсвөр насны хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд өгөх зөвлөгөө	61

БҮЛЭГ 6. УРАГ ТӨРЛИЙН ХҮЧИН, БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ЦАХИМ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ГЭР БҮЛД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ 67

6.1 Ураг төрлийн бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, гэр бүлд зөвлөгөө өгөх нь	67
6.2 Бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийнхэнд зөвлөгөө өгөх нь	73
6.3 Цахим бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлд зөвлөгөө өгөх нь.....	76

БҮЛЭГ 7. БУСАД ҮЙЛЧИЛГЭЭНД ХОЛБОН ЗУУЧЛАХАД ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ ЗӨВЛӨГӨӨ 81

7.1 Хуулийн байгууллагад холбон зуучлахад өгөх мэдээлэл зөвлөгөө	81
7.2 Эмнэлгийн тусламжид илгээхэд өгөх мэдээлэл зөвлөгөө.....	82
7.3 Шүүх эмнэлгийн үзлэг шинжилгээ хийлгэх талаар өгөх мэдээлэл зөвлөгөө	83
7.4 Шүүх хуралд оролцох талаар өгөх мэдээлэл зөвлөгөө	84

ХАВСРАЛТУУД.....85

НОМ ЗҮЙ.....89

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Засгийн газраас гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх зүйн орчинг боловсронгуй болгох, салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг сайжруулах, жендэрийн тэгш бус байдлаас үүдэлтэй хүчирхийлэл, түүний дотор бэлгийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах, тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхыг бэхжүүлэх арга хэмжээ авч байна.

Гэсэн хэдий ч хүүхдийн эсрэг хүчирхийлэл ялангуяа гэр бүл, ураг төрлийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо буурахгүй байна. Тухайлбал, 2023 онд улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байраар нийт 3668 хүн үйлчилгээ авснаас 80,9 хувь нь хүүхэд, эдгээрийн 10 гаруй хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд байна.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажиллахад урт хугацаанд мэргэжлийн нийгмийн ажил, үйлчилгээ үзүүлэх, хамгаалах шаардлагатай байдаг. Учир нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн бие махбод, сэтгэл зүй, сэтгэц хүнд гэмтэл авдаг.

Ялангуяа хайртай дотныхоо гэр бүлийн гишүүдийн зүгээс хүчирхийлэлд өртсөн хүүхдийг нөхөн сэргээх, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэхэд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийг буруутгах хандлага гаргах, гэр бүлийн гишүүдийн эдийн засгийн хэрэгцээ, хараат байдлаас шалтгаалах, хэргийн явцад нөлөөлөх зэрэг маш олон хүндрэл гардаг. Тиймээс хүчирхийллийн харилцаатай гэр бүлд байгаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд тусгайлан урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхээс гадна гэр бүлийн гишүүн бүрдээ нь ажиллах зайлшгүй хэрэгцээ, шаардлагатай.

Энэхүү нөхцөл байдалд хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн гишүүн бүрдээ ажиллаж байж, тухайн хүүхдийн бие сэтгэхүйд гарсан гэмтэл нөхөн сэргээгдэх, нийгмийн ажилтны болон салбар дундын хамтын ажиллагаа хичээл зүтгэлээр уг кейс амжилттай шийдвэрлэгдэх нөхцөл үүсдэг.

Тус яамнаас бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэдтэй ажиллахад нийгмийн ажилтанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор 2019 онд “Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх” сургалтын гарын авлагыг хөтөлбөрийн хамт боловсруулж, улсын хэмжээнд сургалт зохион байгуулсан.

Дээрх гарын авлагын үргэлжлэл болгож, нийгмийн ажилтнууд, сэтгэл зүйч нарт эзэмшвэл зохих ур чадварууд болох бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд болон тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх арга зүй, үйл явц, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар цогц мэдлэг, ур чадвар олгох зорилгоор “Бэлгийн хүчирхийллийн кейс менежмент, нийгмийн ажлын холбон зуучлах үйлчилгээний арга зүй”-н удирдамжийн хамт цогцоор боловсрууллаа.

Уг арга зүйн гарын авлага нь Та бүхний нийгмийн ажил, үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэхэд ажилд чухал хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Хүндэтгэсэн,

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
ГЭР БҮЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА Н.БАЯРМАА

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Энэхүү гарын авлагыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлаг, бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, мэргэжилтнүүдийн хамтын оролцоотойгоор боловсруулсан болно.

Тус гарын авлага нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүд хүчирхийллийг даван туулж, хэвийн амьдралдаа эргэн ороход нь туслах чиглэлээр ажиллаж буй нийгмийн ажилтнууд, сэтгэл зүйчид, зөвлөгчдийн нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг нь чиглүүлэх зорилготой.

Уг гарын авлагыг боловсруулахдаа бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд өгөх нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөний арга зүйн талаарх олон улсын адил төстэй гарын авлага, удирдамжуудыг ашигласны сацуу манай практикт түгээмэл тохиолддог хүүхдийн бэлгийн хүчирхийллийн ээдрээтэй асуудлуудад хариу өгөхөд чиглэсэн мэргэжлийн хүмүүсийн зөвлөмж, санаа оноог аль болох оруулахыг зорьсон.

Гарын авлага нь 7 бүлэгтэй. Эхний гурван бүлэгт бэлгийн хүчирхийлэл ба хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөний талаар зөвлөгчдийн зайлшгүй мэдвэл зохих үндсэн мэдээллийг оруулсан.

Дараагийн дөрвөн бүлэгт бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд өгөх нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөний арга зүйн асуудлууд багтсан. Ингэхдээ зөвлөгч практик үйл ажиллагаандаа хэрэглэхэд аль болох дөхөм байх үүднээс зөвлөгөөний арга зүйг нийтлэг байдлаар танилцуулахын зэрэгцээ хүүхдийн насны онцлогоор, мөн бэлгийн хүчирхийллийн өвөрмөц хэлбэрүүдийн үед ямар арга барил хэрэглэхийг тус тусад нь танилцуулсан болно.

Эцэст нь бусад үйлчилгээнд холбон зуучлахад хохирогчид болон тэдний гэр бүлийн гишүүдэд өгөх шаардлагатай мэдээлэл зөвлөгөө орсон байгаа. Нэмэлтээр ашиглах гол эрх зүйн баримт бичгүүдийн товч лавлагааг мөн хавсралтад оруулсан.

Энэхүү гарын авлага нь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдийн нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөний талаарх мэдлэг, ур чадварыг сайжруулах, зөвлөгөө өгөх үйлчилгээний чанар, үр дүнг дээшлүүлэхэд зохих хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.



НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Тус гарын авлагад хэрэглэсэн хүүхдийн бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой доорх нэр томьёог дараах байдлаар ойлгоно:

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж “Санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг хэлнэ.”¹

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл гэж “Тухайн хүү эсхүл охины хувьд бүрэн ойлгохгүй, хараахан төлөвшөөгүй тул мэдээлэлд суурилсан зөвшөөрөл өгч чадахгүй, эсвэл хууль тогтоомж, нийгмийн ёс суртахууныг зөрчсөн аливаа бэлгийн үйл ажиллагаанд хүүхдийг татан оролцуулахыг хэлнэ” (Дэлхийн эрүүл мэндийн байгууллага)

Хүүхдийн бие махбодын хүчирхийлэл гэдэг нь хүч хэрэглэн хүүхдийн биед халдаж, түүнд бие махбодын гэмтэл учруулах үйлдэл юм. Үүнд хүүхдийг түлхэх, цохих, алгадах, сэгсрэх, шидлэх, өшиглөх, хазах, түлэх, хоолойг нь боомилох, хордуулах зэрэг үйлдлүүд орно (AVI 2021).

Хүүхдийн сэтгэл санааны хүчирхийлэл гэж “Хүүхдийн сэтгэл санаанд сөргөөр нөлөөлсөн хандлага, зан үйл болоод хүүхдээ асран халамжлах, хамгаалах үүргээ биелүүлээгүй үйлдлийг хүүхдэд үзүүлж байгаа сэтгэл санааны дарамтыг ойлгоно”².

Ураг төрлийн хүчин (incest) гэдгийг гэр бүлийн харилцаа хамаарал бүхий насанд хүрсэн хүн, эсвэл насаар том хүүхэд бэлгийн дур хүслээ хангах үүднээс хүүхдийн эсрэг хийж буй бэлгийн гэмт үйлдэл гэж ойлгоно.

Хүүхдийн мөлжлөг гэдэгт хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрхшээлдээ байлгах, хянаж цагдах, өөрийн үгээр байлгах, хүүхдийн мөлжлөг хүчирхийлэлтэй холбоотой материалыг бусдад дамжуулан өгөх, хадгалах, өөр бусад хүнийг дээрх үйлдэл хийхийг албадах, цахимаар болон бусад хэлбэрээр хүүхдийг хууран мэхлэх, ашиг олох зорилгоор хүүхдийг мөлжих, хөдөлмөр эрхлүүлэх, бэлгийн дур хүслээ хангах, хувийн эсвэл санхүүгийн ашиг олох зорилгоор хүүхдийг ашиглах, орчин цагийн боолчлол, хүний наймаа, зэвсэгт мөргөлдөөнд оролцуулах зэрэг тооцогддог (AVI 2021).

Хүүхдийн бэлгийн мөлжлөг гэдгийг ашиг олох зорилгоор бэлгийн харилцаанд албадан оруулж, биеийг нь үнэлүүлэхийг ойлгоно.

Хүүхдийн биеийг үнэлэх гэж “Шан харамж буюу бусад аливаа төлбөрийн хэлбэрээр хүүхдийг бэлгийн харилцаанд ашиглахыг хэлнэ”³.

Хүүхдийг худалдах гэж “Аливаа этгээд буюу бүлэг этгээд шан харамж буюу бусад аливаа төлбөр авч хүүхдийг бусад этгээд буюу бүлэг этгээдэд шилжүүлэн өгөх аливаа үйлдэл буюу хэлцлийг хэлнэ”⁴.

¹ Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай Монгол Улсын хуулийн 4 дүгээр зүйл 4.1.8

² Хүүхдийг ивээх сан, Хүүхэд хамгааллын хамтарсан баг, 2016

³ Хүүхдийн эрхийн тухай Конвенцын Нэмэлт протокол

⁴ Хүүхдийн эрхийн тухай Конвенцын Нэмэлт протокол

Педофил (pedophile) гэдэг нь удаан хугацааны туршид нэг юманд төвлөрсөн хурц хэв шинж бүхий, бэлгийн бойжилт нь гүйцээгүй хүүхэдтэй холбоотой сексийн талаарх бодол, төсөөлөл, хүсэл, зан байдал бүхий сексийн мэдрэмжийг илэрхийлнэ⁵.

⁵ ДЭМБ-ын Олон улсын өвчний ангилал ICD-11



БҮЛЭГ 1. БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, зөвлөгч нар (цаашид “Зөвлөгч” гэх) нь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм-сэтгэл зүйн чанартай зөвлөгөө өгөхийн тулд юуны өмнө бэлгийн хүчирхийллийн талаар үндсэн мэдлэгтэй, зөв үзэл хандлагатай байх шаардлагатай. Иймд энэ бүлэгт бид бэлгийн хүчирхийллийн талаар Зөвлөгчийн зайлшгүй мэдвэл зохих гол мэдээллийг товч танилцуулах болно.

1.1 БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ГЭЖ ЮУГ ХЭЛЭХ ВЭ?

Бэлгийн хүчирхийллийг олон улсад болон улс орнуудад хэд хэдэн янзаар тодорхойлсон байдаг. Тухайлбал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ): “Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь хүчээр, эсвэл тэнцвэргүй байдалд, эсвэл албадлагын нөхцөлд бодитоор, заналхийлж хүч хэрэглэн хийгдсэн бэлгийн үйлдлийг хэлнэ”¹ гэж тодорхойлсон бол АПА “Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь хүчирхийлэгч нь хохирогчийн зөвшөөрөл өгч чадахгүй байдлыг өөрийн давуу тал болгосон, эсхүл заналхийлж хүч хэрэглэн, хүсээгүй бэлгийн үйлдэл хийхийг ойлгоно”² гэж тодорхойлжээ.

Манай улсад олон улсын байгууллагуудын тодорхойлолтыг голдуу хэрэглэдэг. Эрүүгийн хуульд бэлгийн хүчирхийлэл гэсэн тусгай тодорхойлолт байхгүй байгаа. Гэхдээ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай Монгол Улсын хуульд: “энэ хуулийн 3-р зүйлд заасан этгээд эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг бэлгийн хүчирхийлэл”³ гэж тодорхойлжээ.

1.2 БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ БОЛОХ НЬ

Охид, эмэгтэйчүүдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нь тэдний бэлгийн халдашгүй байдалд заналхийлсэн хүний эрхийн ноцтой зөрчил бөгөөд хүнд гэмт хэрэг юм. Бэлгийн хүчирхийлэл нь охид, эмэгтэйчүүдийн бэлгийн амьдралын болон нөхөн үржихүйн эрхийг ч мөн зөрчдөг. Иймд олон улсын гэрээ конвенцуудад болон манай улсын холбогдох эрхзүйн баримт бичгүүдэд бэлгийн хүчирхийлэл хүний эрхийн зөрчил болох талаар дараах байдлаар авч үзжээ.

Эдийн засаг, нийгэм ба соёлын эрхийн тухай Олон улсын гэрээгээр (Пакт) эмэгтэйчүүдийн эрүүл саруул байх эрхийг хамгаалсан байдаг⁴. Үүнд бие махбод, сэтгэц, нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэнд ордог байна.

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцоор (ЭЯГБХУТК)⁵ оролцогч улс орнууд охид, эмэгтэйчүүдийг худалдаалахыг хориглох үүрэг хүлээсэн. Мөн Конвенцын Ерөнхий зөвлөмжид улс орнууд Эрүүгийн хуульдаа хүчин болон бусад хүчирхийллийн хэргийг хохирогчийн биеийн болон сэтгэл санааны бүрэн бүтэн байдал, бэлгийн бие даасан байдлын эсрэг гэмт хэрэг гэж тодорхойлох ёстой бөгөөд ёс суртахуун, олон нийтийн үзэл суртал, нэр хүндийн эсрэг гэмт хэрэг

¹ https://www.who.int/docs/default-source/documents/ethics/sexual-exploitation-and-abuse-pamphlet-en.pdf?sfvrsn=409b4d89_2

² <https://www.apa.org/topics/sexual-abuse/>

³ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 6 дугаар зүйл. 6.5; Төрийн мэдээлэл, 2017 он, №5

⁴ Монгол Улс 1968 оны 01-р сарын 05-нд энэхүү гэрээнд гарын үсэг зурж, 1974 оны 11-р сарын 18-нд соёрхон баталсан. Төрийн мэдээлэл, тусгай дугаар

⁵ Монгол Улс 1980 оны 07-р сарын 10-нд энэ Конвенцод гарын үсэг зурж, 1981 оны 05-р сарын 14-нд соёрхон баталсан.

гэж харуулах ёсгүй бөгөөд хүний хүйс, жендэрийн мэдрэмж зэргээс үл хамааран хүн бүрийн эрхийг хамгаалж, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн гэмт этгээд болгоныг шийтгэх үр дүнтэй тогтолцоог эрүүгийн хуулиар бүрдүүлэх ёстой бөгөөд зарим гэмтэнг хэлтрүүлэх тохиолдол гаргах ёсгүй⁶ гэж зөвлөсөн байна.

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд (1998) хүчин, бэлгийн боолчлол, албадлагын биеэ үнэлэлт, албадлагын жирэмслэлт, албадлагын үр хөндөлт болон бусад хэлбэрийн бэлгийн хүчирхийллийг олон улсын эрх зүйд анх удаа хүн төрөлхтний эсрэг хийсэн гэмт хэрэг⁷ хэмээн авч үзсэн байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг⁸ бүлэгт хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, бэлгийн мөлжлөг, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орохыг хориглож, гэмт хэрэгт тооцож, ял шийтгэл оногдуулахаар заасан байдаг.

1.3 БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ ТОО БАРИМТ

Охид эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэж буй бэлгийн хүчирхийлэл нэмэгдэж, үйлдэгдэх хүрээ нь гэр бүлийн аюулгүй орчин руу шилжиж байгаа нь сэтгэл түгшээсээр байгаа билээ. ДЭМБ-ын мэдээллээр жил бүр 200 сая хүүхэд бэлгийн мөлжлөгийн хохирогч болдог байна. Гэвч бодит тоо үүнээс харьцангуй их бөгөөд илрэхгүй, хохирогч нь өөрөө ч мэдээгүй байх тохиолдол олон байдаг⁹.

Манай улсад жилд 700 орчим буюу өдөрт 2 бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэг бүртгэгдэж байгаа нь бидэнд харагдаж буй мөсөн уулын зөвхөн орой нь л юм. Монгол Улсын Үндэсний Статистикийн Газраас 2017 онд хийсэн жендэрт суурилсан хүчирхийллийн үндэсний судалгаагаар манай улсын 10 эмэгтэй тутмын нэг нь 15 нас хүрэхээсээ өмнө бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан гэж мэдүүлсэн байна¹⁰. 2016 онд хийсэн “Хүүхдийн эрх ба хамгаалал” үндэсний судалгаагаар 10 хүүхэд тутмын 8 нь ямар нэг байдлаар хүчирхийлэлд өртсөн, түүнээс 2 хүүхэд тутмын нэг нь бие махбодын хүчирхийлэлд, 4 хүүхэд тутмын гурав нь сэтгэл санааны хүчирхийлэлд, 3 хүүхэд тутмын нэг нь үл хайхрах хүчирхийлэлд, 8 хүүхэд тутмын нэг нь бэлгийн шинжтэй дарамт, халдлагад өртдөг ажээ¹¹. Давтамжийн хувьд хүүхдүүд бие махбодын хүчирхийлэлд хамгийн их өртдөг бөгөөд энэ нь ихэвчлэн гэр бүл, сургуулийн орчинд гардаг байна.

2019-2021 онд цагдаагийн байгууллагад хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг 1655 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан байна. Эдгээр гэмт хэргийн хохирогчдын 80 орчим хувь нь 10-29 насны охид, залуу эмэгтэйчүүд; 47% нь 8-17 насны охид байсан бөгөөд насанд хүрээгүй хохирогчдын 87 хувийг ерөнхий боловсролын сургуулийн сурагчид эзэлж байна¹².

⁶ https://www.amnesty.mn/images/2020/09/huchinduulehees_angid_bh_erh.pdf

⁷ Монгол Улс Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрмийг 1998 оны 07-р сарын 18-ны өдөр баталж, 2002 оны 07-р сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Төрийн мэдээлэл, тусгай дугаар 2005 он.

⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawld=11634>, Монгол Улсын Эрүүгийн хууль, 12-р бүлэг

⁹ <https://gia.gov.mn/12/item/709>

¹⁰ Үндэсний статистикийн газар, НҮБ-ын Хүн амын сан, Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгааны тайлан, 2017

¹¹ Хүний эрхийн үндэсний комисс, Гүүд Нэйброс олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар. “Хүүхдийн эрх ба хамгаалал” үндэсний судалгаа, 2016

¹² Хүний эрхийн үндэсний комисс, Гүүд Нэйброс олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар. “Хүүхдийн эрх ба хамгаалал” үндэсний судалгаа, 2016



Цаашилбал, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн мэдээгээр бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн улмаас тус хүрээлэнгээр шинжилгээ хийлгэгчдийн 46% буюу 881 нь 0-19 насны хүртэлх насны хүүхдүүд байна¹³.

Бэлгийн хүчирхийллийг ихэнх хүмүүс гудамж, харанхуй булан тохой, орц, хонгилд үл таних этгээд, шөнө оройн цагаар үйлддэг гэж боддог ч үнэн хэрэгтээ цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бэлгийн хүчирхийллийн 3 хэрэг тутмын 2 нь гэр орон сууцанд (66%), 8.5% нь гудамж талбайд үйлдэгдсэн, хүчингийн гэмт хэрэг үйлдэгчдийн 4 хүн тутмын 3 нь таньж мэддэг эсвэл ойр дотны садан төрлийн хүмүүс байсан байна.

Бэлгийн хүчирхийлэл үйлдэгдэх тодорхой газар гэж байхгүй бөгөөд насны хязгааргүйгээр, гэр бүлд, олон нийтийн газарт, ажил дээр, боловсрол, эмнэлгийн байгууллагад, зэвсэгт мөргөлдөөний үед болон ямар ч цаг үе, газарт гарч болзошгүй.

Дээрх цөөн тоо баримтаас харахад охид эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, түүний дотор хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл манай нийгмийн сэтгэл түгшээсэн тулгамдсан асуудал болох нь тодорхой харагдаж байна.

1.4 БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТӨРЛҮҮД

Бэлгийн хүчирхийлэл гэдэг ойлголтод дор бүрдээ онцлогтой бэлгийн хүчирхийллийн олон хэлбэр багтдаг¹⁴:

- Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл
- Бэлгийн мөлжлөг (хүний наймаа болон хүчээр биеийг нь үнэлүүлэх, бэлгийн харьцааны шинжтэй үйлдлийг хүчээр хийлгэх)
- Бэлгийн гаж зан үйл (хүүхэд болон насанд хүрсэн хүнийг нүцгэлэх эсвэл бусдын бэлгийн ажил хийхийг харж таашаал авах ... гэх мэт)
- Садар самууныг сурталчилсан бүтээгдэхүүн эсвэл бичлэгт хүчээр оролцуулах
- Бэлгийн дарамт
- Бэлгийн халдлага
- Хүчин - (гэнэтийн хүчин, итгэл төрүүлсэн хүчин, ураг төрлийн хүчин, бүлэглэн үйлдэх хүчин, болзооны хүчин, ижил хүйстний хүчин, ёс заншлын хүчин, шорон дахь хүчин...гэх мэт)
- Цахим бэлгийн хүчирхийлэл (цахим зурвасаар илрэх бэлгийн хүчирхийлэл, хүүхдийг цахим бэлгийн мөлжлөгт ашиглах гэх мэт)

Бэлгийн хүчирхийллийн дээрх хэлбэрүүдийн дотроос манай нийгмийн өдөр тутмын амьдралд тохиолдсоор байгаа бэлгийн хүчирхийллийн хамгийн ноцтой хэлбэр болох ураг төрлийн хүчингийн талаар болон орчин үед хурдацтай өсөж буй цахим бэлгийн хүчирхийллийн талаар товч танилцуулъя (Хүүхдийн эсрэг хүчирхийллийн эдгээр хэлбэрүүдийг дараагийн бүлэгт илүү дэлгэрэнгүй авч үзнэ).

1.4.1 Ураг төрлийн хүчин (incest)

Ураг төрлийн хүчин нь гэдэг нь хохирогчтой цусан болон ойрын төрөл садангийн холбоотой хэн нэгэн этгээд түүнийг эрхшээлдээ оруулах зорилгоор эрх мэдэл, давуу байдлаа ашиглан, гэр бүлийн ариун журамт ёс, хайр хүндэтгэл итгэлийг эвдэж, хүний халдашгүй дархан байдал, эрх чөлөөг зөрчиж, бэлгийн харилцаанд оруулахаар завдсан, оруулсан, садар самууны шинжтэй бусад үйлдэлд уруу татсан шаардсан гэмт хэргийг

¹³ ЭМЯ, Глобал сан, ХТЭТ. "Хүчирхийллийн нөлөөгөөр охид, эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөлтийн байдлыг үнэлэх" судалгааны тайлан, 2018

¹⁴ file:///C:/Users/user/Downloads/friends_and_family_guide_final-1%20(1).pdf

хэлдэг¹⁵. Энэ гэмт хэргийн хохирогч нь ихэвчлэн насанд хүрээгүй хүүхэд байдаг.

Ураг төрлийн хүчин бол ойр дотных нь хүмүүс итгэлийг нь эвдэж бэлгийн дур хүслээ ханган ашигласнаас хохирогчийн амьдрал, өөрийгөө үнэлэх үнэлэмжийг устгадаг хамгийн гутамшигт гэмт хэрэг юм.

1.4.2 Цахим бэлгийн хүчирхийлэл

Цахим технологи хурдацтай хөгжихийн хэрээр цахим гэмт хэрэг дэлхий дахинд улам бүр анхаарал татаж байна. Цахим гэмт хэргийн дотор цахим бэлгийн хүчирхийлэл томоохон хувийг эзэлдэг ба хохирогч нь ихэнхдээ охид, эмэгтэйчүүд байдаг.

Цахим бэлгийн хүчирхийлэл нь тухайн хүний хувийн нууц, бэлгийн амьдралтай холбоотой зураг, бичлэг гэх зэргийг хуурч мэхлэх, итгэлийг нь олох, айлган сүрдүүлэх, хулгайлах, хүсээгүй зүйлээр нь барьцаалах зэрэг аргаар олж аван олон нийтийн цахим сүлжээнд нийтлэх, нийтлэхээр сүрдүүлэн бэлгийн хүчирхийллийн хохирогч болгох зэргээр хохирол учруулдаг олон сөрөг үр дагавартай гэмт хэрэг юм.

Цахим бэлгийн хүчирхийлэл нь цахим дарамт, цахим зурвасаар илрэх бэлгийн хүчирхийлэл буюу секстинг (sexting), хүүхэдтэй бэлгийн хүчирхийллийн зорилгоор холбоо тогтоох (grooming) гэх мэт олон хэлбэрээр илэрдэг (Хүүхдэд тохиолддог эдгээр хэлбэрүүдийн онцлогийг дараагийн бүлгээс харна уу).

Цахим дарамт гэдэг нь хүний гадаад, дотоод харагдах байдал, хүйс, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, хөгжлийн бэрхшээл, өөрийгөө илэрхийлсэн зэргээр нь бусдыг цахим орчинд заналхийлэх, айлгах, дарамтлах, дорд үзэх гэмт үйлдэл юм.

Цахим дарамтлагч нь хохирогчийг 24 цагийн турш байршил үл хамааран дарамтлах боломжтой байдаг ба дарамтлагчаас ирсэн сөрөг сэтгэгдэл, сөрөг мэдээлэл нь олон нийтийн сүлжээнд хадгалагдаж, хохирогч түүнийг давтан харах, давтан хүлээж авах эрсдэлтэй байдгаараа бусад төрлийн дарамт шахалтаас илүү сэтгэл зүйн хор хохирол учруулж болдог. Хохирогчийн тухай сөрөг мэдээллийг бусадтай хуваалцах байдлаар цааш хэдэн зуу, хэдэн мянган хүнд түгээснээс бүрэн устгах боломжгүй гэж боддогоос хохирогч нь хэзээ ч тухайн дарамтаас гарч чадахгүй мэт санагдаж, итгэл найдвараа алдахад хүргэдэг байна¹⁶.

¹⁵ <https://www.psychiatrictimes.com/sexual-of-fenses/ramifications-incest>

¹⁶ ХЭК 1990



БҮЛЭГ 2. ХҮҮХДИЙН ЭСРЭГ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Өмнөх бүлэгт бид бэлгийн хүчирхийллийн талаар ерөнхий ойлголт өгсөн бол энэ бүлэгт хүүхдийн эсрэг үйлдэгддэг бэлгийн хүчирхийллийн (цаашид “хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл/хүүхдийн бэлгийн хүчирхийлэл” гэх) онцлогийг авч үзэх болно. Тухайлбал, энэ асуудлыг хэрхэн ойлгох, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн талаар олон улсын болон манай улсын холбогдох хуулиудад хэрхэн тусгасан байдаг, ямар хэлбэрүүд болон шинжээр илэрдэг, хүүхдийн ураг төрлийн хүчирхийлэл, цахим хүчирхийлэл, тэдгээрийн хор хөнөөл нь юу болох, хүүхдийн хүчирхийллийн талаар ямар буруу ташаа ойлголтууд байдаг зэрэг үндсэн мэдээллийг танилцуулах болно.

2.1 ХҮҮХДИЙН ЭСРЭГ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ГЭЖ ЮУГ ХЭЛЭХ ВЭ?

Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.8-т Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж *“санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамтыг ойлгоно”*¹⁷ гэж тодорхойлсон байна.

Тэгвэл хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл гэдгийг *“тухайн хүү эсхүл охины хувьд бүрэн ойлгохгүй, хараахан төлөвшөөгүй тул мэдээлэлд суурилсан зөвшөөрөл өгч чадахгүй, эсхүл хууль тогтоомж, нийгмийн ёс суртахууныг зөрчсөн аливаа бэлгийн үйл ажиллагаанд хүүхдийг татан оролцуулах явдал юм гээд хүүхдийн бэлгийн хүчирхийлэл нь бусад этгээдийн дур сонирхлыг хангахад чиглэсэн, хүүхэд ба насанд хүрэгч этгээд эсхүл нас, хөгжлийн хувьд хариуцлага хүлээх бусад хүүхдийн хооронд үүсэх харилцаа юм гэж ДЭМБ-аас тодорхойлжээ.*

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нь хүүхэд, ялангуяа охидыг хүйсээр ялгаварлан гадуурхаж, бэлгийн дур хүслээ хангах хэрэгсэл мэт дорд үзэх үзэл хандлагаас үүдэн гардаг. Нөгөө талаас хүүхдийн гэнэн, өөрийгөө хамгаалах чадвар, мэдлэг дутмаг байдлыг далимдуулж хууран мэхлэх, итгэл эвдэх, төөрөлдүүлэх, айлган сүрдүүлэх замаар үйлдэгддэг тэдний аюулгүй, халдашгүй байдал, эрүүл мэнд, бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг нь зөрчиж буй хүнд гэмт хэрэг юм.

Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчид нь бэлгийн хүчирхийллийн асуудлыг бүрэн ойлгоогүй, зөвшөөрөл өгөх боломжгүй, бие, сэтгэлзүйн хөгжлийн хувьд бэлтгэлгүй, бэлгийн харьцааны талаар бүрэн ойлголтгүй хүүхдүүдийг энэ гэмт хэргийн хохирогч болгодог. Тэд бэлгийн хүчирхийлэл үйлдэхийн зэрэгцээ хүүхдийн сэтгэл зүйн хүчирхийлэл болон бие махбодын хүчирхийллийг давхар үйлддэг (тодорхойлолтыг нэр томъёоны тайлбараас харна уу).

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нь нэг удаагийн тохиолдол байхаас эхлэн хэдэн сараас хэдэн жил үргэлжлэх олон удаагийн үйлдэл байдаг.

¹⁷ Хүүхдийн хамгааллын тухай хууль, Төрийн мэдээлэл, 2016, №9

2.2 ХҮҮХЭД ХҮЧИРХИЙЛЛЭЭС АНГИД БАЙХ ХАЛДАШГҮЙ ЭРХТЭЙ БОЛОХ НЬ

Бэлгийн хүчирхийлэл нь хүний эрхийн зөрчил болох талаар олон улсын гэрээ Конвенц болон Монгол Улсын холбогдох хуулиудад хэрхэн тусгасан талаар бид өмнөх бүлэгт товч танилцуулсан. Тэгвэл энэ хэсэгт хүүхэд бэлгийн хүчирхийллээс ангид байх, хамгаалуулах, шаардлагатай тусламж үйлчилгээг авах эрхийн асуудлыг олон улсын болон манай улсын эрхзүйн баримт бичгүүдэд хэрхэн тусгасан байдгийг тусгайлан авч үзье.

Хүүхдийн эрхийн тухай Конвенцод¹⁸ хүүхэд амьд явах, хөгжих, хамгаалуулах, оролцох гэсэн 4 суурь эрхийг эдлэх эрхтэй гэж заасан. Мөн тус Конвенцоор хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэх, хүүхдийг мөлжлөгт ашиглахыг хориглосон. Тухайлбал, (a) хүүхдийг бэлгийн хууль бус аливаа ажиллагаанд татан оролцуулах, шахалт үзүүлэх; (b) хүүхдийн биеийг үнэлүүлэх, бэлгийн хууль бус бусад ажиллагаанд ашиглан мөлжих; (c) хүүхдийг садар самуун үзүүлбэр, түүнийг сурталчилсан материалд ашиглахыг хориглоно гэж тодорхой заажээ. Тус Конвенцын 34 дүгээр зүйлд төрөөс хүүхдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалах үүргийг тусгайлан заасан байдаг.

Хүүхдийн эрхийн тухай Конвенцын Нэмэлт протокол. 2000 онд баталсан нэмэлт протоколоор хүүхдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалах эрх зүйн хамгаалалтыг улам бэхжүүлж, эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах эрх зүйн баримт бичгийг баталсан юм.

ЭЯГБХУТК-оор¹⁹ оролцогч улс орнууд охид, эмэгтэйчүүдийг худалдаалахыг хориглох үүрэг хүлээсэн. Тус **Конвенцын нэмэлтээр** "... эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авах үүрэг хүлээлгэсэн байдаг."²⁰

Ланзаротын Конвенц²¹: Хүүхдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалахад тусгайлан зориулсан энэхүү бүс нутгийн анхны баримт бичиг нь Испанийн Ланзароте хотод 2007 онд батлагдаж, Европын Зөвлөлийн бүх гишүүн орнууд гарын үсэг зурснаар 2010 онд хүчин төгөлдөр болсон. Энэ Конвенцыг дэлхийн хэмжээнд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг зөвхөн газар зүйн тодорхой бүсээр хязгаарлах ёсгүй гэсэн ойлголттойгоор боловсруулсан тул дэлхийн аль ч улс нэгдэн ороход нээлттэй байдаг. Тус Конвенцын гол цөм нь хүүхдийг хамгаалах асуудал юм. Тус Конвенцод улс орнууд хүүхдэд үйлдэгддэг бэлгийн хүчирхийллийн эсрэг "4Р арга барил"-аар буюу урьдчилан сэргийлэх, хамгаалах, мөрдөн шалгах, үндэсний болон олон улсын хамтын ажиллагааг дэмжих замаар цогц хариу арга хэмжээ авах шаардлага тавьсан юм.

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 2 дугаар бүлэгт хүүхдийн эрхийг Хүүхдийн эрхийн Конвенцын нэгэн адилаар хуульчилж өгсөн²². Тус хуулийн 7 дугаар зүйлийн нэгдэх хэсэгт (7.1) "Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй" гэж заажээ.

¹⁸ Монгол Улс нь Хүүхдийн эрхийн тухай Конвенцыг 1989 оны 11-р сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 09-р сарын 02-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

¹⁹ Монгол Улс уг Конвенцод 1980 оны 07-р сарын 10-нд гарын үсэг зурж, 1981 оны 05-р сарын 14-нд соёрхон баталсан.

²⁰ <https://mfa.gov.mn/documentation/55446>, ЭАБХУТК-ын 20.1 дэх хэсэгт оруулах нэмэлт өөрчлөлт, 1995.12.22-ны өдөр баталсан

²¹ <https://www.coe.int/en/web/children/lanzarote-convention>

²² Хүүхдийн эрхийн тухай хууль, Төрийн мэдээлэл, 2016, №9



Монгол Улсын Эрүүгийн хуулийн “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”²³ бүлэгт хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, бэлгийн мөлжлөг, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орохыг хориглож, гэмт хэрэгт тооцож, ял шийтгэл оногдуулахаар заасан байдаг.

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн талаарх эдгээр болон бусад эрх зүйн зохицуулалт нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх сэргийлэх үйл ажиллагааны үндэс болдог.

2.3 ХҮҮХДИЙН ЭСРЭГ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ДИНАМИК²⁴

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг нийгмийн өвөрмөц үзэгдэл гэж ДЭМБ үздэг. Бэлгийн хүчирхийллийн динамик байдал нь насанд хүрэгчдийн бэлгийн хүчирхийллээс ялгаатай тул хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг насанд хүрэгчдийнхтэй адил арга замаар шийдвэрлэх боломжгүй. Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн **ДИНАМИКИЙН ОНЦЛОГ** нь:

- Бие махбодын хүч, харгислал ховор хэрэглэнэ. Хүчирхийлэгч нь хүүхдийг хуурч шан харамж өгөх, эсвэл айлган сүрдүүлж хүүхдийн итгэлийг алдуулж, бэлгийн хүчирхийллийг нуухыг хичээдэг.
- Хүчирхийлэгч нь ихэнхдээ хүүхдийн сайн мэддэг, итгэл даасан асран хамгаалагч нь байдаг. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн судалгаанаас үзэхэд хүчирхийлэл үйлдэгчдийн 85% нь хохирогч хүүхдүүдийн гэр бүлийн гишүүн, хамаатан садан, танил хүмүүс байсан байна.²⁵
- Ураг төрлийн хүчирхийлэл буюу гэр бүлийн хамаарал бүхий хүмүүсийн хоорондын бэлгийн хүчирхийлэл нь хүүхдийн бэлгийн хүчирхийллийн гуравны нэг хувийг эзэлдэг байна.
- Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нь хэдэн долоо хоногоор, эсвэл олон жилээр ч үргэлжилсэн байдаг. Хохирогчдын 30% нь 3-7 жилийн хугацаанд урт удаан хугацааны бэлгийн хүчирхийлэлд өртсөөр байсан тоо баримт байгаа.
- Хохирогч хүүхдүүдийн 26% нь бэлгийн хүчирхийлэлд давтан өртсөн байна. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нь удаа дараа давтагдах тусам улам төвөгтэй хэцүү болдог онцлогтой.

2.4 ХҮҮХДИЙН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ИЛРЭХ ХЭЛБЭРҮҮД, ТҮГЭЭМЭЛ ШИНЖҮҮД

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг зөвхөн хүчиндэх гэмт хэрэг гэж ойлгох нь буруу юм. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нь энгийн мэт харагдах “томчуудын” +18 сэдэвтэй элдэв зүйл ярих, шалиг үг ярих өдөх, хүүхдийг нүцгэн байхад нь харах зэргээс эхлээд хүүхдийн биеийн бэлгийн хэсгүүдэд бэлгийн сэдэлтэйгээр хүрэх, бэлгийн харьцаанд орох зэрэг маш олон хэлбэрээр илэрдэг. Иймд хүүхдийн бэлгийн хүчирхийллийг “**ҮЛ**

²³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11634>, Монгол Улсын Эрүүгийн хууль, 12-р бүлэг

²⁴ https://www.who.int/docs/default-source/documents/ethics/sexual-exploitation-and-abuse-pamphlet-en.pdf?sfvrsn=409b4d89_2

²⁵ <http://www.prokuror.mn/a/2165>

“ХҮРЭЛЦЭХ” болон “ХҮРЭЛЦЭХ” гэсэн үндсэн хоёр хэлбэрт ангилдаг²⁶.

Үл хүрэлцэх хэлбэрүүд	Хүрэлцэх хэлбэрүүд
<ul style="list-style-type: none"> • Хүүхдийг ямар ч шалтгаангүйгээр илт өдөж, сонжсон харц шидэх, эрээ цээргүй ширтэх, • Шалиг үг яриа өдөж, доромжлох • Өөрийн болон бусдын нүцгэн, садар самуун зураг, бичлэг явуулах, үзүүлэх, туршиж үзэхийг санал болгох, бэлэг эрхтнээ харуулах, • Хүүхдийг нүцгэнээр буюу бэлгийн хавьтал үйлдэж буй видео бичлэг хийх, фото зураг авах (порнографт ашиглах), • Хүүхдийг нүцгэн унтаж байхад нь зорилготойгоор харах, • Усанд орж байхад нь нууцаар харах, • Хувцас тайлуулах тоглоом тоглох, • Цахимаар нүцгэн, биеийн нууц хэсгүүдийг ил гаргасан зураг бичлэгийг явуулахыг хүсэх, шаардах, нууцаар авах, • Цахим бэлгийн мөлжлөгт өртүүлэх. 	<ul style="list-style-type: none"> • Үнсэх, озох, • Хүүхдийн биеийн нууцлаг хэсгүүдэд хувцасны гадна, дотроос хүрэх, • Хүүхдийн нууцлаг газруудыг илж таалах, • Хувцасны гадна болон дотроос бэлэг эрхтэн, хөх, бөгс зэрэг нууцлаг хэсгүүдээ бариулах, оролдуулах, • Өөрийн бэлэг эрхтэн, өгзгөөр хүүхдийн хувцасны гадна талаас хүргэх, шүргэх, • Янз бүрээр бэлгийн хавьтал хийхийг шаардах, эдгээрийг үйлдэх, • Хүчиндэх, • Бэлгийн харилцааны шинжтэй хамааралтай, хамааралгүй зураг, үйлдлүүдийг эвлүүлж цахимаар зураг, бичлэгийг тараах, • Цахим зураг, бичлэгээр сүрдүүлэн өөртэйгээ уулзахыг шаардах, хуурамч зураг, бичлэг ашиглан уулзаж бэлгийн хүчирхийлэлд өртүүлэх.

ТЭВРЭХ, БИЕ БИЕДЭЭ ХҮРЭХ зэрэг нь тухайн хүндээ эерэг сэтгэгдэл төрүүлж, нөхөрлөл, багийн харилцаа, хайр, анхаарлыг илэрхийлдэг тул таатай, сэтгэл хангалуун байдал бий болгодог. Харин бэлгийн таашаал, ханамж авахын тулд хүүхдэд энэ үйлдлүүдийг ашиглах нь гэмт үйлдэл болно. Тухайлбал, зорилготойгоор хүүхдийн хориотой хэсгүүдийг энхрийлэн таалах, хүүхдийн бэлэг эрхтэнг гараар болон амаар оролдох, эрхлүүлэх үедээ биеийн далд хэсгүүдэд хүрэх, ёс зүйд үл нийцэх гэрэл зураг, порно зургуудыг хүүхдэд үзүүлэх зэргээр хүч үл хэрэглэх үйлдлүүд, эсвэл хүч хэрэглэн бэлгийн харьцаанд оруулах, хүчиндэх, бандидах зэрэг.

Тухайн хүүхэд томчуудын дээрх үйлдлүүдэд зөвшөөрсөн буюу дургүйцсэн дүрийн алийг ч харуулж болно. Гэвч энэ нь чухал биш. Яагаад гэвэл хүүхэд наанаа эсэргүүцээгүй, зөвшөөрсөн мэт байдалтай байгаа нь уг үйлдлийн хор уршгийг бүрэн ухамсарлаж, нөхцөл байдлыг зөвөөр үнэлж, дүгнэх чадваргүй байдагтай холбоотой. Мөн нөгөө талаас хүүхдэд томчуудын хэлсэн үг, хийж байгаа үйлдэл бүхэн зөв гэж ойлгуулсан байдгаас ийм үйлдлүүдийг буруу зүйл гэж ойлгодоггүй. Хэрэв өөрт нь таагүй санагдвал аль болох холхон байхыг эрмэлзэж, зугтах оролдлого хийдэг ч энэ хариу үйлдэл нь тэр болгон амжилттай болдоггүй. Ихэнх тохиолдолд хүүхэд энэ үйлдэлд хэрхэн дургүй байгаагаа илэрхийлэх, хэнд, яаж хэлэх тухай мэдлэггүй байдал нь нөлөөлдөг.

ПРАКТИК ЗӨВЛӨМЖ

- Хүүхдэд бага наснаас нь биеийн нууц хэсгүүдийн талаар болон таатай ба таагүй хүрэлтүүдийн учир утгыг хэлж ойлгуулахын чухлыг;
- Хэрвээ хэн нэгэн хүүхдийг тань тэврэх, хүрэх болон бусад байдлаар хүүхдэд таагүй, муухай санагдахаар үйлдэл хийхийг завдсан, оролдсон, хийсэн бол тэр тухайгаа заавал эцэг эх, ойр дотныхоо хүнд хэлж байхыг хүүхдэдээ зааж сургахыг эцэг эхчүүдэд зөвлөж байх нь энэ төрлийн бэлгийн хүчирхийллийг таслан зогсоход чухал.

²⁶ ЭМЯ, БСШУЯ, НҮБ-ын Хүн амын сан. “Бэлгийн боловсрол 1” гарын авлага, Улаанбаатар хот, 113-р хуудас.



Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд ажиглагддаг түгээмэл шинжүүд

Хохирогч хүүхдийн нас, сэтгэл зүйн байдал, өөрийгөө илэрхийлэх чадвар, бэлгийн хүчирхийллийн ямар хэлбэрт өртсөн, хүчирхийлэл хэр удаан хугацаанд үйлдэгдсэн, дарамт шахалт, гэр бүлийн нөхцөл байдал зэргээс шалтгаалан хохирогч хүүхэд бүр адилхан сэтгэл хөдлөл, хариу үйлдэл үзүүлдэггүй. Зарим хүүхэд илт мэдэгдэхүйц шинж тэмдэг илрэхгүй байх нь элбэг бөгөөд тэдний хувьд яг юу болоод байгааг ойлгож ухаараагүй байх нь бий. Гэхдээ бэлгийн хүчирхийлэлд өртсөний дараа хохирогч хүүхдэд доорх шинжүүд түгээмэл ажиглагддаг. Үүнд:

- Багтрах, хэт сандрах, уймрах, салгалах, унах, татах
- Байнгын айдас, түгшүүр, сэтгэл зүйн хэт хөөрөл, тайвшрах чадваргүй байх
- Хүмүүст итгэх итгэл алдрах, эсвэл хүмүүстэй хэт задгай харилцах
- Хүчирхийллийн тухай бодлыг зайлуулах, өөрөөсөө холдуулах, мартахыг хичээх
- Шөнө хар дарж зүүдлэх, нойргүйдэх
- Харанхуйгаас айх
- Байнга уцаарлах, уурлах, зожгирох
- Ганцаараа байхыг илүүд үзэх
- Бүх зүйл дээр сөрөг хандлагатай болж зовлон бэрхшээл тоочих
- Өөртөө итгэлгүй, сул дорой болох
- Сэтгэлээр унах, ямар нэгэн юм нууцлах
- Хэн нэгний эсвэл өөрийнхөө тухай учир нь үл мэдэгдэх зүйл ярих
- Найзад хэцүү зүйл тохиолдсон гэж бусдаас туслалцаа хайж эхлэх
- Мансууруулах бодис хэрэглэх
- Утга учиргүй олон хувцас давхарлан өмсдөг болох
- Хэт их идэх дуршилтай эсхүл огт хоол идэх дур хүсэлгүй болох
- Бэлгийн харьцааны талаар насандаа тохирохооргүй их мэдлэгтэй болох
- Зарим тохиолдолд бэлгийн харилцааны хэт их сонирхолтой болох
- Эсвэл эрэгтэй хүнийг үзэн ядах хандлага илрэх
- Амиа хорлох оролдлого хийх гэх мэт.

2.5 ХҮҮХДИЙН УРАГ ТӨРЛИЙН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Харамсалтай нь бэлгийн хүчирхийллийн хамгийн гутамшигтай ноцтой хэлбэр болох хүүхдийн ураг төрлийн хүчингийн гэмт хэрэг манай өдөр тутмын амьдралд тохиолдсоор байгаа нь гашуун үнэн билээ. Охидын хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг “Гүнж төв” Төрийн бус байгууллагаас бэлгийн хүчирхийллийн хохирогч охидын дунд хийсэн судалгаагаар тэдний 57% нь ураг төрлийн бэлгийн хүчирхийллийн, 30% нь болзооны хүчингийн, 14% нь гудамж талбайн хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон байна. Ураг төрлийн бэлгийн хүчирхийлэл үйлдэгчдийн 57% нь хойд эцэг, 24% нь төрөл садангийн холбоотой хүмүүс, 14% нь төрсөн эцэг, 5 орчим хувь нь төрсөн ах нь байжээ²⁷.

Хүүхдийн ураг төрлийн хүчин гэдэгт гэр бүлийн харилцаа хамаарал бүхий насанд хүрсэн хүн, эсвэл насаар арай том хүүхэд бэлгийн дур хүслээ хангах үүднээс хүүхдийн эсрэг хийж буй бэлгийн гэмт үйлдлийг ойлгоно. Энэ нь хүн хоорондын харилцаа, ялангуяа

²⁷ ХТЭТ. “Бэлгийн хүчирхийлэл” Гарын авлага, Улаанбаатар, 2019

гэр бүлийн харилцааны итгэлийг эвддэг, хүний халдашгүй байдлыг зөрчсөн жигшүүрт халдлага юм.

Хүүхдийн ураг төрлийн хүчин нь хохирогчийн хүүхэд насных нь хамгийн эмзэг, ичгүүртэй, хар толбо болон үлдэж, ирээдүйн амьдралд нь арилшгүй хортой ул мөр үлдээдэг бөгөөд асар их хор нөлөө үзүүлдэг. Тэдгээрийн заримаас дурдвал:

- Ураг төрлийн холбоотой хүний үйлдсэн бэлгийн хүчирхийлэл нь хүүхдэд бусад төрлийн хүчирхийллээс илүү айдас, ичгүүр, доромжлолыг амсуулдаг.
- Хохирогч болсон хүүхдүүд ихэвчлэн өөрийгөө буруутгадаг. Тэд гэмт хэрэг үйлдсэн ах, эцгийгээ болон ойр дотны хүмүүсээ буруутгаж чаддаггүй.
- Тэд хүнд итгэх итгэлээ алдаж, бусдаас агшин зуур тусгаарлагддаг.
- Хохирогч бусдаас тусламж авч чадахгүй байгаадаа бухимдан, гэмт этгээдийн хэлснээр өөрийгөө хэнд ч хэрэггүй, хаягдсан, хэн ч надад тусалж чадахгүй мэтээр бодож, ганцаардал, сэтгэл гутралд автдаг.
- Дахин хэзээ ч ийм үйлдэлд орохыг хүсдэггүй ч, энэ талаар хэн нэгэнд яривал бүх хүн түүний тухай ярина гэхээс эмээж чимээгүй байхыг эрмэлздэг.
- Хохирогч болж буй явдлыг эргэн санахаас зайлсхийж, стресст орж, ирээдүйнхээ талаар гутранги бодолд автсанаар өөрийгөө хэвийн бус сэтгэл зүйтэй болсон мэтээр төсөөлдөг.
- Аюулгүй байдал, итгэл найдвараа алдах нь ихэнхдээ сэтгэл гутрал, гуниг харуусал, амьдрах итгэл үнэмшлээ алдах зэрэг бухимдлаа өөр байдлаар илэрхийлэх, амиа хорлоход ч хүргэдэг.

Зөвлөгч нь ураг төрлийн хүчингийн дээрх онцлогуудыг энэ гэмт хэргийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд зөвлөгөө өгөхдөө байнга анхаарч байх хэрэгтэй.

2.6 ХҮҮХДИЙН ЦАХИМ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Орчин үед цахим технологийн хэрэглээ өсөхийн хэрээр хүүхэд цахим бэлгийн хүчирхийллийн хохирогч болох эрсдэл улам бүр нэмэгдэж байна. Тухайлбал, Дани, Унгар, Их Британи зэрэг улсуудад хийсэн судалгаагаар нийт хүүхдийн 6% нь “хувийн” зураг, бичлэгээ алдаж, олон нийтэд тараалгуулж, цахим бэлгийн дарамт үзүүлэх хэргийн хохирогч болсон байдаг гэжээ.

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2021 онд хийсэн судалгаагаар манай улсын 13-18 насны хүүхдийн 96% нь Фейсбүүк хэрэглэдэг бөгөөд тэдгээр хүүхдүүдийн нэг өдрийн цахим хэрэглээ нь дэлхийн дундаж үзүүлэлтээс 3 дахин их буюу 237 минут байгаа дүн гарсан байна. Судалгаанд оролцогчдын 57% нь үе тэнгийнхний цахим дарамт их байдаг гэж хариулсан бол 43% хувь нь үл таних хүний цахим дарамт их байдаг гэж хариулжээ. 13-18 насны хүүхдүүд дунджаар 3-4 facebook-ийн хаягтай байгаа бөгөөд 61% нь илүү хаягаа бусадтай чатлаж, танилцахад ашигладаг гэсэн бол 36% нь эцэг эхийн хяналтгүй ашиглах зорилготойгоор хэрэглэдэг гэсэн байна. 10 хүүхдийн 7 нь таагүй байдлын улмаас хэн нэгнийг блоколж, өөрийнхөө аюулгүй байдлыг хангах зорилгоор 62% нь хэн нэгнийг хасаж байсан бөгөөд тэдний олонх нь охид байсан ажээ²⁸.

²⁸ <https://crc.gov.mn/k/3ck/6x>, Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын судалгаа, 2021, Харилцаа холбооны зохицуулах газар



Цахим орчин дахь хүүхдийн эрхийн зөрчлийн тухай судалгаагаар өсвөр насны хүүхдүүдийн 70 гаруй хувь нь өдөрт 1-2 цагийг цахим орчинд өнгөрүүлдэг ба хоёр хүүхэд тутмын нэг нь садар самууныг сурталчилсан мэдээлэлтэй тогтмол тааралддаг, 82% нь зүй бус утгатай зурвас и-мэйл, фейсбүүкийн хэрэглэгчдээс авч байсан; эцэг эхчүүдийн 95 хувьд нь энэ төрлийн сөрөг мэдээллийг шүүх программ хангамжийг ашиглах чадвар огт байхгүй, 93% нь хүүхдээ цахим дарамт, дээрэлхэлтэд өртөж байсан гэж хариулсан байна.

Хүүхдийн тусламжийн утас 108 дугаарт ирдэг дуудлагын 70% нь тусламж эрсэн дуудлага байдаг бөгөөд үүний 40% нь цахим гадуурхалтай холбоотой байдаг ажээ²⁹.

Дээрх цөөн тоо баримтаас харахад манай улсад хүүхдийн цахим хэрэглээ маш өндөр, үүнийг дагаад цахим бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл ч мөн өндөр байгаа нь илт байна. Хүүхдийн цахим бэлгийн хүчирхийлэл нь хэд хэдэн хэлбэрээр илэрдэг. Тэдгээрийн заримаас товч танилцуулъя.

2.6.1 Хүүхдийн цахим дарамт

Цахим дарамт нь 13-14 насныханд илүү түгээмэл тохиолддог ба 15 наснаас эхлэн тухайн үзэгдэл багасдаг гэсэн олон улсын судалгаа байдаг. Мөн цахим орчинд дарамтлуулснаас үүсэх сэтгэл гутрал, сэтгэлийн түгшүүр, өөртөө итгэлгүй болох, ганцаардах зэрэг сэтгэл зүйн сөрөг байдлууд бусад төрлийн гадаад хүчин зүйлсээс үүдэх сэтгэл зүйн асуудалтай харьцуулахад 2 дахин их болохыг судалгаагаар баталсан байдаг. Иймд цахим орчны дарамтад өртсөн өсвөр насныхан амиа хорлох бодол тээх, цаашлаад амиа хорлох үйлдлүүдийг бодитоор оролдох, үйлдэх өндөр эрсдэлтэй.

Хүний үндсэн хэрэгцээний нэг болох бусдаар хайрлуулах, нийгмийн нэг хэсэг байх хэрэгцээ нь өсвөр насныхныг улам ихээр цахим сүлжээнд донтуулж, эргээд тухайн хэрэгцээ хангагдахгүй байх нь цахим орчин дахь хүчирхийллийн хохирогч болж, сэтгэл гутралд автах байдлыг үүсгэдэг. Ингэснээр тухайн хүүхэд өөрийгөө бусдад хэрэггүй нэгэн, хайрлагдахгүй нэгэн хэмээн дүгнэж, бусдаас хөндийрч, зайгаа барьж эхэлдэг ба сөрөг бодол болон сөрөг сэтгэл хөдлөлийг үүсгэж ганцаардалд хүргэх өндөр эрсдэлтэй байдаг.

2.6.2 Хүүхэдтэй бэлгийн хүчирхийллийн зорилгоор холбоо тогтоох (Grooming)

Энэ гэмт үйлдлийг хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийлэлтэй холбоотойгоор “хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох донтой этгээд (пидафил) чатыг ашиглан бэлгийн хүчирхийлэл үйлдэх зорилгоор хүүхэдтэй уулзахад бэлтгэх”³⁰, эсвэл “интернэтийг ашиглан хүүхэдтэй найз болж, түүнтэй бэлгийн харьцаанд орохыг ятгах гэмт хэргийн үйлдэл”³¹ гэж тодорхойлсон байдаг.

Гэмт этгээд нь танихгүй хүн эсвэл хүүхдийн сайн мэддэг хэн нэгэн байж болно. Тэд хүүхэд, өсвөр насныхны өргөн хэрэглэдэг аппликэйшн, олон нийтийн сүлжээ, цахим хуудсуудыг ашиглан ирээдүйн хохирогчоо хайдаг ба боломжоо нэмэгдүүлэхийн тулд хэдэн зуун хүүхэдтэй цахимаар холбогддог. Хохирогчид нь дийлэнхдээ охид байдаг.

Гэмт этгээдүүд нь хүүхдүүдийг гэр бүл, найз нөхдөөс нь хөндийрүүлж, тусгаарлах, өөртөө татахын тулд сэтгэлзүйн янз бүрийн арга заль ашигладаг. Сонирхдог зүйлс, бусадтай харилцах харилцаа, гадна байдал, биеийн хэлбэр, хувцаслалт гэх мэт асуудлаар хувийн

²⁹ <https://www.mglbar.mn/news/4065>, Цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөл, эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага”, Б.Өнөрмаа, хяналтын прокурор, хуульзүйн ухааны доктор

³⁰ See Oxford British and World English Dictionary.

³¹ See Cambridge Advanced Learner’s Dictionary & Thesaurus.

мэдээлэл солилцож яриа өрнүүлэх, магтах, бэлэг сэлтээр өөртөө татахаас гадна хяналтыг гартаа авахын тулд айлган сүрдүүлэх аргуудыг хэрэглэдэг.

Гэмт хэрэгтэн хохирогч хүүхдийн итгэлийг олж, нарийн мэдээлэл олж авахын тулд нэг хүүхэдтэй холбоо тогтоох үйл явц хэдэн өдрөөс хэдэн жил хүртэл үргэлжилж болох магадлалтай. Гэхдээ өнөө үед хүүхэдтэй анх холбоо тогтоох, гэмт хэрэг үйлдэх хоёрын хоорондох хугацаа маш богино болоод зогсохгүй, гэмт хэрэгтнүүд нь хохирогчтой итгэлтэй харилцаа бий болгохоос илүүтэй хохирогчийг хөшүүрэгдэх, өөртөө татах ямар нэг аргыг хурдан олоход анхаарлаа хандуулдаг болсон байна³².

Манай улсад энэ төрлийн гэмт хэргүүд цөөнгүй бүртгэгдэж байгаа бөгөөд гэмт хэрэгтэн өөрийн бодит нэр, нас, зургаа өөрчлөн хүүхдүүдийн итгэлийг олж авснаар хэдэн ч хүүхдийг хохирогч болгох боломжтойг доорх тохиолдлоос харж болно.

Тохиолдол: А нь 2020 онд фейсбүүкийн хуурамч хаяг үүсгэж, бага насны охидын хаяг руу найзын хүсэлт илгээж, нийт бага болон өсвөр насны нийт 84 охинтой танилцан, харилцаа тогтоож, чатлах явцдаа тухайн охидыг айлгаж, ятгах гуйх байдлаар өөрсдөөр нь нүцгэн дүрс бичлэгийг нь хийлгүүлэн авч, улмаар уулзаж, барьцаалан айлган сүрдүүлж, заналхийлж, бэлгийн харьцаанд орсон гэмт хэргийг цагдаагийн байгууллага илрүүлэн шалгасан байна.

Цаашилбал, бага насны хүүхдийг хүчиндэх, бэлгийн хүслээ ёс бусаар хангасан гэмт хэргээр удаа дараа яллагдсан этгээдүүд цахим орчинд шилжиж, бага насны хүүхдийг садар самуунд уруу татсан үйлдлүүд илэрсээр байна. Сүүлийн үед цахим бэлгийн хүчирхийлэл үйлдэж буй этгээдүүд нь хүүхдүүдийн хувийн мэдээллийг дан ганц бэлгийн хүслээ хангах бус ашиг олох зорилгоор бусдад худалдаж байгаа тохиолдлыг мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байгаа³³ талаар Эрүүгийн цагдаагийн газраас мэдээлсэн байна.

2.6.3 Цахим зурвасаар илрэх хүүхдийн бэлгийн хүчирхийлэл (Sexting)

Цахим бэлгийн хүчирхийллийн энэ хэлбэр нь цахим орчин, төхөөрөмжийг ашиглан илт бэлгийн харилцаа, садар самуун агуулгатай мэдээлэл зураг, зурвас, дүрс бичлэгийг илгээх, олж авах, тараах, түгээхээр айлган сүрдүүлэх, цахим орчинд нийтлэх, түүгээр дарамтлан бэлгийн хүчирхийлэл үйлдэх зорилготой гэмт хэрэг юм.

Хүүхдэд хандсан цахим зурвасаар илрэх бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл, тэрчлэн өсвөр насныхны хийсэн бэлгийн харьцааны агууламж бүхий зураг, дотно харилцаатай зураг зэргийг харилцан тохиролцож хоорондоо хуваалцсан байсныг цахимаар бусадтай хуваалцах нь мөн эдгээр хууль бус үйлдэлд хамаарна.

Хүүхэд хэн нэгэнд өөрийн таалагддаг гэдгээ харуулах, сайн найзууд гэдгээ нотлохын тулд бэлгийн харьцааны утга агуулга бүхий зурвас, зураг, дүрс бичлэгийг нь авахыг, хуваалцахыг хүссэн хүсэлт, шаардлагыг биелүүлэх “найрсаг шахалт”-д орсон, эсвэл орж болзошгүй юм. Цахим зурвасаар илрэх бэлгийн хүчирхийлэл нь хүүхэд педафилүүдэд (бэлгийн гаж донтнууд) өгөөш болох, өмнө илгээсэн зураг, мэдээллийг нь ашиглан айлган сүрдүүлэх замаар нэмэлт зураг, зүрс бичлэг олж авах, улмаар бэлгийн сонирхлоо гүйцэлдүүлэх, зарим тохиолдолд мөнгө нэхэх зэрэг эрсдэлд оруулдаг.

³² CEOP, “Threat Assessment of Child Sexual Exploitation and Abuse”, p.10.

³³ Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мэдээлэл, <http://www.shuud.mn/a/539376>



2.6.4 Хүүхдийн цахим бэлгийн хүчирхийллийн бусад хэлбэрүүд

Хүүхдийн порнограф: Энэ нь хүүхдийг жинхэнэ эсвэл дуурайлган бэлгийн дур хүслээ илэрхийлсэн зан үйл хийж байгааг нүдээр харуулсан аливаа материал эсвэл хүүхдийн бэлгийн эрхтнийг голчлон бэлгийн зорилгоор дүрсэлсэн аливаа материалыг хэлнэ³⁴ хэмээн тодорхойлсон байдаг.

Хүүхдийг садар самуунд сурталчлах: Үүнийг хүүхдийг ил тод бэлгийн харилцаанд бодитоор буюу хиймлээр оруулж байгааг аливаа арга хэрэгслээр илэрхийлэх буюу гол нь бэлгийн харилцааны зорилгоор хүүхдийн бэлэг эрхтнийг аливаа байдлаар харуулах гэж ойлгоно.

Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэж хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн, хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон үйлдлийг хэлнэ³⁵.

Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах: Үүнийг хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг болон кибер орчныг ашиглаж бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан үйлдлийг ойлгоно.

Дээр дурдсан бүх үйлдлүүдэд насанд хүрээгүй хүнийг оролцуулах, 18-аас доош насны хүүхдийн зүй бус зураг, дүрс бичлэг хийх, бусадтай хуваалцах, бусдаас авах, бусдад тараах нь Монгол Улсын Эрүүгийн хуулиар хориотой гэмт хэрэгт тооцогддог.

2.7 Бэлгийн хүчирхийллийн хүүхдэд үзүүлэх хор нөлөө

Бэлгийн хүчирхийлэл нь хүүхдийн бэлгийн хэвийн хөгжлийг тасалдуулж, тэднийг сэтгэл хөдлөл, сэтгэл зүй, бие махбодын хувьд хэт их ачаалалтай болгож, сөрөг бодол, мэдрэмж, туршлагыг даван туулахад хүргэдэг богино болон урт хугацааны ихээхэн хор хөнөөлтэй үзэгдэл юм. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл нь тэдний аюулгүй байдал, эрүүл мэнд, боловсрол, амь насанд ч урт болон богино хугацааны асар их сөрөг нөлөө үзүүлдэг. Эдгээрийн заримаас дурдвал:

- Хүүхдийн бие бялдар, сэтгэхүйн хэвийн өсөлт хөгжилд сөргөөр нөлөөлдөг.
- Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндэд асар их сөрөг үр дагавартай: тэдний сэтгэл санааны хүнд цочрол, сэтгэлийн түгшүүр, сэтгэл гутрал, сэтгэл зүйн гэмтлээс үүдэлтэй өөрийгөө гэмтээх, мансууруулах бодис, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэх зэрэг ноцтой эрсдэлт зан үйлд өртөж болно.
- Хүүхэд сургуулиа орхих, сургууль завсардах, боловсролын түвшин доогуур байх зэргээр хувь хүний хөгжил, амьдралын чанарт сөргөөр нөлөөлнө.
- Хүний дархлал хомсдолын халдвар (ХДХВ), бусад бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ) авах өндөр эрсдэлтэй.
- Өсвөр насны охидын жирэмслэлт, үр хөндөлт, төрөлт гэх мэт нөхөн үржихүйн эрүүл мэндийн хор нөлөө асар их гэх мэт.

2.8 ХҮҮХДИЙН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ТАЛААРХ БУРУУ ОЙЛГОЛТУУД

Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн талаар олон нийтийн дунд, зарим мэргэжилтнүүдийн дунд ч буруу ташаа ойлголт багагүй байдаг. Иймд энэ хэсэгт түгээмэл

³⁴ 2007 онд Европын холбооноос баталсан Хүүхдийг бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийллээс хамгаалах тухай Конвенц буюу "Ланзаротын конвенц"

³⁵ Монгол Улсын Эрүүгийн хууль, 16.8 дугаар зүйл

яригддаг ажиглагддаг буруу үзэл, хандлага, тэдгээрийг хэрхэн зөв ойлгох тайлбарыг авч үзлээ.

БУРУУ: “Хүүхэд өөрт тохиолдсон бэлгийн хүчирхийллийн талаар зохиож ярьдаг”.

ЗӨВ: Хүүхдүүд бэлгийн хүчирхийллийн тухай худлаа, эсвэл зохиож ярьдаггүй. Харин хүүхэд өөрт нь тохиолдсон зүйлийн талаар бусдад ярих дургүй, насны онцлог байдлаасаа шалтгаалан энэ талаар зохиож ярих туршлагагүй байдаг. Тиймээс хүүхэд энэ тухай ярьж эхэлсэн бол заавал анхаарлаа хандуулж, бүрэн мэдээлэл олж аван, хүүхдэд яаралтай туслалцаа үзүүлэх шаардлагатай. Хүүхдүүд нас, хөгжлийн онцлогоосоо шалтгаалан хэсэг хэсгээр, эмх замбараагүй ярих, эсвэл цаг хугацааг бүрэн санахгүй сольж ярих асуудал гардаг тул хүүхдэд итгэж байгаагаа мэдрүүлж чадвал гэмт хэргийг таслан зогсоход хувь нэмрээ оруулж чадна. Судалгаанаас үзэхэд бэлгийн хүчирхийллийн талаар хүүхдээс гаргасан гомдлын 94% нь хөндлөнгийн хяналтаар баталгаажсан байдаг.

БУРУУ: “Танихгүй хүнээс болгоомжил”.

ЗӨВ: Хүмүүс хүүхдүүддээ “танихгүй хүнээс болгоомжил, ойртож, ярихгүй, харьцахгүй бай” гэж заадаг нь хэрэгтэй боловч бэлгийн хүчирхийлэлд өртөхөөс хамгаалах гол арга биш юм. Учир нь бодит байдал дээр ихэнхдээ хүүхдийн таньж мэддэг хүн нь бэлгийн хүчирхийлэл үйлдсэн байдаг ба хүүхдэд байнга сануулдаг “танихгүй хүн” нь хүүхдийн бэлгийн хүчирхийлэгч болох нь харьцангуй цөөн байдаг. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн судалгаа³⁶-наас үзэхэд хүчирхийлэл үйлдэгчдийн 85% нь хохирогч хүүхдүүдийн гэр бүлийн гишүүн, хамаатан садан, танил хүмүүс байжээ. Иймд зөвхөн таньж мэдэхгүй хүнээс болгоомжил гэсэн сэрэмжлүүлэг хүүхдийн таньж мэддэг, эсвэл бүүр ойр дотны хүн нь бэлгийн хүчирхийлэл үйлдэхэд хүүхэд болгоомжилж, бусдаас тусламж авч мэдэхгүйд хүргэдэг. Энэ байдал илэрч, мэдээлэгдэхгүй далд байснаар даамжирч, хүүхэд таньж мэддэг хүн, гэр бүлийн хэн нэгэн гишүүний бэлгийн хүчирхийлэлд өртөмхий болгодог.

БУРУУ: “Хүүхдүүд өөрсдөө эрэгтэйчүүдийг өдөн, анхаарал татдаг”.

ЗӨВ: Энэ нь хүчирхийллийн бурууг гэмт этгээдээс холдуулан хүүхдэд тохож байгаа буруу үзэл хандлага бөгөөд гэмт этгээдүүдийн өөрсдийгөө хамгаалах, асуудлыг өөрөөсөө холдуулах гэж зохиосон худал яриа юм. Тэд “хүүхэд өөрөө өдсөн”, “одоогийн хүүхдүүд замбараагүй болсон”, “насыг нь таахын аргагүй өсгөлүүн болсон”, “би энэ хүүхдэд дурласан учраас” гэх мэтээр асуудлыг өөрөөсөө зайлуулсан тайлбар хийхийг хичээдэг. Ялангуяа өсвөр насныхны бэлгийн бойжилт явагдах онцлог үед хүүхдэд бие махбод, сэтгэхүйн олон өөрчлөлтүүд болдог. Энэ үед насанд хүрсэн гэмт этгээдүүд тодорхой зорилготойгоор хүүхдийг өөртөө татаж, эргэлзүүлэх, төөрөлдүүлэх, итгэлийг нь олох аргыг түгээмэл хэрэглэдэг. Тухайлбал: *Хамт кино үзэх, хоолонд оруулах, гадуур машинтай зугаалах* гэх мэт аргуудаас гадна сэтгэлийг татахын тулд ... *чамд хайртай, дурласан, чи үнэхээр хайртай бол хайртайгаа баталчих* гэх мэтээр төөрөгдүүлэн бэлгийн харьцаанд ордог. Бэлгийн харьцаанд орж, зорилгоо биелүүлмэгц хохирогч хүүхдийг буруутган, өөрөө уснаас хуурай гарахыг оролддог. Хүүхдүүд ямар ч тохиолдолд биеийн болон сэтгэлзүйн хувьд хүчин мөхөстдөг.

³⁶ <http://www.prokuror.mn/a/2165>



БУРУУ: "Гэр бүл дэх хүүхдийн бэлгийн хүчирхийллийн асуудалд ээжүүд буруутай".

ЗӨВ: Энэ нь гэмт хэргийг гэмт этгээдээс холдуулсан бас нэгэн буруу ойлголт. Хүчирхийлэлтэй гэр бүлийн ээж, аав аль аль нь ихэнхдээ хүүхдээ хамгаалах талаар хариуцлагагүй хандсан байдаг. Ихэнх тохиолдолд ээж нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч байдаг тул хүүхдэдээ анхаарал тавих, хамгаалах чадваргүй байдаг. Гэр бүлийн хүчирхийлэлд амьдардаг хүүхдүүд ээжийгээ өрөвдөж, зовж байгаа дээр нь дахин нэрмээс болохыг хүсдэггүй тул ээждээ хэлдэггүй. Зарим ураг төрлийн хүчингийн тохиолдолд гэмт этгээд "ээж чинь энэ тухай мэдэж байгаа" гэж хэлдгээс хүүхэд тусалж чадахгүй байна гэж буруугаар ойлгон ээждээ гомдож, энэ талаар хэлдэггүй. Мөн цөөнгүй тохиолдолд хүчирхийлэл үйлдэгч хүүхдийг ээждээ хэлбэл "бүгдийг нь ална, амь насыг хорооно" гэх мэтээр сүрдүүлдэг тул хүүхэд чимээгүй байснаараа гэр бүлээ аварч байна гэж боддог.

БУРУУ: "Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг ихэнхдээ гудамж, харанхуй булан тохой, орц, хонгилд танихгүй хүмүүс, шөнө оройн цагаар үйлддэг".

ЗӨВ: Хүмүүс ихэнхдээ ингэж боддог ч үнэн хэрэгтээ цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бэлгийн хүчирхийллийн 3 хэрэг тутмын 2 нь гэр орон сууцанд (66%), 8.5% нь гудамж талбайд үйлдэгдсэн байсан бөгөөд³⁷ хүчингийн гэмт хэрэг үйлдэгч 4 хүн тутмын 3 нь хохирогч хүүхдийн таньж мэддэг эсвэл ойр дотны садан төрлийн хамааралтай хүмүүс байдаг байна.

³⁷ 2020 онд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо мэдээ (505 бэлгийн хүчирхийллийн хэрэг)

БҮЛЭГ 3. НИЙГЭМ-СЭТГЭЛЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ: ҮНДСЭН УХАГДАХУУН

Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудад ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн дотор, ялангуяа хөдөө орон нутагт, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчээс өөр мэргэжлийн, эсвэл шинэ ажилтнууд нэлээд байдаг. Иймд энэ бүлэгт нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөөний үндсэн ухагдахууны талаар товч ойлголт өгөх болно.

3.1. НИЙГЭМ СЭТГЭЛЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ГЭЖ ЮУГ ХЭЛЭХ ВЭ?

"Зөвлөгөө" гэдэг нэр томъёо нь зөвлөгч ба асуудалд тусламж хайж буй хүний хоорондын харилцааг илэрхийлдэг ойлголт юм. ЮНЕСКО-ийн Зөвлөгөө өгөх гарын авлагад "Нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө гэдэг нь үйлчлүүлэгч өөрийн нөхцөл байдлаа ойлгох, тодруулах, асуудлаа бодитоор танин мэдэх, бэрхшээлийг давах, шаардлагатай үед нөхцөл байдлаа өөрчлөхөд туслах нийгэм-сэтгэлзүйн үйлчилгээ"³⁸ гэж тодорхойлжээ.

Мөн "Үйлчлүүлэгчийн суурь асуудал, түүний шалтгаанд тулгуурлан бие хүний асуудалд төвлөрсөн зөвлөх, туслах үйлчилгээг сэтгэл зүйн зөвлөгөө гэнэ. Товчоор хэлбэл өөрөө асуудлаа ухамсарлаж, ойлгох боломжтой хүнд зориулсан сэтгэл зүйн тусламж үйлчилгээг хэлнэ"³⁹ гэсэн тодорхойлолт ч бий. Сэтгэл зүйн зөвлөгөө нь сэтгэл зүйн тусламж үйлчилгээний нэг төрөл юм.

3.2 НИЙГЭМ-СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ТӨРӨЛ, ҮЙЛ ЯВЦ

Зорилго: Нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөний зорилго нь үйлчлүүлэгчийн асуудлыг таньж мэдэх, өөрөөр нь шийдвэр гаргуулах, үйлчлүүлэгчийн өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж, өөрчлөлт гаргахад оршино.

Ихэнх тохиолдолд үйлчлүүлэгчид зөвлөгөөний талаарх мэдлэг дутмаг байдгаас өөрийгөө болж буй асуудлыг шийдвэрлэх чадваргүй гэсэн ойлголттой байдаг. Зарим нь зөвлөгөөг "ид шидийн тусламж", зөвлөгчийг "шидтэн" мэт хүлээж авдаг бол зарим нь эмнэлгийн түргэн тусламж гэж ойлгодгоос зөвлөгч бүх хариуцлагыг өөртөө хүлээж асуудлыг нь шийдэж өгнө гэдэг хүлээлттэй байдаг. Тийм учраас зөвлөгөө авах гэж ирэхдээ асуудлаа эергээр шийдвэрлэхийн тулд зөвлөгчөөс "эмчийн жор" шиг шийдвэр гаргуулахыг хүсэж ханддаг. Харамсалтай нь иймэрхүү нийгэмд тогтсон буруу ташаа ойлголт нь зөвлөгөөний үр дүнд сөргөөр нөлөөлөх, үйлчлүүлэгч зөвлөгчийг гарах гарцыг шууд зааж өгсөнгүй гэж бухимдах хандлагыг гаргадаг.

Гэвч зөвлөгчийн гол үүрэг нь тухайн үйлчлүүлэгчээр **ӨӨРӨӨР НЬ ШИЙДВЭР ГАРГУУЛАХ** явдал билээ. Үйлчлүүлэгчээр өөрөөр нь шийдвэр гаргуулж хэр чадаж байгаа эсэхээр л зөвлөгчийн ур чадвар үнэлэгддэг.

Зөвлөгөөний төрлүүд: Нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөг хэлбэрээр нь ганцаарчилсан ба бүлгийн; хугацаагаар нь богино ба удаан хугацааны гэж ангилдаг⁴⁰. Богино хугацааны зөвлөгөө нь өдөрт 4 цагаар 5 долоо хоног орчим байна. Удаан хугацааны зөвлөгөө

³⁸ http://www.unesco.org/education/mebam/module_2.pdf

³⁹ <https://www.legalinfo.mn/law/details/8907>

⁴⁰ О.Мягмар, "Сэтгэц заслын зөвлөгөөний онол арга зүй" гарын авлага, 2009 он



нь сэтгэц заслын үед долоо хоногт 3-4 удаа, 1.5 цагаар дунджаар 3 сар хийгдэнэ. Зөвлөгөөний хугацаа нь асуудлын хүнд хөнгөнөөс шалтгаалж өөр байдаг.

Зөвлөгөөний үе шатуудыг хэрэгжүүлэх: Нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг **ХОЁР ҮЕ ШАТААР** хэрэгжүүлдэг. Эхний шатанд үйлчлүүлэгч хүндрэлтэй байгаа асуудлаа сайн тодорхой харж ойлгоход тусална. Үүнийг үйлчлүүлэгчид дэмжлэг үзүүлэх байдлаар түүний бодол санаа, мэдрэмжийг анхааралтай сонсож, үйлчлүүлэгчийг чадваржуулах хандлагыг ашиглаж хэрэгжүүлнэ. Хоёр дахь шатанд зөвлөгөөг үйлчлүүлэгч асуудлаа зохицуулах, бэрхшээлийг давж гарах, өөрчлөлт хийж асуудлаа шийдвэрлэхэд нь туслахад чиглүүлнэ.

Зөвлөгөөг хаах: Зөвлөгөө зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлж, зөвлөгч, үйлчлүүлэгч хоёр хамтын шийдвэрээр үйлчилгээг дуусгавар болгох үйл явцыг зөвлөгөөг хаах гэж нэрлэнэ. Зарим тохиолдолд дараах шалтгаануудын улмаас зорилгодоо хүрэхээс өмнө зөвлөгөөг төгсгөж болно. Үүнд:

- **Үйлчлүүлэгчийн зүгээс:** хувийн асуудал, ар гэрийн шалтгаанаар, өөр байгууллага, зөвлөгчийг сонгохоор, эцэг эх, асран хамгаалагчийн шаардлагаар, эрүүл мэнд, хуулийн асуудлаар мэргэжлийн байгууллагад хандахаар гэх мэт.
- **Зөвлөгчийн зүгээс:** өөр ажилд шилжих, ажлаа үргэлжлүүлэн хийхээ болих, үйлчлүүлэгч татгалзсан нөхцөлд, байгууллагын санаачилгаар гэх мэт шалтгаанаар зөвлөгөөг зорилгодоо хүрэхээс өмнө төгсгөж болно.

Зөвлөгөөний үр дүнг үнэлэх: Зөвлөгч нь зөвлөгөө дуусгавар болсны дараа гарсан өөрчлөлт үр дүнг зөвлөгчийн болон үйлчлүүлэгчийн үнэлгээнд тулгуурлан үнэлнэ. Хохирогч хүлээн авсан үйлчилгээ, туслалцааны үр дүн хэрхэн эерэг, сөрөг нөлөө үзүүлснийг тусгай маягтын дагуу эсвэл ярилцлагын аргаар үнэлж болно. Зөвлөгч нь үзүүлсэн үйлчилгээний явцад гарсан өөрчлөлтүүд, үр дүнг үйлчлүүлэгчтэй харилцан ярилцсаны үр дүнд тусгай үнэлгээний маягтын асуумжийг бөглөж үнэлнэ. Зөвлөгөөг хаасан талаар зөвлөгч, үйлчлүүлэгч харилцан зөвшөөрч гарын үсэг зурснаар үйлчилгээ төгсгөл болно.

Шаардлагатай бол Зөвлөгч нь зөвлөгөөг хэзээ, хэрхэн дахин үргэлжлүүлэх шийдвэрийг үйлчлүүлэгчтэй хамтарч гаргана. Үйлчилгээг төгсгөж, кейсийг хаахдаа үйлчлүүлэгч хэвийн амьдралдаа эргэн ороход бэлэн болсон эсэхэд тулгуурлаж шийднэ.

Баримтжуулах: Хохирогчид зөвлөгөө өгөх явцад гарсан өөрчлөлтүүд, ярилцлага, холбон зуучилсантай холбогдох баримтуудыг тухай бүрд нь баримтжуулж үйлчлүүлэгчийн хувийн хэрэгт хавсаргаж явна. Эмнэлгийн магадалгаа, хуулийн асуудал, бусад гарсан өөрчлөлттэй холбоотой холбогдох баримтууд, үнэлгээний маягыг хохирогчийн хувийн хэргийн төгсгөлд хавсаргана.

ПРАКТИК ЗӨВЛӨМЖ

Зөвлөгөөг илүү үр дүнтэй болгохын тулд юу анхаарах вэ?

Үр дүнтэй зөвлөгөө гэдэг бол үйлчлүүлэгчийн өмнөөс шийдвэр гаргах бус, харин үйлчлүүлэгчтэй хамтран ажиллах, үйлчлүүлэгчээрээ өөрөөр нь шийдвэр гаргуулж чадах үйл явцыг хэлнэ. Иймд Зөвлөгч та доорх зүйлүүдийг анхаараарай.

- Хоёр адилхан асуудалтай үйлчлүүлэгч ба адилхан нөхцөл байдал гэж байдаггүй. Үйлчлүүлэгчийн асуудал гаднаасаа адил төстэй мэт боловч хувь хүн бүрийн амьдрал, нөлөөлж буй хүчин зүйлүүд харилцан адилгүй байдгаас ТОХИОЛДОЛ БҮР ӨВӨРМӨЦ байдаг.
- Зөвлөгөө өгөх явцад нөхцөл байдал яг үе шатны дагуу байна гэж байдаггүй болохоор үйлчлүүлэгч болон зөвлөгч харилцаагаа байнга өөрчилж байдаг.
- Хувийн асуудалдаа хамгийн сайн дүгнэлт хийж чадах хүн нь үйлчлүүлэгч өөрөө. Иймд Зөвлөгч зөвлөгөө өгөх явцад үйлчлүүлэгчид асуудлаа бие даан шийдвэрлэх, хариуцлагыг өөртөө бүрэн ухамсарлахад нь тусалбал зохино. Үйлчлүүлэгч өөрийн асуудлаа хэрхэн авч үзэж, хандаж байгаа нь зөвлөгч түүний тухай хэрхэн ойлгож төсөөлснөөс илүү чухал байдаг.
- Зөвлөгөө өгөх явцад үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын мэдрэмж зөвлөгчийн шаардлагаас илүү чухал. Иймд үйлчлүүлэгчийн сэтгэл хөдлөлийн байдлыг байнга анхаарч байхгүй бол зөвлөгөөний зорилгод хүрэхэд хүндрэлтэй.
- Үйлчлүүлэгчид туслахын тулд Зөвлөгч нь өөрийн хувь хүний болон мэргэжлийн бүхий л боломжоо ашиглах ёстой. Гэхдээ тодорхой тохиолдолд хэн нэгэн хүн, түүний амьдрал, асуудал, хүндрэлийн өмнө бүрэн хариуцлага хүлээж чадахгүй гэдгийг мартаж болохгүй.
- Зөвлөгөөний уулзалт бүрээс шууд эерэг үр дүн хүлээх боломжгүй. Гайхалтай үр дүн гэнэт эсрэгээр өөрчлөгдөж болох бөгөөд өөрийгөө өөрчлөх нь хүнээс маш их хүч, эрсдэл шаарддаг.
- Туршлагатай зөвлөгч өөрийн мэргэжлийн түвшин, хувийн алдаа дутагдлаа мэддэг байх төдийгүй үйлчлүүлэгчийн тусын тулд ажиллах ёс зүйн зарчмыг нэг бүрчлэн баримтлахаа мэддэг байх ёстой.
- Асуудал бүрийн хандлага, агуулгыг олохын тулд онолын янз бүрийн чиг хандлагаар ажиллаж болох бөгөөд зөвхөн ганц төгс төгөлдөр чиг хандлага гэж байхгүй, байж ч болохгүй юм.
- Зөвхөн зөвлөгөөгөөр шийдэгддэггүй асуудлууд олон байдаг. Ийм тохиолдолд Зөвлөгч нь үйлчлүүлэгчдээ тухайн нөхцөл байдлаас зайлсхийх аргагүйг болон нөхцөл байдлыг бодитоор хүлээн авч, хэрхэн даван туулах талаар ойлгуулбал зохино.

3.3 НИЙГЭМ-СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ БОЛОН ЗӨВЛӨГЧИЙН ЁС ЗҮЙН ЗАРЧМУУД

Зөвлөгч нь үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөхдөө нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөний үндсэн зарчмууд болон зөвлөгчийн мэргэжлийн ёс зүйн зарчмуудыг баримталж ажиллавал зохино.

3.3.1 Нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөхөд баримтлах үндсэн зарчмууд

1) Хүний эрхэд суурилсан арга барилаар ажиллах⁴¹: Энэ нь Зөвлөгч бол хүний эрхийг хэрэгжүүлэгч субъект, үйлчлүүлэгч бол эрх эзэмшигч гэдэг зарчмыг баримталж ажиллахыг хэлнэ. Энэ үүднээс Зөвлөгч нь үйлчлүүлэгчийнхээ эрхийг хүндэтгэх, хамгаалах, хөхүүлэн дэмжих үүрэг хүлээнэ.

2) Нууцлалыг хангах: Зөвлөгч нь хохирогчтой холбоотой хувийн болон мэдээллийн нууцыг чанд хадгалах ёстой. Болсон явдлын талаар хэнд хэлэхийг хүсэж байгаагаа тодорхойлоход нь үйлчлүүлэгчид туслалцаа үзүүлэн яаж үүнийгээ мэдэгдэх вэ гэдэгт нь тусална. Зөвлөгч нь мөн өөрийнхөө нууцлалын хүрээг хохирогчид ойлгуулах хэрэгтэй. Хэрэв үйлчлүүлэгчийн болсон явдлын тухай гэр бүлийнхэн болон мэргэжлийн бусад байгууллага хүмүүст мэдэгдэх шаардлагатай бол энэ тухай үйлчлүүлэгчдээ урьдчилан хэлэх хэрэгтэй.

⁴¹ Олон улсын хүүхдийн эрхийн зөвлөх Доктор Катерина Ларкинсын илтгэл “хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын механизм/Хүүхдийн эрхийн конвенц, Нэмэлт протокол” https://eeas.europa.eu/sites/eeas/files/eu_mon_hr_conference_june.mon_.pdf



3) Үйлчлүүлэгчийн хувийн орон зайг хангах: Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгөх, бусад тусламж үйлчилгээ үзүүлэхдээ заавал **ТУСГАЙ ӨРӨӨНД** гүйцэтгэнэ. Ялангуяа бэлгийн халдлагын талаар бусад хүн хамт сонсож болох орчинд хэнээс ч ярилцлага авч болохгүй. Бэлгийн харьцаатай холбогдох зөвлөгөөг дээд зэргийн ая тухтай, үйлчлүүлэгчийн хувийн орон зайг хангасан орчинд өгөх нь чухал.

4) Үйлчлүүлэгч мэдээлэлтэйгээр зөвшөөрөл өгөх, мэдээлэлд суурилан сонголт хийх боломжоор хангах: Үйлчлүүлэгчид боломжтой үйлчилгээний талаар ойлгомжтой хангалттай мэдээлэл өгсний үндсэн дээр тэдний зөвшөөрлийг авах ба сонголт хийх, өөрөө шийдвэр гаргах эрхийг нь дэмжинэ. Хохирогч албадлагаар үйлчилгээ авах шаардлагатай тохиолдолд учир шалтгаан, нөхцөл, үйлчилгээний журам, үзүүлэх үйлчилгээгээ танилцуулж ойлгуулах шаардлагатай.

5) Үйлчлүүлэгч туслалцаа, дэмжлэг хайх, хандахад нөлөөлөх: Ихэнх хохирогч нарт нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээнээс гадна эрүүл мэндийн, нийгмийн халамжийн, эрхзүйн гэх мэт тусламж үйлчилгээ, дэмжлэг шаардлагатай байдаг. Иймд тусламж хайх, мэргэжлийн байгууллагад хандахад нь тэдэнд нөлөөлж, дэмжих хэрэгтэй. Гэхдээ тухайн хүн өөрөө хүсэхгүй байхад туслалцаа ав гэж тулган шаардаж болохгүй.

6) Үйлчлүүлэгчийн оролцоог хангах: Зөвлөгөө өгөхдөө тэднийг идэвхжүүлсэн, хэрэгцээнд нь суурилсан, соёлын болон хувь хүн тус бүрийн онцлогийг харгалзсан арга барилаар ажиллана.

7) Шаардлагатай мэдээллийг зөв зохистой аргаар өгөх. Үйлчлүүлэгчийн тавьсан ямар ч асуултад хариулах хэрэгтэй. Цаашид юу болох тухай товчхон тайлбарлах нь чухал. Хохирогчид өөрийнхөө нэр, утасны дугаараа өгөх хэрэгтэй.

3.3.2 Зөвлөгчийн мэргэжлийн ёс зүйн зарчмууд

Зөвлөгч нь үйлчлүүлэгчид нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг хэрэгжүүлэхдээ *Монголын нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм*⁴²-д заасан нийтлэг шаардлага, зарчим, үнэт зүйлс, ёс зүйн хэм хэмжээг баримтлахын сацуу дараах мэргэжлийн ёс зүйн зарчмуудыг заавал дагаж мөрдөнө.

- Үйлчлүүлэгчийн нэр төр, эрхэм чанарыг дээдлэх
- Хэнийг ч ялгаварлан гадуурхахгүй, алагчлахгүй байх
- Үйл ажиллагааны бүх үе шатанд шударга ёсыг баримтлах
- Үйлчлүүлэгчид үнэн сэтгэлээсээ хандах, шүүмжлэхгүй байх
- Хувь хүний ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч хүндэтгэх
- Үйлчлүүлэгчтэй харьцахдаа хувийн ашиг сонирхол агуулахгүй байх
- Үйлчлүүлэгчийн эрх ашгийн төлөө бусад мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах,
- Үйлчлүүлэгчид дээд зэргийн үйлчилгээ хүргэхийн тулд өөрийгөө мэргэжлийн хувьд тасралтгүй хөгжүүлж байх
- Мэргэжлийн хил хязгаарыг баримталж, үйлчлүүлэгчийн асуудалд хэт гүн орж автахгүй байх.

⁴² <https://mlsp.gov.mn/content/detail/1068>

3.4 НИЙГЭМ-СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХӨД ШААРДАГДАХ УР ЧАДВАНУУД

3.4.1 Сонсох ур чадвар

Сайн сонсож сурах чадвар нь нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх хамгийн чухал бөгөөд хэцүү чадвар юм. *“Сайн сонсох” гэдэг нь анхаарлаа сайн төвлөрүүлж, нэгтгэн ойлгох, нягтлах, холбоо хамааралтай асуултыг асуух, дуугүй байж хүндлэл үзүүлэх байдлаар илэрдэг*⁴³. Энэ нь товчхондоо **ТЭВЧЭЭРТЭЙ БАЙХ** ур чадвар юм. Үйлчлүүлэгчийг сонсох нь харилцагчаа үнэн сэтгэлээсээ сонирхож байгаагийн илэрхийлэл болдог.

Зөвлөгч нь сонсох чадварыг сайн эзэмшсэнээр үйлчлүүлэгчтэйгээ харилцаагаа бататгах, хувь хүнийхээ хувьд түүнийг ойлгон хүлээн авч байгаагаа харуулах ойрын зорилгоо биелүүлнэ. Цаашилбал, өөрийн санал бодлоо илэрхийлэхэд шаардлагатай мэдээллүүдийг олж авснаар үйлчлүүлэгч асуудлаа шийдвэрлэх холын зорилгодоо хүрэхэд нь тусална. Бусдыг дэмжих, асуудлыг зөвшөөрөх нь тэднийг хэр сонсож чадсан бэ гэдгээс хамаардаг.

Үйлчлүүлэгчээ анхааралтай сонсох нь яагаад чухал вэ?

- Тухайн хүнд анхаарлаа хандуулж байна гэдгээ харуулна.
- Тухайн хүний асуудал болон уг хүн юу мэдэрч байгааг ойлгож, түүнд байнгын анхааралтай, хүндэтгэлтэй хандаж байгаагаа мэдрүүлнэ.
- Тухайн асуудал, шийдэлд дүн шинжилгээ хийж, зохистой хариу үйлдэл үзүүлэхэд тусална.
- Цэгцтэй, асуудалдаа чиглэсэн шийдлийг олж авах боломжтой болно.
- Харилцааг зөв чиглүүлнэ.

Сонсох сайн арга барилууд

Аргууд	Зорилго	Тавих боломжит асуултууд
Тодруулах	Нэмэлт мэдээлэл авах; Үйлчлүүлэгчид нөхцөл байдлынхаа талаар дахин эргэцүүлэх боломж олгох;	<i>... гэснийгээ тодруулахгүй юу? Та тэгэхээр ... гэж байна гэсэн үг үү?</i>
Дахин дурдах	Утга санааг нь нягталж, нэг ойлголттой болсон эсэхээ шалгах; Сонсож байгаа, түүнийг ойлгосон гэдгээ харуулах	<i>Миний ойлгосноор чи ... гэж төлөвлөж байгаа юм аа даа. Тэгэхээр та ... гэж шийдсэн байх нь ээ.</i>
Төвийг сахих	Асуудлыг нь сонирхож сонсож байгаа гэдгээ харуулах; Үйлчлүүлэгчийг үргэлжлүүлэн ярихад нь дэмжлэг болох;	<i>Аан зөв зөв. Би ойлгож байна. Наадах чинь зөв санаа байна шүү.</i>
Мэдрэмжээ хуваалцах	Тухайн хүний юу мэдэрч байгааг ойлгож байна гэдгээ харуулах;	<i>Тэгэхээр танд ... гэж санагдсан байх нь. Таны харсан зүйл үнэхээр гайхшируулж байна. Таныг үнэхээр тоохгүй байгаа мэт танд санагдсан байж дээ.</i>
Дүгнэн шинжлэх	Бүхий л ярилцлагыг нэгтгэн анхаарлаа төвлөрүүлэх; Асуудлыг өөр талаас нь авч үзэн нягтлах;	<i>... эдгээр асуудлууд нь таны илэрхийлсэн гол санаанууд байна. Таныг тухайн нөхцөл байдалд яасныг би ... гэж ойлгож байна.</i>

⁴³ United Nations Children’s Fund 2000 Third edition 2003 “TRAINING HANDBOOK ON Psychosocial Counselling for Children in Especially Difficult Circumstances” (Revised and updated)



Сайн сонсогч байхад сөргөөр нөлөөлөх зарим хүчин зүйлс:

1) Хайхрамжгүй сонсох: Ихэнх хүмүүс өөрийн ярьж чадах хурдаасаа 4 дахин хурдан сэтгэн боддог. Тэрбээр заримдаа ярилцагчтайгаа харьцахын оронд цаг хугацаагаа өөрийн хэрэг явдлаа бодоход зарцуулж байдаг. Ийм алдаа гаргахгүй байхад туслах нэг арга нь үйлчлүүлэгчийн яриа, үг бүрийг анхааралтай сонсоход анхаарлаа төвлөрүүлэх, түүний үгэн бус харилцаа буюу үйл хөдлөл, дохио зангаа, сэтгэл хөдлөл зэргийг ажиглах юм.

2) Урьдчилан таамаглах: Үйлчлүүлэгчийн яриа уйтгартай, утга санаа нь төдийлэн анхаарал татахгүй байх явдал байдаг. Энэ нь зөвлөгчийг урьдчилан таамаглах, залхах нөхцөлийг үүсгэдэг. Зөвлөгч нарын дунд харилцагчаа төдийлөн сайн сонсоогүй боловч өөрийн дотоод сэтгэлдээ өмнөх туршлага дээрээ тулгуурлан асуулт хариулт, үг яриаг томъёолсон, урьдчилан таамаглах хэв маяг түгээмэл байдаг.

Ийм байдлаас зайлсхийхийн тулд зөвлөгч нь тэвчээртэй байж, үйлчлүүлэгчийг ярьж дуустал нь заавал сонсох хэрэгтэй. Өөрийгөө дайчлан ойлгохыг хичээн сонсвол үйлчлүүлэгчийн яриа нь харин ч сонирхолтой санагдах нь бий.

3) Хайнга сонсох: Үйлчлүүлэгчийг сонсож байгаа мэт боловч хэрэг дээрээ зөвлөгчийн бодол санаа нь өөр газар байдаг. Үүнийг нуух аргагүй байдаг тул үйлчлүүлэгч нь анзаарах магадлалтай.

4) Асуудалд хэт автах: Зарим тохиолдолд хэтэрхий хэцүү асуудлыг сонсохоороо зөвлөгч нь хэт автах асуудал үүсдэг. Тиймээс аль болох өөрийгөө чөлөөлж, харилцан яриагаа үргэлжлүүлэх хэрэгтэй.

5) Үзэл бодол үл нийлэх: Үйлчлүүлэгчийн ярьж байгаа зүйл зөвлөгчийн үзэл бодолтой тэр бүр нийлэхгүй байж болно. Энэ нь Зөвлөгч үйлчлүүлэгчийн яриаг анхааралгүй сонсох, ач холбогдол өгөхгүй байх шалтгаан болох ёсгүй.

3.4.2 Бусдыг ойлгох, мэдрэмжийг хуваалцах ур чадвар

Энэ чадвар нь харилцааны ур чадвар болон хандлагын нийлмэл илрэл юм⁴⁴. Бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллаж буй зөвлөгч энэ чадварыг сайн эзэмших нь маш чухал. Энэ чадвар нь дараах байдлаар илэрхийлэгдэж болно.

- Дотоод мэдрэмжийг нь хуваалцах: "... ийм учраас ... танд ... байгаа байх даа"
- Санааг нь давтах: "... хойш танд ... ийм асуудал үүсээд байна гэж ойлголоо, тийм үү?"
- Дуугүй сонсох: Үйлчлүүлэгч сэтгэл хөдлөлөө гаргах үед нь зөвлөгч чимээгүй байх гэх мэт
- Асуулт тавьж тодруулах: "Та энэ талаараа жаахан дэлгэрэнгүй ярьж болох уу, ... хойш танд...яг ямар хэцүү асуудлууд тохиолдсон бэ?"

Бусдын зовлонг ойлгох болон бусдын зовлонд гашуудах хоёр хоорондоо ялгаатай. Зөвлөгч нь үйлчлүүлэгчийн оронд өөрийгөө тавьж чаддаг байх хэрэгтэй, мөн үйлчлүүлэгчийн сэтгэл хөдлөлийг ойлгож байгаагаа байнга илэрхийлж байх нь зөв. Өөрөөр хэлбэл үйлчлүүлэгчийн зовлонд зүгээр эмгэнэн гашуудах биш түүнтэй хамт байж, түүний шаналлыг мэдэрч байгаагаа илэрхийлснээр та зорилгодоо хүрэх боломжтой болно.

⁴⁴ United Nations Children's Fund 2000 Third edition 2003 "TRAINING HANDBOOK ON Psychosocial Counselling for Children in Especially Difficult Circumstances" (Revised and updated)

3.4.3 Бусад ур чадварууд⁴⁵

Үйлчлүүлэгчийн дотоод ертөнцөд нэвтрэн орох ур чадвар: Энэ нь үйлчлүүлэгчид анхаарал халамж тавьж байгаагаар дохио зангаа, биеийн болон нүүрний хөдөлгөөн, эерэг харьцаагаар илэрхийлэх чадвар юм.

Үйлчлүүлэгчийн зан байдал, ёс зүйг хүндэтгэх чадвар: Энэ нь үйлчлүүлэгчид өөрийн зөвлөгөөг тулгахгүй байх, сургамжлахаас татгалзах, үйлчлүүлэгчийн нөөц боломж, өөрийн асуудлаа шийдвэрлэх чадвар боллоцоонд итгэхийг хэлнэ.

Үйлчлүүлэгчийг сэтгэлийн шаналлаас ангижруулах төдийгүй шийдвэр гаргахад чиглүүлэх зохистой зайг барьж харьцах чадвар: Энэ нь үйлчлүүлэгчид өөртөө итгэлтэй байх, өөрийгөө дахин өөрчлөх шийдвэр төгс байх үзлийг суулгах юм.

Хүмүүст сонирхлоо илэрхийлж чаддаг, тэдэнтэй харьцахдаа тэвчээртэй байх чадвар: Энэ нь үйлчлүүлэгчийн зан байдал ба нөхцөл байдалд мэдрэмжтэй байхыг хэлнэ.

Сэтгэл хөдлөлөө тогтвортой байлгаж, анхаарлаа сайн төвлөрүүлэх чадвар: Энэ нь үйлчлүүлэгчийн итгэл найдварыг хүлээх, хүндэтгэх чадвартай байхыг хэлнэ.

Өөрийнхөөрөө байх чадвар. Энэ нь үйлчлүүлэгчид үнэн сэтгэлээсээ хандах чадвар

Нээлттэй байх чадвар: Энэ нь бусад хүмүүсийн өмнө нээлттэй байх гэсэн утгаар бус харин хүртэхүй болон мэдрэмждээ үнэнч байхыг хэлдэг. Нийгмийн зүгээс үзүүлж буй хэвшмэл ойлголт нь мэдрэмжээ ялангуяа сөрөг мэдрэмжээ хаяхыг сургадаг. Жишээ нь хэн нэгэндээ "битгий уйл" эсвэл "битгий сэтгэлээр уна" гэж хэлдэг. Хүмүүсийн эдгээр үгс сэтгэлийн дарамт, уйтгар гуниг, айдас, уур уцаараа нууцлахад хүргэдэг. Зөвлөгч нь өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийн эерэг ба сөрөг бүх хариу үйлдэлд тэвчээртэй хандсанаар үйлчлүүлэгчид эергээр нөлөөлдөг.

Өөрийгөө танин мэдэж хөгжүүлэх чадвар: Өөрийгөө танин мэдэхээ хязгаарлах нь эрх чөлөөгөө хязгаарласан хэрэг бөгөөд өөрийгөө гүн гүнзгий танин мэдэх нь амьдралдаа сонголт хийх боломжийг ихэсгэдэг. Зөвлөгч нь өөрийгөө хэр их мэдэж байна тэр хэмжээгээр өөрийн үйлчлүүлэгчээ ойлгохын зэрэгцээ үйлчлүүлэгчээ хэр их мэдэрч чадаж байна тэр хэмжээгээр өөрийгөө ойлгож байдаг. Өөртөө маш бодитойгоор хандах нь чухал.

Өөрийн хүчээ мэдрэх чадвар: Зөвлөгч өөрийгөө хэн гэдгээ, хэн болж болохоо, амьдралаас юу хүсэж байгаагаа, түүнд юу илүү чухал байгааг мэдэх ёстой. Мэргэжлийн ажил дээр эсвэл өөрийн хувийн амьдралдаа ч зөвлөгч бусад хүмүүст итгэл найдвар төрүүлэх төдий биш харин үзэл бодлоо удирдан үйл ажиллагаагаа явуулах ёстой болдог.

Тодорхойгүй байдалд хүлээцтэй хандах чадвар: Тодорхойгүй нөхцөл байдалд олон хүмүүс тухгүй байгаагаар мэдэрдэг. Зөвлөгч нь тухайн тодорхой биш нөхцөл байдалд өөртөө итгэлтэй байх нь чухал.

Хариуцлага хүлээх чадвар: Зөвлөгөөний явцад янз бүрийн асуудал үүсэж болно. Эдгээр нөхцөл байдалд Зөвлөгч өөрийн хийж байгаа ажил үүрэгт бүрэн хариуцлага хүлээх ёстой.

⁴⁵ United Nations Children's Fund 2000 Third edition 2003 "TRAINING HANDBOOK ON Psychosocial Counselling for Children in Especially Difficult Circumstances" (Revised and updated)



Тодорхой зорилготой байх чадвар: Хэт их том зорилго тавих нь амжилтгүй байдлыг бий болгож, үүнээс шалтгаалж өөрийгөө хамгаалж чадахгүй сэтгэлээр унадаг. Зөвлөгч нь төгс болгох гэсэн эрмэлзлээсээ салах ёстой. Ямар ч зөвлөгч ажлаа сайн хийж чадах боловч төгс хийнэ гэж байхгүй. Боломж хязгаарлагдмал учраас үйлчлүүлэгчид худлаа амлалт өгөхгүй, бүтэхгүй, боломжгүй зүйл дээр найдвар төрүүлэхгүй байх ёстой.

Анхаарал тавих: Зорилгодоо хүрэхэд зөвлөгчийн ур чадвар маш чухал үүрэгтэйгээс гадна үйлчлүүлэгчид анхаарал тавих мөн маш чухал. Наад зах нь Зөвлөгч нь үйлчлүүлэгчтэй харилцахдаа зөвлөгөө өгөх тусгай өрөөнд уулзах бэлтгэлийг хангах хэрэгтэй. Жишээ нь, суудлаа тухтай эзэлсэн байх, бага зэрэг урагш хандсан, харцаа төвлөрүүлсэн гэх мэт байдлаар бүх анхаарлаа төвлөрүүлсэн байдалтай байна. Үйлчлүүлэгчдээ анхаарал тавих нь хэл ярианаас ч илүү мэдрэмж төрүүлдэг. Анхаарал тавьснаар үйлчлүүлэгчид зөв ойлголт, эерэг мэдрэмж төрүүлэх болно. Зөвлөгч нь үйлчлүүлэгчдээ анхаарал тавьж байгаагаа илэрхийлэхийн тулд толгой дохио, зөвшөөрсөн дуу авиа гаргах (аанхан гэх мэт) зэрэг үйлдэл үзүүлэх, нүүрний хувирал, инээмсэглэх, хөмсөг атируулах гэх мэт харилцааны олон янзын хэлбэрүүдийг ашиглаж болно.

3.5 НИЙГЭМ-СЭТГЭЛЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХӨД ХЭРЭГЛЭХ АРГУУД⁴⁶

3.5.1 Ярилцлагын арга

Үйлчлүүлэгчтэй ярилцлага хийх нь түүний тулгамдаж буй асуудал, нөхцөл байдлын талаар мэдээлэл олж авах, улмаар зөвлөгөөний зорилгоо тодорхойлох, арга барилаа боловсруулах нь эхний алхам юм. Үйлчлүүлэгчтэй ярилцлага хийхэд асуултын хэлбэрээ зөв сонгож, асуултаа зөв тавих нь маш чухал. Иймд асуултын төрлүүд, тэдгээр нь юуг илэрхийлэх талаар доорх хүснэгтэд товч харуулав.

Нээлттэй асуулт	Энэ асуулт нь үйлчлүүлэгч хариултаа өөрийн үгээр хэлэх боломж олгодог. Мөн өөрийн бодол санаагаа цэгцэлж нөхцөл байдлынхаа талаар дахин эргэцүүлэн бодоход нь тусалдаг.
Хаалттай асуулт	Энэ асуулт нь ярилцлагын эхэн хэсэгт мэдээлэл цуглуулахад хэрэг болдог. Гэхдээ анхааралтай хэрэглэхгүй бол үйлчлүүлэгчийн хариулыг хязгаарладаг муу талтай.
Чиглүүлсэн асуулт	Энэ асуулт нь хүчирхийллийн хохирогчтой ярилцахад төдийлөн тохиромжтой бус. Учир нь эдгээр нь зөвхөн таны хандлага ойлголтыг илэрхийлэхээс, тухайн үйлчлүүлэгчийнхийг илэрхийлдэггүй. Иймээс хариулт нь худал байх магадлалыг нэмэгдүүлнэ.

Нээлттэй асуултын жишээ: “Танд энэ нь ямар санагдсан талаараа яриач?”

Хаалттай асуултын жишээ: “Танд энд таалагдаж байна уу?”, “Та үргэлж түүнтэй муудалцдаг уу?”

Чиглүүлсэн асуултын жишээ: “Та түүн рүү уурлаж давшлах хэрэгтэй биз дээ?”, “Ингэх нь тэнэг хэрэг гэж та бодсонгүй юу?”

3.5.2 Ажиглалтын арга

Энэ арга нь орчин нөхцөл, үйлчлүүлэгчийн зан төлөв, сэтгэл хямралын байдал, зөвлөгөөнд үзүүлж буй хариу үйлдэл зэргийг мэдэхэд чухал ач холбогдолтой. Жишээ нь сэтгэл хямралын байдал хэр ноцтой байгааг мэдэхийн тулд дараах зан үйл, сэтгэл хөдлөлийг ажиглах хэрэгтэй. Тухайлбал:

⁴⁶ United Nations Children’s Fund 2000 Third edition 2003 “TRAINING HANDBOOK ON Psychosocial Counselling for Children in Especially Difficult Circumstances” (Revised and updated)

- Гадаад төрх, үг хэллэг, нүүрний хувирал, хувцаслалт зэрэгт нь мэдэгдэхүйц өөрчлөлт орсон эсэх;
- Сэтгэл зүйн тогтворгүй эсвэл гунигласан байдал илэрч байгаа эсэх;
- Бухимдал, уур уцаар, тэвчээргүй байдал ажиглагдаж байгаа эсэх;
- Айдас, аюултай зүйл хийх гэсэн бодол, айх айдастай байх;
- Бусад хүн, эд хөрөнгө болон өөртөө аюул учруулахаар үйлдэл, бусад руу шалтгаангүйгээр дайрах зэрэг харгис, хэрцгий хандлага гаргаж буй эсэх;
- Амиа хорлох, өөрийгөө гэмтээхийг оролдох оролдлогууд ажиглагдаж байгаа эсэх гэх зэрэг болно.

3.5.3 Асуудлын менежментийн аргууд⁴⁷

Эдгээр аргуудад асуудлыг олон талаас авч үзэх, зорилго тодорхойлох, даван туулах зэрэг аргууд орно.

Асуудлыг олон талаас авч үзэх арга: Асуудлыг олон талаас харах гэдэг нь тухайн асуудлыг судлахын тулд санаа бодлыг нь өдөөж өгснөөр үйлчлүүлэгч асуудлыг өөрөөр харж чаддаг болоход нь туслах юм. Энэ арга нь үйлчлүүлэгчид, тухайлбал, хүүхдэд учраад буй асуудал, зөвлөгөө өгөх зорилго, давах туулах стратеги болон шийдлийг тодорхойлоход тусалдаг.

Зорилгоо тодорхойлох арга: Энэ нь зөвлөгөө өгөх үйл явцаас үйлчлүүлэгч чухам яг юу хүсэж байгаагаа тодорхой болгоход нь тусалдаг. Шийдлийг олохын төлөө үйлчлүүлэгч ажиллаж чадах ба өөрийн асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцоно. Хүрч болохуйц, тодорхой зорилго тавих нь үйлчлүүлэгчийг үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход дэмжлэг болдог.

Зөвлөгөө өгөхөд энэ аргыг хэрэглэснээр:

- Үйлчлүүлэгчийн анхаарал, үйлдэл нь төвлөрдөг.
- Үйлчлүүлэгчийн эрч хүч, хүчин чармайлтыг дайчилдаг.
- Тэсвэр хатуужилтай болгодог.
- Үйлчлүүлэгчийг төлөвлөгөөтэй болж, түүнийгээ хэрэгжүүлэхэд нь түлхэц болдог.
- Зөвлөгөө өгөх үйл явцыг чиглүүлдэг.

Даван туулах арга: Энэ арга нь асуудлыг шийдвэрлэх үйл явцад үйлчлүүлэгчийн давуу тал болон өөрт нь байгаа эерэг зан үйлийг бататгах, дадал болгох, уян хатан чанарыг суулгах арга юм. Даван туулах аргын нэг хэлбэр нь *эерэг зан үйлийн даван туулах арга* бөгөөд үүнийг хувь хүний дотоод чанар, эерэг зан төлөв/зан үйлийг болон нийгмийн чадваруудыг нь бататгах замаар тухайн үйлчлүүлэгчийн стрессийг даван туулахад дэмжлэг үзүүлэхийг ойлгоно.

⁴⁷ United Nations Children's Fund 2000 Third edition 2003 "TRAINING HANDBOOK ON Psychosocial Counselling for Children in Especially Difficult Circumstances" (Revised and updated)



3.5.4 Бусад аргууд⁴⁸

Зөвлөгөө өгөх явцад нөхцөл байдал, асуудлын онцлогоос хамааран төрөл бүрийн аргыг ашиглах нь зөвлөгөөг сонирхолтой, өвөрмөц, амжилттай болоход хэрэгтэй. Үйлчлүүлэгч бүр адилгүй, асуудал бүр өөр учир тухайн тохиолдлын онцлогт илүү тохирох аргуудыг хэрэглэвэл зохино. Жишээ нь: хүүхэдтэй, нас хувийн онцлогт нь тохирсон аргуудыг хэрэглэх хэрэгтэй (Хүүхдэд хэрэглэхэд тохиромжтой аргуудыг бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөх дараагийн бүлгүүдээс хараарай).

⁴⁸ United Nations Children's Fund 2000 Third edition 2003 "TRAINING HANDBOOK ON Psychosocial Counselling for Children in Especially Difficult Circumstances" (Revised and updated)

БҮЛЭГ 4. БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД НИЙГЭМ- СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ НЬ

Энэ бүлэгт бид бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга зүйн хүрээнд дараах асуудлуудыг авч үзэх болно. Үүнд: бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөхөд баримтлах өвөрмөц зарчмууд; хохирогч хүүхдийн нийтлэг онцлог, тэднийг хэрхэн ойлгох; хүүхдэд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйл явц ба алхмууд; хүүхдэд хэрэглэхэд тохиромжтой аргууд, хохирогч хүүхдийн гэр бүлийн гишүүдэд өгөх зөвлөгөө зэргийг онцлох болно.

4.1 ХОХИРОГЧ ХҮҮХДЭД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХӨД БАРИМТЛАХ ӨВӨРМӨЦ ЗАРЧМУУД

Зөвлөгч нь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөхдөө өмнөх гуравдугаар бүлэгт дурдсан нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөний үндсэн зарчмууд, зөвлөгчийн мэргэжлийн ёс зүйн зарчмуудыг баримталж ажиллахын сацуу доор дурдсан хүүхдийн эрхэд суурилсан ээлтэй үйлчилгээний зарчмууд хийгээд хүүхдийн бэлгийн хүчирхийллийн онцлогтой холбоотой өвөрмөц зарчмуудыг зөвлөгөөний бүх үе шатанд мөрдөж ажиллавал зохино.

4.1.1 Хүүхдийн эрхэд суурилсан ээлтэй үйлчилгээний зарчмууд:

- Хүүхэд хүндлэл болон хайр халамжийг хүртэх эрхтэй бие хүн учраас ямарч тохиолдолд хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавих;
- Хүүхдийн хувийн орон зай, нууцлал, нэр хүнд, аюулгүй байдлыг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх;
- Хүүхэд бүх төрлийн үйлчилгээний бүхий л үе шатанд мэдээлэлд суурилсан зөвшөөрөл өгөх боломжийг хангасан байх;
- Хүүхэд үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй тул ямар нэгэн байдлаар тэднийг шүүж зэмлэхгүй, буруутгахгүй байх;
- Хүүхдийн ашиг тусын тулд хийгдэж буй үйлчилгээ, үйл ажиллагаанууд хурдан шуурхай, хялбар, хүртээмжтэй байх;
- Хүүхэд өөрт хэрэгтэй халамж, үйлчилгээ, мэдээллийг хаанаас, хэзээ, хэрхэн авах талаар сонголттой байх;
- Хүүхэд өөрийнх нь асуудлаар гаргаж буй шийдвэр гаргах үйл явцын талаар мэдээлэлтэй байж, идэвхтэй оролцох;
- Хүүхдэд өгөх аливаа мэдээлэл нь тэдний насны онцлогт тохирсон, тодорхой, ойлгогдохуйц байх;
- Хүүхдэд үзүүлж буй аливаа үйлчилгээ нь тэдний нас, хөгжил, чадавх, хувийн онцлогт тохирсон байх;
- Хүүхдэд ээлтэй орчинд халамж, үйлчилгээг явуулах.

4.1.2 Бэлгийн хүчирхийллийн онцлогтой холбоотой өвөрмөц зарчмууд

1) Хохирогчийн аюулгүй байдлыг хангахыг нэн тэргүүнд авч үзэх: Хохирогч хүүхэд хүчин болон бэлгийн халдлагын тухай анх ярьж байхдаа айдас болон өөртөө итгэлгүй



байдлыг мэдэрч байдаг. Тэр ганцаар үлдэхээсээ айж болох бөгөөд түүний сэтгэл хөдлөлд мэдрэмжтэй хандах хэрэгтэй. Зарим хохирогчид, жишээ нь, гэртээ эргэн харьж чаддаггүй. Ийм тохиолдолд зөвлөгч аюулгүй газар очиход нь хохирогчид туслах ёстой.

2) Хохирогчийн сэтгэлийн шархыг нь дахин давтан хөндөхгүй байх: Хохирогчоор болсон явдлын талаар олон дахин яриулж сэтгэлийн шархыг нь хөндөхгүй байх, шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Гэвч амьдрал дээр хуулийн байгууллагаар асуудал шийдвэрлэгдэж дуустал байнга сөхөгдөж яригдах учир зөвлөгчид зарим талаараа хүндрэл учруулдаг. Гэхдээ сайн зөвлөгч тухайн асуудлыг хэрхэн даван туулах, ямар хугацаа зарцуулагдах, тухайн үе шатуудад ямар туслалцаа, дэмжлэг үзүүлэх талаараа мэдлэгтэй байвал энэ нь бэрхшээл болохгүй байх боломжтой.

3) Итгэлцлийн уур амьсгал бий болгох: Ихэнх хохирогч хүүхэд өөрт нь итгэхгүй байх гэж бодсоноос болоод болгоомжтой байж өөрийгөө хамгаалах байдалд ордог. Хэрвээ Зөвлөгч түүнд зүгээр л итгэж байгаагаа хэлэх юм бол хохирогч биеэ барихаа больж, юу болсон тухайгаа танд ярьж өгөх болно. Үнэн зөв мэдүүлж байгаа эсэхийг дүгнэх, нотлох нь зөвлөгчийн үүрэг биш, иймээс хэрвээ танд үйлчлүүлэгч тань худал ярьж байна гэсэн бодит нотолгоо байхгүй л бол итгэлцлийн уур амьсгал бий болгохыг оролдох хэрэгтэй.

4) Болсон явдалд хохирогч буруугүй гэдгийг хэлж ойлгуулах: Зарим тохиолдолд хохирогч хүүхдийг ойр дотнынхон нь шууд буруутгах хандлага гардаг. Мөн хохирогч өөрийгөө хамгаалж чадаагүй, буруутгагдахаас эмээн хуулийн байгууллагад хандахгүй тохиолдол олонтой байна. Иймд гэмт хэргийн хариуцлагыг хэрэг үйлдэгч үүрэх ёстой ба болсон явдалд чамд ямар ч буруу байхгүй гэдгийг ямар нэгэн хоёрдмол санаагүйгээр ойлгуулах хэрэгтэй.

5) Хохирогчийн мэдрэмж, сэтгэл рүү харах: Хохирогч хүүхдэд тайвшрах боломж өгч сэтгэл санааг нь засаад юу санаж байгааг нь өөрөөр нь сэтгэлээ онгойтол яриулахыг оролдох хэрэгтэй. Ийм аргаар та хамгийн үнэн зөв, дэлгэрэнгүй мэдүүлэг авах болно.

4.1.3 Зөвлөгчид тавигдах мэргэжлийн онцлог шаардлагууд

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг хэрэгжүүлж буй Зөвлөгч нь:

- Жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний дотор бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн асуудлаар сургагдсан, зөв мэдлэгтэй;
- Бэлгийн хүчирхийллийн түгээмэл тохиолддог хэлбэрүүдэд өртсөн хохирогч/хохирогч хүүхдийн кейс менежментийн зохистой дадал эзэмшсэн;
- Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч/хохирогч хүүхдэд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх, нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үр чадвартай;
- Хүчирхийллийн хохирогч хүүхэд эмэгтэйчүүдийг эрхийг хамгаалах, хэнийг ч үл буруутгах, үл алагчлах, хохирогчийн зовлон шаналлыг ойлгох, чин сэтгэлээсээ үйлчлэх эерэг хандлагатай;
- Хохирогчтой ажиллах явцад өөрийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, сэтгэл хөдлөлөө зохистой удирдах чадвартай байх;
- Монгол Улсын Стандартад (MN 6949:2021) заасан Нийгмийн ажил үйлчилгээний бусад нийтлэг шаардлагуудыг хангасан байвал зохино.

ПРАКТИК ЗӨВЛӨМЖ

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд зөвлөгөө өгч буй Зөвлөгч нь хохирогч төвтэй хүний эрхийн хандлагад суралцан, аливаа гарцыг хайхдаа хохирогч хүүхдийн эрх ашгийг хамгаалах талд ажиллах ёстой. Нийтээрээ тэр хохирогчийг үгүйсгэж байсан ч, Та түүний талд бат зогсож чадвал асуудал эерэгээр шийдвэрлэгдэхэд нөлөөлж чадна.

4.1.4 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд зөвлөгөө өгөхөд хориглох зүйлүүд

- Хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан үзэхгүй алагчлах, гутаан доромжлох;
- Хүүхдийг үл тоох, буруутгах, загнах, зандрах, доромжлох;
- Хүүхдийн хувийн болон мэдээллийн нууцыг задруулах;
- Хүүхэд өөрөө зөвшөөрөөгүй байхад хүчээр ганцаараа байхад нь ярилцлага хийх;
- Тусгаарлаагүй орчинд, гадны хүний (эсвэл олон хүний) дэргэд ярилцлага авах;
- Хүүхэдтэй эсрэг хүйсийн хүн ярилцлага хийх;
- Яриандаа албаны үг хэллэг, хуулийн зүйл заалт ашиглах;
- Хэт сэтгэл хөдлөл дор ярилцлага авах;
- Өөрийн үзэл бодлоо тулгах, шаардах;
- Хүүхэдтэй хувийн дотно харилцаа үүсгэх, бэлэг сэлт авах;
- Зөвлөгч өөрийн урьдчилсан таамаг, дүгнэлтдээ хөтлөгдөх;
- Хүүхэд өөрийгөө гэмтээхээр төлөвлөж буйг мэдсээр байж шаардлагатай арга хэмжээ авахгүй байх;
- Хохирогч, түүний гэр бүлээр шийдвэр гаргуулахгүй, зөвлөгч өөрийн шийдвэр дүгнэлтээ тулгах.

ПРАКТИК ЗӨВЛӨМЖ

- Зөвлөгчийн зүгээс үзүүлж буй хохирогч хүүхдийг буруутгасан, ялгаварласан, үл тоосон, хэрэгцээг нь үл ойшоосон хандлага, Зөвлөгчийн хувийн ташаа итгэл үнэмшил, таагүй зан байдал зэрэг нь “энд хэрэггүй ирлээ”, “намайг хэн ч тоодоггүй”, “хэн ч надад туслах боломжгүй юм байна” гэсэн сэдэл төрүүлж, хүүхдийг дахин хохироох эх үүсвэр болдог.
- Иймд бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ажиллахдаа Зөвлөгч нь мэргэжлийн ёс зүйн нэг л алдаа гаргах тохиолдолд үйлчлүүлэгчид “ХОЁРДАГЧ ХОХИРОЛ” гарах үндэслэл бүрддэгийг онцгой анхаарч ажиллах хэрэгтэй.

4.2 БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДИЙГ ОЙЛГОХ НЬ

4.2.1 Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд гэж хэнийг хэлэх вэ?

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хэн ч байж болно. Гэхдээ ихэвчлэн охид, эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийллийн хохирогч болдог. Гэмт хэргийн онцлогоос хамааран манай улсын холбогдох хуулиудад **“ХОХИРОГЧ”**-ийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2017)
<p>8.1. “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ”.</p>	<p>3.1.2. Хохирогч гэж “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн хүнийг хэлнэ”.</p>	<p>5.1.2. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч гэж “гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг хэлнэ”.</p>

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тодорхойлсон Монгол Улсын Стандартын (MNS 6040:2019) нэр томъёоны тайлбар хэсэгт: ... “**хохирогч** гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон, эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүнийг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг.

“**ХОХИРОГЧ ХҮҮХЭД**” гэдэг нэр томъёог хэрхэн ойлгох вэ? Хүүхдийн эрхийн Конвенцод 18 нас хүрээгүй бол “**ХҮҮХЭД**” гэж тодорхойлсон. Манай улсын Эрүүгийн хэрэг байцаан шийтгэх тухай хуульд 14 наснаас доош хүнийг “**БАГА НАСНЫ ХҮҮХЭД**” гэж тодорхойлсон байдаг.

Монгол Улсын Иргэний хуулийн 15 дугаар зүйлд зааснаар иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар 18 наснаас эхэлдэг бөгөөд насанд хүрээгүй буюу 14-18 нас хүртэлх хүүхэд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байдаг учраас насанд хүрээгүй иргэн хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцлийг хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийн үндсэн дээр хийх хуулийн зохицуулалттай.

Иймд 14 настай хүүхэд бие бялдрын хөгжлийн хувьд 16 эсхүл түүнээс дээш настай байх боломжтой буюу харагдах байдлаар бусдыг төөрөгдөлд оруулахаар байсан ч эрх зүйн чадамжийн хувьд бэлгийн харьцааны талаарх хүсэл зоригоо бүрэн илэрхийлэх чадамжгүй⁴⁹ гэж үзнэ.

4.2.2 Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн нийгэм-сэтгэл зүйн онцлог

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн нас, өөрийгөө илэрхийлэх чадамж, бэлгийн хүчирхийллийн ямар хэлбэрт өртсөн зэргээс хамаарч тэдний нийгэм сэтгэл зүйн байдал өөр өөрийн онцлогтой. Зөвлөгч нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөхдөө тэдний нийтлэг болон өвөрмөц онцлогуудыг сайтар судалсан, өгч буй мэдээлэл зөвлөгөөндөө тэдгээр онцлогуудыг тооцсон байх шаардлагатай. Энд бид бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн **НИЙТЛЭГ ОНЦЛОГУУД**-ыг танилцуулах ба дараагийн бүлэгт хохирогч хүүхдийн онцлогийг насны бүлгээр, зарим хүчирхийллийн онцлогоор тус тусад нь авч үзэх болно.

Хүүхэд, өсвөр үеийнхэн бол нийгэм-сэтгэл зүйн хувьд бүрэн төлөвшөөгүй, эцэг, эх, асран хамгаалагчаас эдийн засаг, бие махбод, бусад нөхцөл байдлын талаар бүрэн хараат, өөрийгөө илэрхийлэх чадвар дутмаг, тийм боломж нь хязгаарлагдмал, өөрийгөө хамгаалах эрх зүйн бүрэн чадамжгүй, нэр төр, алдар хүнд гэдэг үгний утгыг бүрэн ойлгоогүй үедээ өсөж хөгжиж яваа онцлогтой билээ.

⁴⁹ Иргэний тухай хууль, 2002 он, 16-17-р зүйл

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд нь насанд хүрээгүй тул асуудлыг бүрэн ойлгоогүй, мэдээлэлжсэн зөвшөөрөл өгөх чадамжгүй, бие, сэтгэлзүйн хөгжлийн хувьд бэлтгэлгүй, бэлгийн харьцааны талаар бүрэн ойлголтоггүй, хүчирхийллийг зогсоох чадваргүй байдаг. Иймээс бэлгийн хүчирхийлэлд өртсөний дараа хохирогч хүүхдэд дараах нийгэм-сэтгэл зүйн онцлог байдлууд түгээмэл илэрдэг. Үүнд:

1) Бэлгийн хүчирхийллийг тэд гэмт хэрэг гэж үзэхээс илүү ичгүүртэй байдал гэж ойлгодог:

Тэд энэ тухай үнэн зөв ярьснаараа бусдыг хүнд байдалд оруулж байна гэж ойлгосон эсхүл гэр бүлийн нөлөөлөлд автсан байдаг. Тэдэнд гэмт хэргийн улмаас бий болсон хор уршгийг тодорхойлох бүрэн чадвар хараахан суугаагүй байдаг. Иймээс тухайн асуудлыг аль болох мартахыг хүсэж, хэн нэгэнтэй хуваалцах, хэн нэгнээс тусламж авахыг төдийлөн хүсдэггүй.

2) Хохирогч хүүхдүүд ихэнхдээ заналхийлэл, сүрдүүлэгт автсан байдаг:

Насанд хүрээгүй хохирогч нь бие даах чадваргүй, хүчирхийлэгч нь эрх мэдэлтэй, нөлөө бүхий хүн байдгаас ямар нэгэн аюултай зэвсэг хэрэглээгүй байсан ч заналхийлэл болон сүрдүүлэг үйлчилдэг. Заналхийлэл нь үг хэлээр илэрдэг. Жишээ нь, гэмт этгээд үйлдсэн хэргийнхээ талаар хүнд хэлэхгүй байхыг шаардах, "хэлбэл ээж болон ойр дотны хүмүүст нь муу зүйл учруулна", "өөрийг нь болон гэр бүлийн гишүүдээс нь хамгийн хайртай хүнийг нь ална" гэх мэтээр сүрдүүлж заналхийлдэг.

Хүчирхийлэгч үг хэлээр заналхийлж сүрдүүлэхийн зэрэгцээ хохирогчийг чимээгүй байлгахын тулд байнгын эсвэл давтамжтайгаар сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэх, үйлдлийг хянах, шийтгэх хүч хэрэглэх, бие махбодын хүчирхийлэл үйлддэг. Зарим тохиолдолд гэмт этгээд өөрт нь болон ойр дотны хэн нэгэнд нь хүч хэрэглэн болсон зүйлийн талаар хүүхдийг бусдад хэлүүлэхгүй байх арга хэмжээ авдаг.

Иймэрхүү айлган сүрдүүлэлт, заналхийлэл, дарамт зэрэг нь хохирогч хүүхдийн сэтгэл зүйд хүчтэй нөлөөлдөг бөгөөд хохирогч болсон явдлыг удаан хугацаагаар бусдаас нуух, ичих, айх зэргээс шалтгаалж тухайн этгээдийн гэмт халдлагад дахин өртөх, бие махбодын болон сэтгэл зүйн хүнд хор уршиг бий болох зэрэг нөхцөл бүрддэг.

3) Зарим хохирогч хүүхэд эргэлзэж, гэмшдэг:

Бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаа зарим хүүхэд түүнд яг юу тохиолдоод байгаад эргэлзэж энэ талаар хүнд хэлэхээс айдаг. Энэ нь хэд хэдэн шалтгаантай. Тухайлбал, хүчирхийлэгч этгээд хохирогч хүүхдүүдэд тохиолдсон зүйлийн талаар "ээж чинь угаасаа мэдэж байгаа", "чамд хэн ч итгэхгүй", "нууцыг хадгал", "хэнд ч хэлж болохгүй", "чамд хайртай болохоороо биеэ барьж чадсангүй" гэх мэт хүүхдийн сэтгэхүйн онцлогт тааруулан хэлдэг бөгөөд ихэнх тохиолдолд тэднийг айлган сүрдүүлсэн, дарамталсан, саймшран дасгаж, ойр зуурын хэрэглээний зүйлсээр хуурч "хахуульдсан" байдаг. Зарим тохиолдолд, ялангуяа хохирогч нэлээд урт хугацаанд бэлгийн хүчирхийлэлд байсан тохиолдолд хохирогчийн болон хайртай хүмүүсийнх нь амь насанд нь бодитой мэтээр заналхийлсэн байдалтай байдаг.

4) Томчуудад итгэх итгэлээ алдах:

Хүүхдийн хэн нэгэнд итгэх итгэл, хайрлах сэтгэл нь алдагддаг. Ялангуяа хүүхэд болж буй асуудлыг зориглож хэлсэн ойрын итгэлт насанд хүрсэн хүн нь өөрт нь итгээгүй, эргэлзсэн, үгүйсгэсэн хандлагыг гаргасан бол томчуудад итгэх итгэлээ бүр алддаг. Мөн гэр бүлийн хэн нь ч үүнийг анзаарч, зогсоож чадахгүй байгаад уурлаж бухимддаг. Тэд аюулгүй байдлаа алдсанаа мэдэрснээр бусдад итгэх итгэл нь алдагдаж, бусадтай харилцах харилцаанд нь ноцтой асуудал, эмзэг мэдрэмтгий байдал бий болсныг мэдэрдэг.



5) Өөрийгөө буруутгах, ичиж гутрах: Тохиолдсон явдалд өөрийгөө маш ихээр буруутган, ичиж зовж гутардаг. Энэ байдлаасаа болоод тохиолдсон зүйлээ бусдад хэлэхгүй нуусаар байдаг. Эцэг эхийнхээ үгэнд ороод би *“цахимаар танилцаж, очиж уулзаагүй бол...”*, *“гэртээ ганцаараа байхдаа хамаатан, сайн таньдаг хүнд итгэж оруулаагүй бол...”*, *“ээжийг ажилтай өдөр эмээгийн дээ очоод хоносон бол...”* гэх мэт шалтгаануудыг өөртөө бодож олон өөрийгөө буруутгасаар байдаг. Хүүхэд гадна байдалдаа эвгүй харьцаа гаргаж байгаа нь дотроо маш их шаналгаатай, сэтгэлзүйн хувьд яаралтай туслалцаа шаардлагатай байгааг илэрхийлж байна гэж үзэх хэрэгтэй.

6) Өөрийн үнэлэмж, хүндэтгэл нь унах: Тэд өөрийгөө арчаагүй, сул дорой байдлаар мэдэрсэн байдаг тул энэ нь хохирогчийг өөрийгөө доогуур үнэлэхэд хүргэсэн байдаг. Хэнд ч хэрэггүй болсон гэсэн мэдрэмж төрүүлдэг. Ялангуяа гэр бүлийнхний зүгээс хүүхдийг буруутгасан хандлага гаргахад өөрийгөө дорд үзэх үзэл нь улам нэмэгддэг. Зарим тохиолдолд энэ байдал нь даамжирвал амиа хорлох оролдлого хийхэд ч хүргэж болно.

7) Өөрийгөө гэмтээх: Өөрийгөө болсон явдалд оролцсон, зөвшөөрсөн гэж үзэн өөрийгөө үзэн яддаг. Энэ бол өөрийгөө буруу ойлгож байгаагийн нэг илрэл юм. Мөн тэд архидан согтуурах, мансуурах бодис хэрэглэх, хоол идэх зуршилгүй болох эсвэл хэт их идэх, гадуур тэнэх, гэмт хэрэгт холбогдохоос гадна өөрийгөө гэмтээж шийтгэх нь ч бий.

8) Бэлгийн зан үйлийн хэвийн бус байдал илрэх: Олон хохирогч хүүхдийн бэлгийн амьдралын тухай үзэл бодол, бэлгийн мэдрэмж нь хэвийн бус болдог. Тэд насанд хүрсэн хойноо болзоонд очихоосоо айх, хүнд итгэх итгэлгүй болсон байдаг. Мөн гэр бүлтэй болсны дараа өөрөө энэ хэргийг үйлдсэн тохиолдол цөөнгүй бүртгэгдсэн байдаг. Нөгөө талаар хүнд итгэж хайртай болох, бэлгийн ханамж таашаал авах мэдрэмж нь хэвийн бус болдог. Зарим хохирогч бэлгийн харилцаанд хэт их сонирхолтой, эсвэл дургүй, эрчүүдийг (эмэгтэйчүүдийг) үзэн ядагч болдог байна.


Гэмт этгээдүүд хүүхдийн **ЭМЗЭГ БАЙДЛЫГ** ашигладаг. Тэд гэмт үйлдэлдээ арганд нь амархан автах, ятгалгад хялбар өртөх боломжтой, эцэг эхийн хараа хяналт, хайр халамж сул, эмзэг, үл хайхрагдсан буюу шоовдорлогдсон, хүчирхийллийн эрсдэлд байгаа хүүхдийг голдуу сонгодог. Иймд Зөвлөгч нь эдгээр хүүхдүүдэд онцгой анхаарах шаардлагатай.

Хүүхэд хамгааллын тухай хуульд **“ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД БАЙГАА ХҮҮХЭД”** гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг ойлгоно⁵⁰ гэж тодорхойлсон.

⁵⁰ Хүүхэд хамгааллын тухай Монгол Улсын хууль, Төрийн мэдээлэл, 2016 он, №9

4.3 БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДЭД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ АЛХМУУД

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйл явцыг доорх **5 ҮЕ ШАТААР** хэрэгжүүлнэ. Гэхдээ тухайн хохирогч хүүхдийн нас, хувийн онцлог, нэн тэргүүний хэрэгцээ, нөхцөл байдлаас шалтгаалан зөвлөгөө өгөх явц тохиолдол бүрд яг энэ дэс дарааллаар явна гэж байхгүй, уян хатан байх шаардлагатай болдог.



Нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйл явцыг доорх алхмуудаар хэрэгжүүлнэ. Үүнд:

4.3.1 Холбоо тогтоох анхны уулзалт

Зөвлөгч нь анхны уулзалтад маш их ач холбогдол өгөх хэрэгтэй. Учир нь анхны уулзалт зөвлөгөөний зорилго, цаашдын стратегийг тодорхойлох, зөвлөгөө үр дүнтэй болоход маш чухал. Анхны уулзалтын эхэн үед хамгийн гол нь хохирогчийн **АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТАЙТГАРАЛ, ИТГЭЛЦЭЛ** бий болгох, хохирогчийн санаж чадах зүйлийг баримтжуулахад анхаарлаа хандуулах хэрэгтэй. Үүний тулд Зөвлөгч нь хохирогчийн тав тухыг анхааралтай ажиглаж, хохирогчдод итгэж, асуудалд нухацтай хандах хэрэгтэйг итгүүлэх, үйлчлүүлэгч өөрийн асуудалдаа эзэн болохыг дэмжих замаар ажиллавал илүү үр дүнтэй байдаг.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүд насны онцлогоос шалтгаалан ихэнхдээ гэр бүлийн гишүүдийн хамт, эсвэл зөвхөн гэр бүлийн гишүүд нь ирж зөвлөгөө авах нь түгээмэл байдаг ч өсвөр насны хүүхдүүд ганцаараа, эсвэл үе тэнгийн найз нөхөдтэйгээ хамт ирэх нь цөөнгүй байдаг. Зарим тохиолдолд тэдний эцэг эх, ойр дотныхон нь эсвэл эмч, багш, нийгмийн ажилтан, хүүхэд хамгааллын болон хуулийн байгууллагын ажилтнууд зөвлөгчид хандахыг зөвлөсөн байдаг. Тэд өөрсдөө зөвлөгөө авахаар хандаж байгаа юу эсвэл хэн нэгэн хүн түүнийг очихыг зөвлөсөн эсэхийг мэдэх хэрэгтэй. Учир нь хохирогч хүүхэд өөрөө хүсээд зөвлөгөө авахаар ирсэн үү, хэн нэг хүний хүсэлт ятгалгаар ирсэн үү гэдгээс шалтгаалаад хохирогчийн хүсэлт өөр байж болно. Хүүхэд хэнтэй ирснээс үл хамааран хүсэж буй хүсэлтийг шийдвэрлэхээр хамтран ажиллах нь Зөвлөгчийн нэн тэргүүний үүрэг юм.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд ба гэр бүлийн гишүүд зөвлөгөө авахаар ирэхдээ **АЙДАС** ба **ИТГЭЛ** гэсэн хоёр хүчтэй мэдрэмжтэйгээр ирдэг. Иймээс Зөвлөгч нь анхны уулзалтаар итгэл найдвар төрүүлж, айдсыг багасгах шаардлагатай болдог. Зөвлөгч болон үйлчлүүлэгч хоёр хэр зэрэг хамтран ажилласнаас зөвлөгөөний үйл явц түүний үр дүн хамаарна гэдгийг зөв тайлбарласнаар тэдний түгшүүр багасдаг. Түгшүүрийг мөн үйлчлүүлэгчийг тухтай сууж, тайвшрахыг хүссэнээр ч багасгаж болно.

ПРАКТИК ЗӨВЛӨМЖ

Анхны уулзалт юунаас эхлэх вэ?

- Анхны уулзалт үйлчлүүлэгчдийг угтан авч, урьж суулгаад танилцахаас эхэлнэ.
- Юуны өмнө зөвлөгөө авахаар ирсэнд нь талархлаа илэрхийлээрэй.
- Үйлчлүүлэгчтэй танилцахдаа гар барих нь нөхөрсөг хандаж буй, туслахад бэлэн байгааг илэрхийлдэг.
- Өөрийгөө танилцуулахдаа нэрээ, ажил үүргээ тодорхой хэлэх хэрэгтэй.
- Зөвлөгч хүүхдийн овог нэрийг асуусны дараа түр зогсолт хийх хэрэгтэй. Энэ нь анхны уулзалтын үед үүсэх тайван бус байдал, айдсыг багасгахад тусалдаг.
- Хүүхдэд болон гэр бүлийн хүнд зөвлөгөөний үйл явцыг танилцуулаарай. Үүний дараа тэдний тайван бус байдал нь харьцангуй багасна.
- Өөр хэн нэгэнд энэ асуудлаараа хандсан эсэхийг асуух, хэрэв тийм бол: хэнд, хэзээ хандсаныг тодруулаарай.
- Хохирогч хүүхэд болон дагаж ирсэн гэр бүлийн хүн өрөөнд анх орж ирэхээс тэдний гадна төрх, сэтгэл санааны байдлыг нь сайтар анзаараарай.

Цаашилбал, Зөвлөгч та үйлчлүүлэгчидтэй анх уулзаад нүүр тулж ярилцахдаа “жигжиг зүйл” гэлтгүй суух байрлал, өөрийн биеийн хэлэмжиндээ дараах зүйлүүдийг анхаараарай. Үүнд:

- Ширээ, сандлын байрлалыг маш сайн тооцоолж, хэт их хол зай, өндөр ширээгүй байхаар төлөвлөсөн байвал харилцаа үүсэхэд илүү дөхөмтэй.
- Байрлалын хувьд зөвлөгч, үйлчлүүлэгч хоёр бие биеэ бүрэн харж байхаар суугаарай. Энэ нь үйлчлүүлэгчид “би тантай хамт байх сонголт хийлээ, тантай ярилцахад бэлэн байна” гэсэн санааг илэрхийлдэг.
- Хөлөө ачих, элгээ тэврэх, гар утсаар ярих, мессэж бичих зэрэг үйлдэл битгий хийгээрэй. Ингэснээр зөвлөгч үйлчлүүлэгчийн ярих, нээлттэй байх бүх зүйлийг хүлээж авахад бэлэн байгааг харуулна.
- Үйлчлүүлэгчдээ аажим аажмаар ойртоорой. Ингэснээр “би тантай хамт байна, таны ярих зүйл надад сонирхолтой байна” гэсэн санааг илэрхийлдэг. Үйлчлүүлэгчид хэт хурдан ойртож дөхөх нь түгшүүр төрүүлдгийг анхаарах хэрэгтэй.
- Үйлчлүүлэгчтэй нүдээрээ харилцаа холбоо тогтоож харилцаарай. Энэ нь анхаарал татаж, сонирхолтой байгааг харуулдаг ба эхний харилцаанд маш их ач холбогдолтой. Гэхдээ тасралтгүй ширтэх ёсгүй.
- Мөн зөвлөгч харцаа тогтвортой байлгахгүй байгаа нь үйлчлүүлэгчид өөрөөс нь залхсан мэт сэтгэгдэл төрүүлдэг.
- Зөвлөгөө өгөх үед бараан өнгийн шил зүүх нь нүдний харилцаа алдагдахад хүргэдэг тул таны нүд үйлчлүүлэгчид харагдахаар шил сонгох нь зүйтэй.
- Дуу хоолой, дууны өнгө зэргээ тайван хандлагатай байлгах хэрэгтэй.

4.3.2 Болсон явдлын талаар яриулах (ярилцлага)

Ярилцлагыг эхлэхийн өмнө үйлчлүүлэгчид юуг мэдээлэх вэ?

(a) Хэрэв хохирогч хүүхэд болсон явдлын талаар ярих боломжтой насны хүүхэд, тэгээд өөрөө зөвшөөрч байвал түүнтэй ганцаарчлан ярилцах боломжийг бий болгох хэрэгтэй. Энэ талаар хүүхдэд болон хамт ирсэн хүнд нь тайлбарлаж шийдээрэй.

(b) Мөн энд болж буй яриа нууц хэвээр үлдэнэ, гэхдээ энэ бол ноцтой гэмт хэрэг учраас цагдаагийн байгууллагад мэдээлэх, хууль хяналтын байгууллагаас эрхзүйн туслалцаа авах шаардлага гарна. Энэ нь хохирогчийн нэр төрд сөргөөр нөлөөлөхгүй гэдгийг зөвлөгөөг эхлүүлэхийн өмнө хүүхдэд болон гэр бүлийн гишүүдэд тайлбарлаж өгсөн байх хэрэгтэй.

Ярилцлагаа хэрхэн эхлэх вэ?

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчтой маш тайван, итгэлтэйгээр харилцаж эхлээрэй. Эхний удаа хамгийн бага баримтжуулалттай ярилцлага хийх ба яаралтай тусламж хэрэгтэй байгаа эсэхийг олж мэдэх хэрэгтэй. Хэрэв шуурхай арга хэмжээ авах шаардлага байхгүй бол үе шаттайгаар гүнзгийрүүлсэн ярилцлага хийнэ.

Зөвлөгч нь ярилцлагыг эхлэх **ЭХНИЙ АСУУЛТ**-ыг маш сайн бодох хэрэгтэй. Жишээ нь яриагаа эхлэхдээ хүүхдэд дараах асуултуудыг эхлээд тавьж болох юм.

- Чи яриагаа юунаас эхлэхийг хүсэж байна?
- Ямар хүндрэлтэй асуудал тулгарсан учраас чи наашаа ирсэн билээ?
- Бид юуны талаар ярилцах вэ? гэх мэт.

Болсон явдлыг яриулахдаа хүүхэд ямар нэг хязгаарлалтгүйгээр ярих боломжийг олгосон байх ёстой. Шаардлагатай гэж үзвэл нээлттэй асуулт тавьж болох ч заавал хариу авах гэж шахах хэрэггүй. Зөвлөгөөний явцад "тийм", "үгүй" гэсэн товч хариулт өгч болохуйц хаалттай асуулт тавихаас зайлсхийгээрэй. Мөн "яагаад" гэсэн үгээр эхэлсэн асуулт битгий тавиарай. Жишээ нь: "Яагаад чи хүргээд өгье гэсэн урилгыг хүлээж авсан юм бэ?"; "Яагаад чи тэднийд очсон юм бэ?"; "Яагаад чи эсэргүүцэл үзүүлээгүй юм бэ?" гэх мэт. Мөн хүүхдэд олон асуулт дараалан тавих хэрэггүй. Учир нь тэр хаанаас нь эхэлж хариулахаа ойлгохоо больдог.

Ярилцлагыг үр дүнтэй болгоход юуг анхаарах вэ?

Хүүхэдтэй бэлгийн хүчирхийллийн талаар нээлттэй ярилцах, ярилцлагыг үр дүнтэй болгоход дагаж мөрдөх чухал дүрмүүд байдаг. Үүнд:

1) Ганцаарчлан ярилцах: Бэлгийн хүчирхийлэл нь маш ээдрээтэй, хохирогчийн дотоод сэтгэл, нэр төрийг хөндсөн шинжтэй байдаг учраас үйлчлүүлэгчийн хувийн нууц, нэр төрийг хамгаалах үүднээс ганцаарчилсан, зөвхөн тухайн тохиолдолд хэрэглэж болох өвөрмөц арга барилыг сонгон авах шаардлага тулгардаг. Иймд ганцаарчлан ярилцлах боломжтой хүүхдэд жишээ нь өсвөр насны хүүхдэд зөвлөгөө өгөхөд ганцаарчилсан зөвлөгөө илүү тохиромжтой. Учир нь хүүхдүүд ихэвчлэн гэр бүлийнхнээсээ айж ичээд тэдний дэргэд болсон явдлыг бүтэн илэрхийлж нээлттэй чөлөөтэй ярьж чаддаггүй.

2) Тайвшруулах: Хүүхдийн сэтгэл түгшсэн, ярихад хүндрэлтэй байгаа бол юуны түрүүнд түүний сэтгэл санааны байдлыг асууж туслах эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлж тайвшруулах шаардлагатай. Мөн болсон зүйлд чи огт буруугүй, өөрийгөө буруутгах хэрэггүй гэдгийг хэлж ойлгуулах хэрэгтэй.

3) Анхааралтай сонсох: Юу болсон талаар хүүхэд өөрөө өөрийнхөө үгээр чөлөөтэй ярих боломж олгоод анхааралтай сонсох хэрэгтэй. Хүүхдийг аль болох тасралтгүйгээр үргэлжлүүлэн яриулахыг хичээгээрэй. Өөрийг нь үнэхээр анхааралтай сонсож байгаа гэдгээ хүүхдэд мэдрүүлэх нь чухал. Хүүхдийн яриаг сэдвээс нь хазайлгахгүйгээр чиглүүлэх хэрэгтэй. Янз бүрийн нарийн ширийн зүйлийг асуухгүй байх, шууд ярилцлага авахгүй, хүүхэд юу ярихыг л анхааралтай сонсох хэрэгтэй.

4) Хүүхдэд итгэх, илгэлтэй байдал төрүүлэх: Хэрвээ хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөнөө, өртөж байгаа талаар хэлбэл энэ тухай ярьж байгаа нь сайн хэрэг гэдгийг хэлж, түүнийг маш их дэмжээрэй. Зөвлөгч та хүүхдийн ярианд итгэх хэрэгтэй. Түүний ярьсан тэр хүн хүчирхийлэгч этгээд гэдэгт итгэхэд хэцүү байсан ч итгэх хэрэгтэй. Учир



нь хүүхэд бэлгийн хүчирхийллийн сэдвээр худлаа ярьдаггүй. Мөн та шүүгч биш учир хохирогчийн ярьж байгаа зүйлийн үнэн эсэхэд эргэлзэх шаардлагагүй. Та хүүхдэд туслах зорилгоор ямар нэгэн зүйл хийнэ гэдгийг хүүхдэд ойлгуулах нь чухал.

5) Тайван байж шаардлагагүй үйлдэл хийхгүй байх. Таны уур хүрч болно. Тэгвэл таны уур хүүхдээс болж хүрээгүй гэдгийг ойлгуулах хэрэгтэй. Үйлчлүүлэгч өөрийн түүхээ ярьж байхад инээх, уйлах, үйлчлүүлэгчийн яриаг тасалдуулах үйлдлүүд гаргаж огт болохгүй. Тухайн асуудал дээр яарч тайлбар, дүгнэлт хийх хэрэггүй.

6) Тулгаж шахаж шаардаж болохгүй. Хүүхдийг заавал бүгдийг ярих ёстой гэж тулгах хэрэггүй. Ямар нэг байдлаар өөрийн амьдрал, харилцаа, мэдрэмжийнхээ талаар илүү их ярихыг тулгавал айж, ичээд дараагийн удаа ирэхгүй байх магадлалтай.

7) Харилцаандаа дүн шинжилгээ хийх: Зөвлөгч нь хүүхэдтэй хийсэн ярилцлага бүрийнхээ дараа ярьсан зүйлийг нь нэгтгэн, болж өгвөл ярилцлага бүртээ гарчиг өгөх. Гэвч өмнөх ярилцлагаас төдийлөн шинэ мэдээлэл нэмэгдээгүй бол ингэх нь зохимжгүй байж болох юм. Харилцаандаа дүн шинжилгээ хийхийн тулд хүүхдийн хэлэх гэсэн санааг зөвлөгчийн хувьд зөв ойлгосон эсэхээ шалгаарай.

8) Давтагдаж байгаа үг ярианд анхаарлаа хандуулах: Ярилцлагын явцад хүүхдийн ярианд давтагдаад байгаа үг, санаа нь хамгийн хүчтэй хариу үйлдэл, илүү сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлж байдаг. Тэр давтагдаж буй үг яриа нь өвөрмөц “түлхүүр” үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ярилцлагыг үр дүнтэй явуулахад тусалдаг.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй ярилцахдаа болж өнгөрсөн үйл явдал дээр хэт төвлөрсөн, уламжлалт ярилцлагын арга зүйг ашиглах нь зарим тохиолдолд сэтгэлзүйн хямралын үр нөлөөг улам дордуулж ч болдгийг анхаараарай.

Анхны уулзалтын дараа хүүхдийн гэр бүлийн хүн зөвлөгчтэй хэдэн удаа уулзах ёстой талаар асуудаг. Энэ тохиолдолд *“Асуудалтай тодорхой танилцахын тулд цаг хугацаа шаардлагатай. Үйлчлүүлэгчид асуудлыг шийдэх нь нэг удаагийн үйлдэл биш удаан үргэлжлэх үйл явц”* гэдгийг товч тайлбарлаж өгөх хэрэгтэй.

ПРАКТИК ЗӨВЛӨМЖ

Зөвлөгөө өгөх үед харилцаагаа эерэг болгохын тулд юуг анхаарах вэ?

- Тодорхой байх
- Харцаа төвлөрүүлэх
- Хүүхэд амгалан тайван нөхцөлийг бүрдүүлэх
- Халуун дулаан уур амьсгалтай нээлттэй байх
- Хүлээн зөвшөөрсөн аястай байж, түгшүүртэй байдал бий болгохгүй байх
- Анхаарал хандуулж, хариу үйлдэл үзүүлэх
- Хүүхдийн илэрхийлж буй аман бус илэрхийллүүдийг ойлгохыг хичээх
- Хүүхдийг идэвхжүүлэх, урамшуулах үүднээс санааг нь зарим үед давтан хэлэх
- Хүүхэд бодол, санаа, сэтгэл хөдлөл, мэдрэмжээ илэрхийлэх боломж олгох
- Биеийн хэлэмжүүдийн зөв хэлбэрүүдийг ашиглах (толгой дохих, шаардлага гарвал биед нь зөв хэлбэрээр хүрэх)
- Хүүхэд өөрийн асуудал бэрхшээлээ ойлгох, зөв тодорхойлоход нь туслах
- Хүүхдийн нөхцөл байдлуудыг үе үе дүгнэн тоймлож байх
- Шүүмжлэхгүй байх
- Хүүхдийн тодорхой бус асуудлыг нягтлан ойлгох үүднээс лавлах
- Шаардлагатай гэж үзвэл дуугүй байх боломж олгох
- Яриандаа энгийн үг хэллэг ашиглах, албан хэллэг, хуулийн заалт мэтийг ашиглахгүй байх хэрэгтэй.

4.3.3 Хохирогчийн хүсэж буй зүйлийг олж мэдэх, шуурхай арга хэмжээ авах

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд өгөх зөвлөгөөний **НИЙТЛЭГ ЗОРИЛГО** нь *бэлгийн хүчирхийллээс үүдэлтэй хүндрэлтэй асуудлаа ойлгох, хямралын үеийг даван туулах, улмаар хэвийн амьдралдаа эргэн ороход нь тэдэнд дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг*. Хүүхэд юу хүсэж байгаа, юуг чухалчилж байгааг мэдэх нь зөвлөгөөний зорилгоо тодорхойлох, ач холбогдлоор нь эрэмбэлэхэд гол чиглүүлэгч болдог.

Юуны өмнө хохирогч хүүхэд болон гэр бүлийн гишүүдийн ярианаас яг одоо хохирогчид тулгараад буй хамгийн гол хүндрэлтэй асуудал **НЭН ТЭРГҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ** юу болохыг олж мэдэх нь Зөвлөгчийн эхний зорилт байх болно. Зарим үйлчлүүлэгч эмнэлгийн тусламж авахад тусалцаа хүсэж ирдэг бол зарим нь хуулийн байгууллагад хандан асуудлаа шийдвэрлүүлэхэд тусалцаа хүсэж байдаг, зарим нь зүгээр зөвлөгөө авах зорилгоор ирдэг. Иймд тэдний нэн тэргүүний хэрэгцээнээс хамаарч Зөвлөгч нь дараах шуурхай хариу арга хэмжээг авах шаардлагатай.

- Хохирогчид эмнэлгийн тусламж шаардлагатай эсэхийг тодорхойлж, яаралтай тусламж шаардлагатай бол түргэн тусламж дуудах, холбогдох эмнэлэгт хүргэх.
- Хүүхэд ураг төрлийн хүчирхийллийн хохирогч болсон тохиолдолд хүчирхийлэгч тусгаарлагдаагүй бол хүүхдийг гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байр, хүүхдийн хамгаалах байр гэх мэт аюулгүй газарт шууд байрлуулах арга хэмжээ авах.
- Хохирогчийн сэтгэл санааг тайвшруулж, хохирогч хүүхэд туслах зорилгоор түүний итгэлтэй, тусалж чадна гэсэн найз нөхөд, хамаатан садантай нь холбогдох. Гэхдээ хохирогч болсон явдлын тухай нь найз нөхөд, хамаатан садан, таньдаг хэн нэгэнд хэлбэл дараа нь гарч болох үр дагавраас айдгийг, хэдийгээр найз эсвэл хамаатан садан нь тайтгаруулж чаддаг боловч хохирогчдод тухайн асуудлын талаар зөвлөгөө өгөх мэдлэггүй байж болохыг бодолцоорой.



4.3.4 Хүүхдийн бэлгийн хүчирхийллийг цагдаагийн байгууллагад мэдээлэх

Бүх улс орон хүүхдийн бэлгийн хүчирхийллийн талаарх мэдээллийг хэрхэн, хэнд мэдээлэхийг зохицуулдаг хууль тогтоомжтой. Монгол Улс Хүүхэд хамгааллын тухай болон Эрүүгийн хуулиар хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүдийг хүүхдийн бэлгийн хүчирхийллийг мэдээлэх талаар үүрэгжүүлсэн бөгөөд мэдээлэхгүй бол гэмт хэргийг нуун дарагдуулсан гэмт хэрэгт тооцдог. Иймээс Зөвлөгч нь хүүхдийн бэлгийн хүчирхийллийг ямар тохиолдолд хааш нь хэрхэн мэдээлэх талаар мэдэж байх, хэрэгжүүлэх нь тэдний хуулиар хүлээсэн үүрэг юм.

Манай улсын Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасны дагуу 14 насанд хүрээгүй хүүхдийг бага насны хүүхдэд тооцдог бөгөөд хүүхэд бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэгт хохирсон, хохирсон байх магадлалтай бол хүүхдийн эрхийн хуульд заасан үндэслэлээр харьяалагдах нутаг дэвсгэрийн цагдаагийн газарт **ЗААВАЛ ДАРУЙ МЭДЭЭЛЭХ** үүрэгтэй. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар мөн нийгмийн ажилтан хүүхдийн гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийг цагдаагийн байгууллагад, эсвэл Засаг даргад мэдээлэх үүрэгтэй. Хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тухайн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэх үндэслэл байгаа бол энэ хуульд заасан тусгаарлах арга хэмжээг авахдаа тэдний зөвшөөрлийг шаардахгүй. Мөн Хүүхдийн тусламжийн утас 108-д мэдээлж, яаралтай туслалцаа авч болно.

4.3.5 Цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэж шийдвэрлэх

Ямар ч тохиолдолд хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд хангах ёстой. Хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлах гэж яарах хэрэггүй. Хүчирхийлэлд шууд болон шууд бусаар оролцоогүй гэр бүлийн гишүүн эсвэл эцэг эх, асран хамгаалагч насанд хүрсэн хүн хохирогч хүүхэдтэй хамт байх ёстой. Хүүхэд өндөр эрсдэлтэй, хүүхдийг хамгаалах өөр арга байхгүй гэж үзвэл хүүхдийг хамгаалах байранд байрлуулах нь эцсийн арга хэмжээ байх ёстой. Шаардлага үүссэн тохиолдолд Зөвлөгч хүүхдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх хэрэгтэй.

ПРАКТИК ЗӨВЛӨМЖ

Анхаарвал зохих нэг чухал асуудал бол бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх гэмт хэргийн хохирогч хүүхдийн хууль ёсны эрх ашиг бүрэн хамгаалагдаж чадаж байгаа юу гэдэг асуудал юм. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч (эцэг эх хамаатан садан) нь хүүхдийн асуудлыг шийдэхэд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа, хуулийн байгууллагад хандах илт сонирхолгүй байгаа нь тогтоогдвол, эсвэл гэмт хэрэг үйлдсэн хүнийг цагдан хориогүй тохиолдолд Зөвлөгч нь Гэр бүл хүүхэд залуучуудын газарт хандаж хүүхдийн хууль ёсны төлөөлөгч томилуулах ёстой. Ингэснээр хүүхдийн эрх ашиг хамгаалагдах боломж нээгдэнэ.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд олон талт мэргэжлийн тусламж үйлчилгээ, туслалцаа шаардлагатай байдаг. Иймд эдгээр үйлчилгээг харилцан уялдаатайгаар цогцоор нь үзүүлэхийн тулд Зөвлөгч нь хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийнхэнд боломжтой бөгөөд шаардлагатай үйлчилгээний талаар танилцуулан хамтарч ажиллана. Хүүхдэд шаардлагатай бусад үйлчилгээнд хандахад нь хэрхэн туслах, холбон зуучлахад Зөвлөгчийн зүгээс ямар мэдээлэл зөвлөгөө өгөх талаар долоодугаар бүлэгт танилцуулсныг хараарай.

Хэрэв ямар нэг асуудал дээр гэр бүлийн гишүүд хүүхэдтэй эсрэг байр суурьтай байвал Зөвлөгч нь хохирогч хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ажиллах үүрэгтэй.

4.4 ХҮҮХДЭД НИЙГЭМ-СЭТГЭЛ ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ АРГА ЗҮЙН ОНЦЛОГУУД

4.4.1 Хүүхдийн сайн сонсогч байхын тулд юуг анхаарах вэ?

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд Зөвлөгч таны хамгийн түрүүнд хүргэж чадах тус бол түүний үгийг **АНХААРАЛТАЙ СОНСОХ** юм. Хүүхдийн яриаг сонсох үед дараах онцлог зүйлүүдийг анхаараарай. Үүнд:

- Хүүхдүүд аливаа зүйлийн тухай ярихдаа түүнийхээ хэсэг, хэсгээс авч ярих замаар санаагаа илэрхийлэх нь бий. Тэр салангид хэсэг бүлэг тус бүр нь хүүхдийн амьдралд нь тохиолдсон зүйлийн утга санааг илэрхийлсэн байдаг. Гэхдээ хүүхдийн ярьж буй тэр салангид хэсгүүд нь тухайн хүүхдийн илэрхийлж байгаа зүйлийн утга санааг бүхэлд нь гаргадаггүй гэдгийг санаж байх хэрэгтэй.
- Хүүхдийн яриаг сонсож байхдаа гол нь та “түүнд анхаарал хандуулж байна” гэдгээ харуулах хэрэгтэй.
- Хүүхэд өөрийн харилцаа холбоо, зан байдал, хүчирхийлэлд өртсөн тохиолдлуудаа илэрхийлэн ярьж байгаа тохиолдолд хүүхдэд юу дургүйцлийг нь төрүүлж, юу таалагдаж буйг сонирхох хэрэгтэй.
- Хүүхэд өөртөө тохиолдсон зүйлээ ярьж байхад нь түүнийг ойлгож, хүндэтгэх хэрэгтэй. Хүүхдийн өөрийнх нь ертөнцийн жишээлбэл кино, уран зохиол, дуу, дууны видео клип зэрэгт гардаг ижил төрлийн тохиолдолтой эх сурвалжуудыг нь судлан шинжилж үзээрэй. Үүнд шүүмжлэлтэй хандах хэрэггүй.
- Хэрвээ хүүхэд өөрийгөө бүрэн илэрхийлж чадахгүй байвал Зөвлөгч дараах асуултуудыг асууж болно:
 - Энэ явдал хэдийд болсон бэ?
 - Чи хаана байсан бэ?
 - Одоо хаана хэнтэй амьдарч байгаа вэ?
 - Хүчирхийлэгчийг урьд нь таньдаг байсан эсэх?
 - Энэ үйлдэл дахин давтагдаж байгаа юу?
 - Энэ тухай өөр хүнд хэлсэн үү?
 - Ээжтэйгээ энэ тухай ярилцсан уу?
 - Одоо ямар зовиур шаналгаа байгаа вэ?
 - Тэр үед биед чинь ямар зовиур илэрсэн бэ?
 - Одоог хүртэл тэр зовиур шаналгаа үргэлжилж байгаа юу?
 - Хүчирхийлэгч чамайг “Хүнд хэлбэл...” гэж сүрдүүлж занасан уу?
 - Чиний дотны хүн мөн байсан уу?
 - Энэ тухай цагдаагийн байгууллагад хандсан уу?
 - Ямар байдалтай хүлээж авсан бэ?
 - Шүүх эмнэлэгт очсон уу?
 - Чи энэ тухай хуулийн байгууллагад мэдэгдэхийг хүсэж байна уу?
 - Чиний санаа бодол ямар байна?
 - Ээж чинь юу гэж бодож байгаа бол?
 - Чамайг бидэнд хандах тухайд хэн нэгэн зөвлөсөн үү? гэх мэт



4.4.2 Хүүхдийн мэдрэмж, таагүй сэтгэгдлийг нь хуваалцахад юуг анхаарах вэ?

Мэдрэмжийг хуваалцах: Хүүхдүүдийн сэтгэл хөдлөл, мэдрэмж жинхэнэ байдаг тул тэдний ярианаас таагүй мэдрэмжийг нь хуваалцаж байгаагаа дараах байдлаар илэрхийлээрэй.

Мэдрэмжийг хуваалцах жишээ:

“Чи түүнтэй муудалцсан учраас маш их санаа зовж байгаа юмаа даа?”

“Бүгдээрээ чиний эсрэг байгаа учраас чи сургуульдаа явмааргүй байна уу?”

“Найзууддаа уур чинь хүрээд байгаа учраас чи сургуульдаа явах дургүй байна уу?”

Үгэн бус мэдрэмжүүдийг ашиглах: Үүний тулд хүүхдэд халуун дулаан мэдрэмж төрүүлж, түүнийг ойлгож, хүлээн зөвшөөрч байгаагаа харуул. Ингэхийн тулд хүүхдийн үгээр илэрхийлж буй утга санаануудыг нь анхааралтай сонсохын сацуу үгэн бус илэрхийллүүдийг нь тусган хүлээн авч, эдгээрт зохих хариу үйлдлийг үзүүлэх хэрэгтэй.

Санааг нь давтах: Зөвлөгч нь хүүхдийн хэлэх гэсэн чухал санааг алдалгүй сонсоод давтан асууж болно. Ингэж давтах нь хүүхэд гол сэдвээсээ хазайхгүй ярих, хүүхдийн илэрхийлэх гэсэн санааг зөв олж харахад тусалдаг. (Санааг нь давтах, мэдрэмжийг нь хуваалцах хоёр нь ихэнхдээ нэгэн зэрэг хийгддэг)

Санааг нь давтах жишээ:

Зөвлөгч: “Орой унтаж чадахгүй байгаа гэж чи хэллээ, тиймээс чиний анхаарал одоо төвлөрч өгөхгүй байх шиг байна тэ.”

Зөвлөгч: “Чи гэрээсээ зугтмаар байгаа, ингэснээр ямар үр дагаварт хүрч болохыг мэдэхгүй байгаа юм байна гэж би ойлголоо.”

Лавлан асуух: Зөвлөгч нь хүүхдийн хэлсэн үг, өгүүлбэрийг лавлан асууснаар түүнийг үргэлжлүүлэн ярих, тухайн сэдэв дээрээ анхаарал төвлөрөх боломжтой байдаг. Энэ нь мөн өмнө дурдсан мэдрэмжээ хуваалцах аргатай адил нэг дор хэрэглэгддэг.

Лавлан асуух жишээ:

Хүүхэд: Би сүүлийн үед үнэхээр гутарч, амьдралд итгэх итгэлгүй болчихлоо. Надад хэн ч туслахгүй, намайг хэн ч тоохгүй байгаа юм шиг санагдаад байна. Үүнээс болж асуудлаа ярих ч хүнгүй, ганцаардаад байна.

Зөвлөгч: “Чамайг хэн ч тоохгүй байна гэж чамд санагдаад байна уу?”

“Амьдралд итгэх итгэлгүй санагдаж байгаа юм байна тэ?”

“Хэн ч чамд туслахгүй байх шиг байна уу?”

4.4.3 Хүүхдэд ажиглах аргыг хэрэглэх нь

Бэлгийн хүчирхийллээс үүдэн хохирогч хүүхдийн биед болон сэтгэл зүйн байдалд гарсан өөрчлөлтийг зөвхөн ажиглалтаар таньж мэдэх боломжгүй ч хүүхдийг өрөөнд орж ирэх үеэс л түүний гадна байдал, орчны харьцаа, сэтгэл хөдлөл зэргийг анхааралтай ажиглах нь бэлгийн хүчирхийллийн илрэх шинж тэмдгүүдийг тодорхойлоход тусална.

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд илрэх шинж тэмдгүүдийг сайтар ажиглах, асууж тодруулах замаар тодорхойлж чадсанаар бэлгийн хүчирхийллийн улмаас хүүхдэд учирсан сэтгэл зүйн болон болон сэтгэцийн эрүүл мэндийн хор уршгийг эрт илрүүлэх, мэргэжлийн тусламжид цаг алдахгүй холбон зуучлахад тусална.

4.4.4 Асуудлыг олон талаас харах аргыг хэрэглэх нь

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөхөд асуудлын менежментийн аргуудыг, жишээ нь асуудлыг олон талаас нь харах аргыг хэрэглэж болно. Энэ аргыг хүүхдэд зөвлөгөө өгөхөд хэрэглэхдээ:

- Ярилцлагаа маш ойлгомжтой асуултаар эхлээрэй.
- Хүүхдээс тухайн асуудалтай холбоотойгоор толгойд нь орж ирж байгаа бүхнийг чөлөөтэй илэрхийлэхийг хүсээрэй.
- Өөртөө итгэлтэй байж, ярилцлагын эрчийг хадгалсаар байх хэрэгтэй.
- Асуудлыг олон талаас харж ярилцсаны дараа, хүүхдэд өөрийг нь ойлгож байгаагаа нээлттэй илэрхийлээрэй.
- Асуудалд ямар нэг байдлаар өөрийн дүгнэлтийг хийж болохгүй, зарим санаа нь цэгцтэй эсвэл эмх замбараагүй байж болно.
- Хүүхдийг төрөл бүрийн байдлаар өөрийгөө илэрхийлэхийг дэмжээрэй.
- Нэг санааг эхлэл цэг болгон авч цааш нь дэлгэрүүлэн бусад санааг эрэлхийлэхэд туслаарай.
- “Санал болгох ба саналаа татах”: энэ нь таны дэвшүүлсэн санал хүүхдэд тохирохгүй эсвэл тааламжгүй байх тохиолдолд тухайн саналаа дараа дахин ярилцаж үзэхээр тэмдэглэн үлдээгээрэй.
- Асуудлыг олон талаас нь харж ярилцсаны дараагаар үр дүнг тодорхойлоорой.

4.4.5 Оролцооны аргуудыг хэрэглэх нь

Ураг төрлийн бэлгийн хүчирхийлэлд өртсөн болон өртсөн байж болзошгүй хүүхэд, хэл ярианы чадвар сул болон өөрт тулгарсан асуудлаасаа болж шаналж буй хүүхдүүдтэй харьцах, зөвлөгөө өгөхөд *тоглоом тоглох, зураг зурах, өдрийн тэмдэглэл хөтлөх, будах, жүжигчилсэн тоглолт хийх, амарч тайвшрах, дүрийн тоглолт, газрын зураг, захиа бичих* зэрэг оролцооны аргуудыг хэрэглэх нь илүү тохиромжтой байдаг.

Дээрх аргуудын заримыг зөвлөгөө өгөх явцад (тухайн асуудалд анхаарлаа хандуулах зорилгоор) заримыг нь үнэлгээ хийхэд (тухайн хүүхэд болон нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулахад) хэрэглэхэд тохиромжтой. Гэхдээ эдгээр аргуудыг хэрэглэхдээ хүүхдийн нас, онцлог зэрэгт мэдрэмжтэй байх хэрэгтэй.

Тоглоом тоглох арга: Тоглоом тогложноор хүүхэд өөрт тохиолдсон зүйлийг хэлэхээс гадна сэтгэлийн хөдлөлөө ч харуулж болно. Энэ арга нь хүүхдийг хөгжилтэй байлгахын зэрэгцээ далд болон ил буй хүсэл тэмүүллийг нь нээн илрүүлэхэд чиглүүлж өгөхийг хичээх арга юм.

Зураг зурах арга: Хүүхдийг тухайн зөвлөгөө өгч буй үйл явцтай холбоотой зураг зурахыг хүснэ (Боломжтой бол хүүхдээс тухайн уурласан болон гунигтай байх үеийн нөхцөл байдлыг зурахыг хүсээрэй). Зөвлөгөө өгөх явцдаа та түүнтэй тухайн нөхцөл байдлын талаар зургаар нь дамжуулан хамтдаа ярилцаж болно. Хүүхэд өөрийн сэтгэл санааны байдал, дурсан санаж буй зүйл, зөвлөгөө өгч буй үйл явцтай холбоотой хүний



талаар зурж болно. Зөвлөгч нь хүүхэд зургийг хэр гоё зурснаар нь түүнийг үнэлж, дүгнэж болохгүй. Хүүхдийн зурсан зургаар дамжуулан олон зүйлийг тодруулах боломжтой байдгийг дараах жишээнээс харж болно.

ЖИШЭЭ: Хүүхэд өөрийн гэр бүлийн зургийг зурж. Тэгвэл зургандаа өөрийгөө гэр бүлийн гишүүдтэйгээ хэр ойрхон зурж байна, гэр бүлийн гишүүд юу хийж байгаагаар дүрсэлсэн байна, зураг дээрх хүмүүс аз жаргалтай эсвэл гунигтай байна уу? Гэр бүлийн бүх гишүүдийг зурсан байна уу эсвэл хэн нэгнийг орхиж зурсан байна уу? гэх мэтийг анзаарч хараарай. Зураг зурж байхад нь саад бололгүйгээр хүүхдээс зарим зүйлийг асуун тодруулж болно. Тухайлбал, Чи хүүхдээ цохиж буй аавыг зурсан байна. Чи яагаад ингээд зурсан юм бэ? Чи гэр бүлийнхээ зургийг зурахдаа яагаад өөрийгөө оруулж зураагүй юм бэ? Чи яагаад энэ хүнийг зурахдаа зургийг балалсан юм бэ? гэх мэт.

Будгаар зурах арга: Хүүхдэд том цагаан цаас болон будаг өгч өөрийн бодол болон мэдрэмжээ дүрслэх нь (хийсвэр болон бодит зураг байж болно) үнэлгээний бас нэгэн сонирхолтой арга юм. Хүүхдүүд юу хүссэнээ зурж болохоос гадна бусад материалуудыг ч нэмэлтээр ашиглаж болно. Бүтээл туурвих болон үнэлгээ хийх аргыг хослуулснаараа энэ арга нь үр дүнтэй юм.

Амарч тайвшрах арга: Хүүхдийн сэтгэл санаа бухимдах эсвэл ямар нэгэн зүйлд түгших нь нэмэгдэх үед Зөвлөгч анхаарлаа тухайн сэтгэл зүйн агшинд хандуулах хэрэгтэй. Энэ тохиолдолд тайвширч амрах боломжтой йог хийх зэрэг амьсгалын бусад дасгалуудыг ашиглаж болно. Эдгээр нь стресс болон уур хилэнг зохицуулах арга юм.

Жүжигчилсэн тоглолт хийх арга: Энэ аргыг ихэвчлэн бүлгээр ажиллахад хэрэглэж болно. Жүжгээр дамжуулан хүүхдүүд өөрт тохиолдсон түүх, харилцаа, илэрхийлэл зэргийг дүрслэн үзүүлж болно. Зөвлөгөө өгөх үйл явцтай холбоотой сэдвийн хүрээнд тоглолтыг хийж болно.

Дүрийн тоглолт: Энэ нь дүрийн тоглолтыг ашиглан хүүхэд шинээр сурсан арга, ур чадвар, санал бодлоо бусадтай хуваалцах арга юм. Дүрийн тоглолтоор хүүхэд тодорхой үүрэг даалгаврыг биелүүлнэ. Тухайлбал хүүхэд хэн нэгэнтэй ярилцах үүргийг хүлээж болно. Энэ нь хүүхэд өөрийн бодол санаа, сэтгэл санааны байдлаа бусадтай хуваалцахыг дэмжих арга юм. Бусадтай харилцааны ямар нэгэн асуудал учирсан үед энэ аргыг ашиглах нь үр дүнтэй байна.

Захиа бичих арга: Хүүхэд зөвлөгөө авч байх явцад болон дараа нь өдрийн тэмдэглэл хөтөлж болно. Өдрийн тэмдэглэлдээ өөрийн зорилго эсвэл тухайн нөхцөлд мэдэрсэн өөрийн сэтгэл зүйн байдлын талаар бичиж болно. Хэрэв хүүхдийн нөхцөл байдалд бусад хүн оролцсон бол хүүхэд түүнд зөрчилдөөнийг шийдвэрлэх үүднээс захиа бичиж болно (тухайн хүүхдийн хүслээс шалтгаалан бичсэн захиаг нь эзэнд хүргэж өгөх эсэхийг сайтар ярилцаарай).

Газрын зураг: Энэхүү арга нь тухайн хүүхдийн талаар мэдээлэл олохоос гадна хүүхэд зөвлөгчтэй хамтран өөрийн амьдралд чухал зүйлс болон бусдын/нийгмийн дэмжлэгийг хэнээс авах талаар дүрслэн үзүүлэх арга юм.

4.4.6 Тайвшруулах, сэтгэл зовнилоо гадагшлуулах дасгалуудыг хэрэглэх нь

Тайвшруулах дасгалууд: Энэ дасгалуудыг хүүхдэд зөвлөгөө өгөхийн өмнө, зөвлөгөө өгөх явцад хийж болно.

Гүнзгий амьсгалах: Хүүхдүүдэд нүдээ анин, удаанаар гүнзгий амьсгаа авч, дуртай зүйлсээ солонгын 7 өнгө тус бүрд тааруулж бодох замаар "солонгон амьсгал"-ыг заах нь зүрхний цохилтыг удаашруулж, булчингаа суллахад тусалдаг. Та 30-60 секундийн зайтайгаар солонгын 7 өнгийг дараалуулан хэлж өгнө.

Булчин суллах: Ихэнх хүүхдүүд түгшсэн үедээ булчингаа чангалж, олонхи нь амьсгаагаа түгждэг. Хоёр үе шаттай энэ хийх дасгал нь сэтгэлийн түгшүүр, зовиуртай хүүхдүүдэд булчингаа удирдаж, тайвшруулж сурахад тусалдаг.

- Тодорхой булчингийн хэсгийг (жишээ нь гарын сарвуу, булчин, хүзүү, мөр, цээж, гуя, хөлийн булчин гм) нэрлэж чангалаад тус бүрд нь таван секунд барина.
- Булчинг суллаж, ямар мэдрэмж төрж байгаа талаар ярилцаарай. Ямар булчин илүү их ачаалалтай, өвдөж байгааг сайн мэдрэхийн тулд маш сайн ажиглаарай. Зовиуртай газрууддаа дахин энэ дасгалаа хийж, гарч буй өөрчлөлтийн талаар ярилцаарай.

Сэтгэл зовнилоо гадагшлуулах дасгал: Энэ дасгалыг удаан хугацааны зөвлөгөөний явцад болон хамгаалах байранд, гэрт нь эргэн нэгтгэсний дараа ашиглахад илүү тохиромжтой.

Санаа зовоож буй асуудлаа бичих нь хүүхдүүдэд сэтгэлийн түгшүүртэй мэдрэмжээ гаргаж сурахад тусалдаг. Хүүхдүүд таагүй, сэтгэлийн түгшүүртэй бодлуудаа удаан хугацаанд дотроо хадгалснаар өөртөө шингээж, сэтгэл санааны дарамтад орох хандлагатай байдаг. Өдөр бүр арван таван минутын турш эдгээр мэдрэмжийг гадагшлуулах цаг гаргах нь хүүхдүүдэд санаа зовнилоо даван туулж сурахад тусалдаг. Эдгээр дасгалын аль нэгийг өдөр бүр хийж үзээрэй.

Бичих, урах дасгал: Хүүхдээ цаасан дээр санаа зовоосон зүйлээ бичиж, зурж, танд уншиж өгөөд, дараа нь урж хаяад хонуул. Энэ нь хүүхдүүдэд санаа зовоож буй асуудал, сэтгэл зовнилоо чангаар хэлж, тэрнээсээ салахад тусалдаг.

Өдрийн тэмдэглэл: Хүүхэд өдрийн тэмдэглэл бичсэнээрээ санаа зовоож буй асуудал, сэтгэлийн түгшүүртэй бодлууд нь цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөж, сайжирч байгаагаа олж харахад тусалдаг. Тухайн өдрийн санаа зовоосон асуудлаа бичээд, маргааш нь түүнийг хэрхэн даван туулсан, сэтгэл зовнилоо ямар байдлаар даван туулсан, эсвэл юу мэдэрснээ тогтмол бичих нь сэтгэлийн түгшүүрийг даван туулахад тусалдаг.

Шидэт хайрцаг: Энэ бол унтахын өмнө хэрэглэхэд тохиромжтой бөгөөд хүүхдийг хуучин салфетканы юм уу жижгэвтэр хайрцгийг өөрөөр нь чимэглүүлээрэй. Хайрцагт тэр өдрийн санаа зовоосон зүйлээ бичиж, тантай хуваалцсаны дараа тэдгээрийг нэг нэгээр нь хайрцагт хийхэд нь тусал. Хайрцгийг өрөөндөө байршуулж, хадгалахыг санал болгоорой. Хагас жилд нэг удаа хайрцагтай "сэтгэл зовоосон асуудал"-аа задалж уншаад, хаях эсэхээ өөрсдөө шийдээрэй.

Амрах орчин бий болгох: Хүүхдийн сонгосон алжаал тайлахад хэрэглэгдэх зүйлүүдээр хайрцгийг дүүргэж, зөвлөгөө өгөх өрөөнийхөө хаа нэгтээ "Амрах орчин" байгуулаарай. Хөгжим, буддаг ном, эвлүүлдэг тоглоом, шүрэн урлал, дууны үг, баримлын шавар, ном, зөөлөн тоглоом гм. Энэ орчиндоо 5-15 минутад хүүхдийн өөрсдийнх нь хүссэн зүйлийг сонгуулан хийлгээрэй.



Хэрэв хүүхдийн санаа зовох, сэтгэлийн түгшүүр буурахгүй нэмэгдэж, унтах амрах, сургуульд сурах болон хэвийн амьдралд нь сөргөөр нөлөөлж байвал сэтгэцийн эмчээс зөвлөгөө авах хэрэгтэй.

4.5 БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН ГЭР БҮЛД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ НЬ

4.5.1 Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн гэр бүлийнхний онцлог

Бэлгийн хүчирхийллийг илчилсний дараа хүүхэдтэй харилцах, хүүхдээ халамжлахад гэр бүлийн гишүүдэд багагүй бэрхшээл учирч эхэлдэг. Өмнө нь нууц, далд байсан бэлгийн хүчирхийллийг ил болгосон нь олон гэр бүлд хямрал үүсгэдэг. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн эцэг эх, өвөө эмээ болон хамгийн ойр дотно байсан хүн нь хүүхдээ хамгаалж чадаагүйдээ өөрийгөө буруутган, хүүхдээ харахаар өрөвдөж, ичгүүртэй мэдрэмж төрдөг тухай байнга илэрхийлдэг. Ингэж хохирогч хүүхдийн гэр бүлийн гишүүд **“дам хохирогч”** болдгоос айдастай, хүнд итгэх итгэлээ алдсан байдгаас бага насны болон сургуулийн хүүхдээ хэнд итгэж үлдээх вэ? ажилдаа явахгүй байх уу? дахиад асуудал гарахгүй баталгаа байгаа юу? гэх мэт өмнө нь тооцоолоогүй бэрхшээлүүд гарч ирдэг. Хүүхдүүд маш их тэсвэр гаргадаг ч хэвийн байдалд эргэж ороход цаг хугацаа, тэвчээр их шаардагддаг. Иймээс гэр бүлийн гишүүд хохирогч хүүхэдтэй хэрхэн харилцахаа мэдэхгүй байх тохиолдлууд их гардаг.

“Дам хохирогч” гэдэг нь бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийн хамгийн ойр дотны хүмүүс буюу гэр бүлийн гишүүд (эцэг эх, эгч, ах дүүс, өвөө, эмээ гэх мэт), дотны найз, багш нь байж болох бөгөөд хайртай хүнд нь тохиолдсон зүйлд цочирдсоноос бий болж буй хор хохирол юм.

4.5.2 Гэр бүлд дүн шинжилгээ хийх

Зөвлөгч нь юуны өмнө бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн гэр бүлд маш сайн дүн шинжилгээ хийх нь хүүхэд дахин хохирогч болохоос хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Иймд гэр бүлд дүн шинжилгээ хийхийн тул дараах мэдээллийг цуглуулах хэрэгтэй. Үүнд:

- Гэр бүлийнх нь ерөнхий нөхцөл байдал: хохирогч хэн, хэнтэйгээ амьдардаг, ажил эрхлэлт, амьжиргааны түвшин, орлогын эх үүсвэр, цалин хөлс, хаана, ямар орон гэрт амьдардаг, хэний эзэмшил, хэр удаан амьдарч байгаа гэх мэт
- Гэр бүлийнх нь уур амьсгал, гэр бүлийн хүчирхийлэлтэй эсэх, гэр бүлийн гишүүдийн байр суурь, хэн ямар үүрэг гүйцэтгэдэг, ямар оролцоотой гэх мэт
- Гэр бүлийн гишүүдийн хоорондын харилцаа, дагавар болон өргөмөл, төрсөн хүүхдүүдийн хооронд харилцааны ялгаатай байдал бий эсэх гэх мэтээр аль болох тодорхой, бодитой мэдээлэл авахыг хичээх хэрэгтэй.
- Мөн гэрт нь байгаа бусад хүүхдүүдэд эрсдэл байгаа эсэхийг нэг бүрчлэн заавал шалгаарай.

4.5.3 Гэр бүлийн гишүүдэд өгөх зөвлөгөөний арга зүй

Зөвлөгч нь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн гэр бүлийн гишүүдэд зөвлөгөө өгөхдөө юуны өмнө **“дам хохирогч”** болж буйг тайлбарлаж, **“Та хүүхдийг ийм байдалд оруулаагүй, гэмт хэрэгтэн үүнийг үйлдсэн, тэр хүүхдийг гэмтээсэн”** гэдгийг ойлгуулан,

хохирогчийг нөхөн сэргээхийн тулд хүчтэй байж, сэтгэл зүйгээ тогтворжуулахад нь туслалцаа үзүүлэх хэрэгтэй. Хүүхдээ хамгаалахад Таны дэмжлэг яг одоо байгаа бүх зүйлээс хамгийн чухал нь гэдгийг онцолж, хүүхдэдээ хэрхэн туслах арга барилын талаар тэдэнд дараах зүйлүүдийг зөвлөөрэй.

- Хүүхдэд айдас төрүүлэхгүйгээр аюулгүй байдлыг нь хангах, түүнийгээ хэрхэн байнга баталгаажуулж хянаж байх;
- Хүүхэд өөрт төрж буй эерэг, сөрөг мэдрэмжээ аюулгүй байдлаар илэрхийлэхийг нь зөвшөөрөх;
- Хүүхдийнхээ давуу талыг дэмжих замаар өөрсдөө уян хатан байдлаар асуудлыг шийдвэрлэх чадварт суралцахад нь туслах;
- Хүүхдээ байнга сонсож, итгэж, тэднийг дэмжиж байх.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийнхээ сэтгэл зүйн байдлыг ойлгох нь гэр бүлийн гишүүдийн зүгээс хүүхдийг буруутгах, шийтгэх, үл итгэх, тусгаарлах, тусламж хайхаас зайлсхийх гэх мэт олон сөрөг хандлагаас сэргийлэхэд тус болдог. Иймээс дараах зүйлүүдийг гэр бүлийн гишүүдэд тайлбарлаж ойлгуулах хэрэгтэй.

Хүүхдүүд яагаад нуудаг вэ?

Бэлгийн хүчирхийллийн талаар хүүхэд хэлэхгүй байх олон шалтгаан байдаг. Тэдгээрийн хамгийн том шалтгаан бол айдас. Тэдэнд хэн ч итгэхгүй гэж хүүхдүүд айдаг. Яагаад гэвэл ихэнх гэмт этгээдүүд “*чи энэ тухай хүнд хэлбэл хэн ч чамд итгэхгүй*” гэж хэлдэг. Хүүхэд хүчирхийлэгчийн үгэнд шууд итгэдэг. Хүүхэд болсон явдлын талаар хүнд хэлбэл хүчирхийлэгч хүүхдэд өөрт нь, гэр бүлд нь муу юм хийнэ гэж айдаг.

Мөн нөгөө талаас хүүхдүүд болсон явдалд өөрсдийгөө буруутгадаг болохоор энэ талаар хэнд ч хэлдэггүй. Хүүхдүүд хүчирхийлэлд өртсөн нь өөрсдөөсөө боллоо гэж үздэг. Хүн болгон мэдэхгүй танихгүй зүйлээсээ айдаг тэр тусмаа хүүхэд бүр ч илүү айдаг. Тийм учраас хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртвөл ээж аав нь хүүхдээ зэмлэх буруутгах биш харин **ОЙЛГОЖ ИТГЭЖ ХАМГААЛАХ** ёстой гэдэг талаар тэдэнд зөвлөх хэрэгтэй.

Хүүхэд тань бэлгийн хүчирхийлэлд өртсөн тухайгаа хэлбэл яах вэ?

Хүүхэд өөрт тохиолдсон бэлгийн хүчирхийллийн талаар нээн ярьсны дараах үе хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндэд ноцтой нөлөө үзүүлэхүйц үйл явдал байдаг. Тиймээс хүүхэд танд өөрт тохиолдсон бэлгийн хүчирхийллийн талаар нээн ярьсны дараа яах хэрэгтэй талаар доорх зүйлүүдийг тэдэнд зөвлөөрэй.

- Тайван байж, сөрөг реакц гаргахгүй байх хэрэгтэй. Таны гаргасан уур хилэн, бухимдлыг хүүхэд өөртөө хамаатуулж ойлгодог гэдгийг байнга санаарай;
- Ямар ч тохиолдолд **ХҮҮХДЭД ИТГЭХ** хэрэгтэй! Ихэнх тохиолдолд хүүхэд бэлгийн хүчирхийллийн талаар худлаа ярьдаггүй. Учир нь уг сэдэв нь хүүхдийн хувьд бусадтай хуваалцахад эвгүй, аймаар зүйл байдаг.
- Хүүхдээ анхааралтай сонсоод асуултад нь эелдгээр хариулах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хүмүүсийн туслалцааг авах шаардлагатай.
- Хэрвээ хүүхэд тань анх удаа энэ тухай танд хэлэхэд та түүнд итгээгүй эсвэл буруутгасан бол дахин тэр юу ч болж байсан танд итгэж хэлэхгүй. “*Нэгэн охин хойд эцгийнхээ хүчирхийлэлд олон жил болсны дараа удаан бодсоны эцэст ээждээ энэ тухай хэлэхэд ээж нь хойд аавыгаа үзэн яддаг болохоор ийм зүйл ярьж байна уу гэж асуусан. Түүнээс хойш тэр хэнд ч энэ тухайгаа ярьж зүрхлээгүй байна*”.



Хүүхдийн “даван туулах” чадварыг яаж дэмжих вэ?

Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг насан туршийн **ДАВАН ТУУЛАГЧ** гэж үздэг. Гэхдээ хүн бүрийн асуудлыг даван туулах чадвар нь харилцан адилгүй байдаг. Хохирогч хүүхдэд зөвлөгөө, туслалцааг цаг алдалгүй үр дүнтэй үзүүлж чадсанаар хүүхэд бэлгийн хүчирхийллийн олон хор уршиг эрсдэлийг даван туулж, хэвийн амьдралдаа ороход нь чухал үр нөлөөтэй байдаг тул гэр бүлийн гишүүдээс байнгын, тасралтгүй, үр дүнтэй хамтын ажиллагааг шаарддаг.

Иймээс Зөвлөгч нь гэр бүлийн гишүүдэд зөвлөгөө өгөхдөө хүүхдийн давуу талыг дэмжсэн, даван туулах чадварыг хөгжүүлэх, бэхжүүлэхэд чиглэсэн арга барилыг хэрхэн хэрэглэх талаар тэдэнд туслах хэрэгтэй. Ингэхдээ даван туулагчийн тохиолдлын жишээг гэр бүлийн гишүүнд уншуулаад ярилцаж болно.

Бэлгийн хүчирхийллийн хүүхдийн бие махбод, сэтгэл зүйд үзүүлэх хор уршиг, эрсдэлийн талаар сайн ойлгуулж, эдгээрээс сэргийлэх, эрт илрүүлж мэргэжлийн тусламжийг тууштай авахад гэр бүлийн гишүүд онцгой үүрэгтэй гэдгийг тэдэнд сайтар ухамсарлуулах хэрэгтэй.

ПРАКТИК ЗӨВЛӨМЖ

- Үйлчлүүлэгчид үргэлж “элэгсэг” байдаггүй. Ийм болохоор бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн гэр бүлийн гишүүд асар их бухимдалтай байдгаас бухимдлаа Зөвлөгчид гаргах, дайрч давшлах, харилцааны зохисгүй үйлдлүүд гаргаж магадгүй. Ийм нөхцөлд Зөвлөгч та тэднийг өөрөөсөө түлхэж, холдуулах бус өөрийн ажил үүргээ биелүүлэх ёстой.
- Зөвлөгчийн үзүүлэх үйлчилгээ нь үйлчлүүлэгч тантай нөхөрсгөөр хандаж, зохих ёсоор биеэ авч явж байгаа эсэхээс хамаарах ёсгүй.

4.5.4 Хүүхдийг гэр бүлд нь эргэж нэгтгэхийн тулд гэр бүлтэй ажиллах, бэлтгэх

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд эргэж хэвийн амьдралдаа орох нь асран халамжлагчдаас нь ихээхэн хамаардаг учраас тэдний хүүхдүүдэд хандах хандлага, харьцаа нь онцгой чухал гэдгийг гэр бүлийн гишүүдэд зөвлөгөө өгөхдөө онцлох хэрэгтэй. Гэхдээ хэт онцгойлсон харьцаа сөрөг үр дагавар учруулах магадлалтайг анхааруулаарай.

Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг болсны дараа хүүхэд, гэр бүлийн гишүүдтэйгээ нэгдэж, эргэн хэвийн амьдралдаа орохдоо хэд хэдэн үе шатыг туулдаг гэж үздэг. Хүүхдүүд хямралын дараах сэтгэл гутралд өртөж ойлгомжгүй зан авир гаргах, гомдоллох, бусдыг буруутгах, тэнэх, мансууруулах бодис хэрэглэх, амиа хорлохыг оролдох зэрэг зан авируудыг гаргаж магадгүй. Зөвлөгч нь дараах үе шатуудын талаар гэр бүлийн гишүүдэд ойлгомжтой тайлбарлаж өгвөл хүүхэдтэйгээ харьцах харьцаанд учрах бэрхшээл багасна.

Эхний үе шат буюу “Ойлголцлын үе”

(24 цагаас 2-3 долоо хоног үргэлжилж болно)

Хүүхэд маш дуулгавартай, хүн бүхэнд талархсан байдлаар ханддаг. Өөрийгөө аюулгүйг бүрэн мэдэрч, муу зүйл дууссан гэдэгт итгэдэг. Дийлэнх тохиолдолд хүүхдүүд биеэ авч явахдаа элдэв асуудал гаргадаггүй.

**Хоёр дахь үе шат буюу
"Зохицлын үе"**

(Ойлголцлын үеийн дараах 3-9 долоо хоног)

Хүүхэд өмнө нь амьдарч ирсэн амьдралын дадал зуршлаараа биш бусдын заавраар "аюулгүй амьдрах" шинэ нөхцөл байдалд дасан зохицох хэрэгтэй болдог. Дасан зохицох энэ явц хүүхдэд заримдаа дарамт шиг санагдаж, тэр бүр таалагдахгүйгээс сэтгэл хөдлөл, мэдрэмжээ эерэг, сөргөөр илэрхийлж болзошгүй.

Хүүхдэд илрэх сөрөг зан үйл: Насанд хүрэгчдийн захиргаадалд дүргүйцэж сахилга батыг зөрчих, уур хилэнгээ шууд илэрхийлэх, сэтгэл санаагаар унах, бүх зүйлийг эсэргүүцэх, ердийн амьдрал болон өөрийн байгаа байдалдаа сэтгэл хангалуун бус хандаж эд зүйлсээ нуух, өрөө, хаалгаа түгжих, гэрэлтэй унтах, юмаа цүнхлэн гэрээсээ явахаар айлгах гэх мэт этгээд зан авир гаргаж, сөрөг үзэл бодол илэрхийлж болох юм. Энэ үед асран халамжлагчийн хандлага, харьцаа онц чухал ач холбогдолтой.

**Гурав дахь үе шат буюу
Тайвшралын үе**

(Зохицлын үеийн дараах 10-40 долоо хоног)

Хүүхэд өөртөө илүү итгэлтэй болж, биеэ авч явах зохисгүй байдал аажмаар арилах ёстой. Гэхдээ эдгэрэлтийн үе нь хэдэн сар жилээр ч үргэлжилж болзошгүй. Хүүхэд шинэ хандлагад дасан зохицох явцад биеэ авч явах зохисгүй байдал эргэж буцах үед гарч болзошгүйг анхаарах хэрэгтэй.

**Сүүлчийн үе шат буюу
"Суурьших" үе**

Бүрэн "эдгэрсний" дараа хүүхэд энэ амьдралдаа дасан зохицож, сэтгэл хөдлөлийн мэдрэмжээ удирдаж сурсан байдаг. Энэ үед боломжтой бол дасан зохицож байгаа газраас нь нүүх, шинэ орчинд оруулахаа түр хүлээх шаардлагатай байдаг. Суурьших үе шатанд дассан газраасаа нүүх нь ямар нэгэн зүйлээ алдсан мэт мэдрэмж хүүхдэд төрүүлж, өөрөөс нь болж энэ бүхэн боллоо хэмээн сэтгэлээ зовоон биеэ авч явах зохисгүй байдалд эргэн орж болох юм. Тиймээс гэр бүлийн гишүүдэд энэ үед хүүхдэд анхаарал хандуулахаас гадна гэр бүлийн дотоод асуудал, уур амьсгалыг хэвийн авч явах талаар сануулаарай.

БҮЛЭГ 5. ХҮҮХДИЙН НАСНЫ ОНЦЛОГТОЙ НИЙГЭМ-СЭТГЭЛ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ

Өмнөх бүлэгт бид бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөхдөө баримтлах нийтлэг зарчмууд, хэрэглэх ерөнхий арга зүйг танилцуулсан. Эдгээр арга барилуудыг хүүхдийн насны онцлогоос хамаарч хэрхэн хэрэглэх талаар энэ бүлэгт авч үзэх болно.

5.1 БАГА НАСНЫ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ НЬ

5.1.1 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн бага насны хүүхдийн онцлог

Бага насны (0-3) хүүхэд нь өөрийгөө илэрхийлэх чадваргүй. Гэхдээ 2-3 насанд хүүхдүүдийн танин мэдэх, төсөөлөн бодох чадвар хөгжиж, тоглоом наадамд дуртай, энд тэнд үсэрч цовхчсон хөдөлгөөнтэй, багахан юмнаас айдаг бөгөөд сэтгэл зүйн хувьд хүрээлэн буй орчиндоо итгэх суурь тогтдог гэж үздэг.

Энэ насны хүүхдийн эсрэг үйлдэгдсэн бэлгийн хүчирхийллээс үүдэлтэй бие махбод, сэтгэцийн гэмтэл нь хүнд тусдаг, цаашид амь насанд нь аюул учруулахуйц хэмжээнд ч хүрэх магадлалтай байдаг. Бэлгийн хүчирхийлэлд өртсөнөөр хүүхдийн сэтгэл зүй, зан төлөвт ноцтой өөрчлөлт гарна гэж үздэг бөгөөд цаашид ч үзэж өнгөрүүлсэн аймшигт тохиолдлыг хэзээ ч мартаггүй, насан туршид нь дагадаг. Хүүхдийн хэл ярианы хөгжилд хоцрогдол гарч эхэлдэг.

Харамсалтай нь манай улсад бага насны, түүний дотор бүр нялх балчир хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг тасрахгүй гарсаар байгаа нь гашуун үнэн билээ. Үүний жишээг дараах тохиолдлоос харж болно.

Тохиолдол ... Замын-Үүд сумд Ч нь өөрийн найз Ц-тэй архи ууж, хүүгийн аав согтуу түр гарсан хойгуур Ц нь найзынхаа ой 8 сартай бяцхан хүүг хүчирхийлсэн аймшигт хэрэг гарсан. Хүүгийн эцэг эх тусдаа амьдардаг хүү аав дээрээ хэд хоног очих үед ийм хэрэг болсон байна. Хүүг найзтайгаа үлдээгээд гараад ирэхэд нь хүү чинь уйлаад байна гээд хүүгээ 30 минут хэртэй тэвэрч тайвшруулж унтуулахад бөгс нь нойтон байсан. Шээчихэж гэж бодоод тоогоогүй, удаагүй хүүхэд чангаар унгаж, бааж байгаа чимээ гарахаар нь үзэхэд битүү цус гарсан байсан. Найз нь мэдэхгүй гээд байхаар нь хутга тулгаж байгаад асуухад хүчиндсэнээ хүлэсэн учраас цагдаагийн байгууллагад мэдэгдсэн (www.shuukh.mn).

Илрэх шинжүүд: Бэлгийн хүчирхийлэлд өртсөн бага насны хүүхдэд тэдний гадна байдал, бие махбод, сэтгэхүйн талаас дараах шинжүүд ажиглагдаж болно.

ГАДНАХ БАЙДЛЫН ИЛРЭЛ	БИЕ МАХБОД СЭТГЭЛ ЗҮЙН ШИНЖҮҮД
Орчиндоо идэвх муутай, дуу сул, цоглог биш, байнгын ямар нэг юмнаас айсан	Биеийн далд хэсгүүдэд санамсаргүй байдлаар үүсэхээргүй хөхрөлт, бэлэг эрхтэн орчмоор зулгаралт, няцралт, тууралт, бэлэг эрхтнээс үнэр, өнгөтэй хэвийн биш зүйл гарах
Инээд баяр хөөр багатай, хүүхдэд байхааргүй уйгартай дүнсгэр царай гаргах	Оюун ухааны хөгжлийн хувьд үе тэнгийнхнээсээ хоцорсон байдал илэрнэ

Томчуудтай харьцахдаа айж царайчилсан байдлаар хандах, тэднээс шалтгаангүйгээр эмээх, бишүүрхэх	Байнга уйлах, уйлагнах, хоол нойрны хэм алдагдах, унтаж байхдаа олон удаа цочих, орондоо бие засах, хар дарах
Үе тэнгийнхээсээ болон томчуудаас дөлөх, ээжээсээ салахгүй дагах	Жингээ алдах, хоол тэжээлийн дутагдал, тураалд орох
Нүдний харц галгүй ноомой, нүүрний баясгалангүй, эсвэл хэт ууртай, зөрүүд зан гаргах гэх мэт	Бэлэг эрхтэн, хонго, бөгс орчмын газруудад хүрэхэд эмзэглэх, зовиур шаналгаатай байгаа нь илт мэдрэгдэх, цус гарсан байх гэх мэт

5.1.2 Хүүхдэд үзүүлэх туслалцаа

Бага насны хохирогч хүүхдийн гэр бүлийн гишүүд бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой зөвлөгөө авахаар хандсан тохиолдолд зөвлөгч юуны өмнө хүүхдэд **ЭМНЭЛГИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ** авах бүх арга хэмжээг нэн даруй авах хэрэгтэй.

Хохирогч хүүхэд дийлэнхдээ эмэгтэй байдаг ч эрэгтэй хүүхэд хохирогч болдог гэдгийг мартаж болохгүй. Тиймээс хохирогчийг хүйсээр үл ялгаварлан үйлчилгээ, зөвлөгөө, тусламжийг нэг адил хэмжээнд үзүүлнэ.

Хэрэв хүүхэд эмнэлгийн яаралтай тусламж авсан байвал дараачийн алхам нь цагдаад даруй мэдэгдэх шаардлагатай. Мөн хүүхдийн тусламжийн утас 108-д хандаж зохих тусламж, үйлчилгээг нэн даруй авах боломжтой.

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу, бага насны буюу 0-14 насны хүүхдийг хүчиндсэн, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн бол хүнд төрлийн гэмт хэрэг учраас Зөвлөгч нь хохирогч болон гэр бүлийн гишүүд зөвшөөрсөн эсэхээс үл хамааран заавал цагдаагийн байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

5.1.3 Гэр бүлийн гишүүдэд нь өгөх зөвлөгөө

Хүчирхийллийн дам хохирогч болсон гэр бүлийн гишүүдийг тайвшруулах; хуулийн байгууллагаар асуудлаа шийдүүлэхэд хэрэгтэй мэдээлэл өгөх; хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл зүйд гарсан эмгэг, хор уршгийг арилгахын тулд хүүхдийн эмч, хүүхдийн сэтгэцийн эмчийн тусламжийг бусад нөхөн сэргээх эмчилгээтэй хамт заавал авах шаардлагатайг ойлгуулах хэрэгтэй.

Зөвлөгч нь хүүхдийн бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг мэдсэн бол цагдаад заавал мэдэгдэх үүргийг хуулиар хүлээдэг гэдгээ гэр бүлийнхэнд тайлбарлаж хэлэх хэрэгтэй (Бусад үйлчилгээнд холбон зуучлахад өгөх мэдээлэл зөвлөгөөг сүүлийн бүлгээс харна уу).

5.2 СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ НЬ

5.2.1 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн сургуулийн өмнөх насны хүүхдийн онцлог

Сургуулийн өмнөх насны (4-5 нас) хүүхдүүдийн хэл яриа хөгжиж, өөрийгөө илэрхийлэх, хамгаалах оролдлогууд явагдаж эхэлдэг. Энэ насны хүүхдүүдийн онцлог нь ой тогтоолт нь санамсаргүй өнгөц шинжтэй, юмыг байгаа чигээр нь тогтоож сэргээн санадаг, хараа, сонсголын ой түлхүү хөгжинө. Өдөр тутмын амьдрал дахь хэрэглэдэг зүйлс, сонирхолтой сэтгэл татсан зүйлээ амархан тогтооно, сэргээн санах нь сул, бусдын яриаг анхааралтай сонсож, бүрэн ойлгодог. Өөрийгөө илэрхийлэх чадвар бага багаар бүрдэж, таатай, таагүй зүйлийг шууд илэрхийлэх, асуултад хариулах, айдсаа шууд илэрхийлж харуулах



зэрэг чадварууд бий болсон байна. Зөвлөгч нь эдгээр онцлогуудыг зөвлөгөө өгөхдөө тооцож үзэх хэрэгтэй.

Сургуулийн өмнөх насандаа бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдүүд цаашдаа өөрийгөө буруутгах, өөрийн үнэлэмж доогуур, бусдаас хараат, өөрийгөө илэрхийлэх чадваргүй хүн болох өндөр эрсдэлтэй байдаг. Зарим хүүхдэд насан туршийн сэтгэцийн эмгэг ч үүсдэг.

Энэ насны хүүхдүүд болж буй явдлын талаар таагүй байдлыг мэдэрч, хэн нэгэнд хэлэхийг оролддог. Хүүхэд ямар нэгэн болохгүй, муу зүйл болсныг мэддэг тул өөрийн итгэж байгаа хүндээ энэ тухай хэлдэг гэдгийг дараах тохиолдлоос харж болно.

ТохиолдолЭэж нь самарт яваад сар гаруй сураггүй болсон хойгуур 5 настай бяцхан охиныг явж чадахгүй догонцоод байгааг харсан хүргэн ах нь юу болсныг асууснаар хойд эцэг нь болох 28 настай В гэгч хүчиндсэн байж болзошгүйг олж мэдээд цагдаад хандсан байна. Охиноос юу болсон тухай асуухад “Аав согтуу орж ирээд намайг хувцсаа тайл гээд тайлуулсан. Тэгээд б***жгойгоо хийсэн цус гарч өвдөөд, би их уйлсан, одоо босоод явж чадахгүй байна” гэхэд нь мэдэж тэр даруй цагдаагийн байгууллагад хандаж, хүчирхийлэгч этгээдийг баривчилжээ. (www.shuukh.mn)

Илрэх шинжүүд: Бэлгийн хүчирхийлэлд өртсөн сургуулийн өмнөх насны хүүхдэд тэдний бие махбод, сэтгэл зүй, бэлгийн эрүүл мэндийн талаас дараах шинжүүд ажиглагдаж болно.

ГАДНА БАЙДАЛ, ЗАН ТӨРХИЙН ШИНЖ	БИЕ МАХБОД СЭТГЭЛ ЗҮЙН ШИНЖҮҮД
Тоглоомын явцад дүрслэн харуулж байгаа үйл явдал нь аюултай, түрэмгийлэл ихтэй, эсвэл ямар ч идэвхгүй	Биеийн далд хэсгүүдэд санамсаргүй байдлаар үүсэхээргүй хөхрөлт, бэлэг эрхтэн орчмоор зулгаралт, няцралт, тууралт, бэлэг эрхтнээс үнэр, өнгөтэй хэвийн биш зүйл гарах
Өөрийн бодлоор биш хэн нэгэн хүний үг хэллэг, үйлдлийг давтан хэлэх	Хэл ярианы хоцрогдолтой, ээрүү, гацаа болох
Томчуудаас айж, дөлөх, эмээх байдал ажиглагдах	Нойр хоолны хэм алдагдах, хар дарах, зүүдлэх, шалтгаангүй айх
Хүүхдийн ерөнхий идэвх буурах, ганцаардмал зожиг байдал илрэх эсвэл хэт тогтворгүй түрэмгий зан илрэх	Хүүхэд худлаа өвдөх, уйлах зэргээр томчуудын анхаарлыг өөртөө татах гэж оролдох
Заримдаа хүүхэд өөрт тохиолдсон явдлыг түүх, үлгэр мэтээр хийсвэрлэн ярих	Байнга уйлах, уйлагнах, унтаж байхдаа олон удаа цочих, орондоо бие засах, хар дарах
Тухайн хүчирхийлэгчээс, эсвэл түүнтэй төсөөтэй хүнээс зайгаа барих, нуугдах, айх гэх мэт	Бэлэг эрхтэн, хонго, бөгс орчмын зовиуртаа байгаа газраа үзүүлэх, өвдөж, эвгүй байгаа тухайгаа хэлэх гэх мэт

5.2.2 Хүүхдэд өгөх зөвлөгөө

Энэ насны хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөхдөө өмнөх дөрөвдүгээр бүлэгт танилцуулсан бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд өгөх нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөөний хүүхдэд тохиромжтой ашиглан аргуудаас хэрэглэнэ. Жишээ нь тоглоомд тулгуурлаж өөрийнх нь дуртай хүүхэлдэйн киноны дүрээс сонгуулан дүрд хувиран ярилцах аргыг хэрэглэвэл илүү үр дүнтэй байдаг. Боломжтой бол хүүхэдтэй тусад нь ярилцах нь хүүхдийн дэргэд гэр бүлийн гишүүд түүхийг нь ярьснаас бага цочрол авдаг. Тиймээс хүүхдийг түр тусгаарлаж, гэр бүлийн гишүүдтэй ярилцах талаар тайлбарлаж зөвшөөрөл авах хэрэгтэй.

Бага насны хүүхдийг бодоход энэ насны хүүхдүүд хаана нь өвдөж байгаагаа хэлэх, тоглоом ашиглан дүрд тоглох байдлаар ярилцахад зарим асуултад хариулах чадвартай байдаг. Жишээ нь тэднээс дараах асуултуудыг асууж болно:

- Чи эд нараас алийг нь сонгох вэ? гээд сонгуулах
- Би нууцыг хадгалагч Пороро (Тобот) байна. Хоёулаа ярилцах уу?
- Хаана нь өвдөж байна, хэн чамайг өвтгөсний?, тэр муу хүнийг эндээс олоорой (тоглоом сонгуулах)
- За миний охиныг (хүүг) энд байхад энэ яасан бэ?
- Тэгээд миний охин (хүү) яасан?
- Одоо энэ муу хүнээс айж байна уу?
- Нууцыг хадгалагч Пороро (Тобот) нь байхад айх зүйлгүй. Одоо хаана нь өвдөж байна?

Зөвлөгч дээрх байдлаар болсон явдлын талаар хүүхэдтэй ярилцах нь хүүхдийн эрүүл биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн нэн тэргүүний хэрэгцээг тодорхойлж, шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг яаралтай үзүүлэхэд тусална.

Ярилцлагын явцад хүүхдэд айх, түгших шинж тэмдэг ажиглагдвал үйл ажиллагаагаа даруй зогсоож, энгийн тоглоомын хэлбэрт шилжин ярилцлагыг дуусгана. Мөн энэ насны хүүхэд өөрсдийн дүрслэл, сэтгэл хөдлөлдөө автан хэтрүүлэгтэй, худлаа ярих тохиолдлууд байдаг тул баталгаажих асуултыг заавал тавих хэрэгтэй.

Хэрэв эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан байвал дараачийн алхам нь цагдаад даруй мэдэгдэнэ. Мөн Хүүхдийн тусламжийн утас 108-д хандаж тусламж, үйлчилгээг нэн даруй авах боломжтой. Дээр дурдчилан *бага насны буюу 0-14 насны хүүхдийг хүчиндсэн, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн бол хүнд төрлийн гэмт хэрэг учраас Зөвлөгч нь хохирогч болон гэр бүлийн гишүүд зөвшөөрсөн эсэхээс үл хамааран заавал цагдаагийн байгууллагад мэдээлэх үүрэгтэй.*

5.2.3 Гэр бүлийн гишүүдэд нь өгөх зөвлөгөө

Сургуулийн өмнөх насны хохирогч хүүхдийн гэр бүлийн гишүүдээс нэн тэргүүнд хохирогч хүүхдэд ямар туслалцаа үзүүлсэн, хаана хандсан талаарх мэдээллийг тодруулах шаардлагатай.

Хүүхдийн амьдарч буй орчинд өмнөх нөхцөл байдлыг санагдуулах зүйл бий болгохгүй байх тал дээр гэр бүлийн гишүүдэд анхааруулах шаардлагатай. Тухайлбал, гэмт хэрэгтнээс тусгаарлах, хэн нэгнийг харахаараа хүүхэд айдаг бол нүүр тулахгүй байлгах, ганцааранг нь үлдээхгүй байх, шөнө ганцааранг нь унтуулахгүй байх г.м

Цаашлаад зөвлөгч нь дам хохирогч болсон гэр бүлийн гишүүдийг тайвшруулах, цаашид хүүхдийн бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндэд үүссэн эмгэг өөрчлөлт хор уршгийг арилгахын тулд хүүхдийн эмч, хүүхдийн сэтгэцийн эмч, сэтгэл заслын эмчилгээг бусад нөхөн сэргээх эмчилгээтэй хамт заавал авах хэрэгтэйг ойлгуулах хэрэгтэй.

Мөн дээр дурдсанчлан, Зөвлөгч нь хүүхдийн бэлгийн хүчирхийллийн тохиолдлыг мэдсэн бол цагдаад заавал мэдэгдэх үүргийг хуулиар хүлээдэг гэдгээ гэр бүлийнхэнд тайлбарлаж хэлэх хэрэгтэй. (Бусад үйлчилгээнд холбон зуучлахад өгөх мэдээлэл зөвлөгөөг долоодугаар бүлгээс харна уу).



5.3 СУРГУУЛИЙН БАГА НАСНЫ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ НЬ

5.3.1 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн сургуулийн бага насны хүүхдийн онцлог

Сургуулийн бага нас (6-12 нас) нь хүүхдийн сурах, хөдөлмөрлөх суурь дадлууд амжилттай төлөвших үе юм. Энэ насны хүүхдийн гол онцлог нь хүрээлэн буй орчинтой танилцаж, өөрсдийн төсөөлөл, дүгнэлттэй болсон байдаг.

- Тэд болж буй үйл явдалд өөрийн гэсэн дүгнэлтээ өгдөг ч дийлэнхдээ өөрийгөө буруутгасан, муу хүүхэд учраас л ийм юм болчихлоо, хэн ч надад тусалж чадахгүй гэж боддогоос туслалцаа авахыг хүсэхгүй, болсон явдлыг нуун дарагдуулах сонирхолтой байдаг.
- Гэмт хэрэгтний зүгээс хохирогч хүүхдийг *"хайртай дотны хүмүүсийг чинь ална; дүүг чинь гэмтээнэ; хүнд хэлбэл муу зүйл тохиолдоно; чамайг шоронд хийнэ; хэн ч чамд итгэхгүй учраас туслахгүй"* гэх зэргээр айлган сүрдүүлсэн байдгаас энэ тухай бусадтай хуваалцахыг хүсдэггүй.
- Мөн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг нэг удаагийнх уу эсвэл олон удаа давтамжтай үйлдэгдэж байгаа юу гэдгээсээ шалтгаалаад хохирогчид олон сөрөг үр дагавар дагалддаг. Нэг удаагийн үйлдэл ихэвчлэн танихгүй хүмүүсийн зүгээс үйлдэгддэг бол олон удаагийн үйлдэл нь таньж мэддэг, ойр дотны хүмүүсийн зүгээс үйлдэгдсэн байдгаараа ялгаатай.
- Хүүхэд хүчирхийлэлд өртөж байгаагаа нуух тусам хүчирхийлэгчид гэмт хэргээ удаан хугацаанд үргэлжлүүлэн үйлдэх боломжийг олгодог. Тиймээс хүүхдүүдэд энэ тухай нь заавал хэлж, ойлгуулах шаардлагатай байдаг.

Сургуулийн бага насандаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийн олон эмгэгүүд, хор уршиг бий болох эрсдэлтэй. Нас нэмэгдэх бүр хүүхэд бусдаас айж эмээх, ичих зэргээс болж асуудлыг нуун дарагдуулах, өөрийгөө нийгэм, орчноос тусгаарладаг. Болсон явдалд өөрийгөө буруутгаж, хэн нэгэн энэ талаар мэдсэнээр маш олон хүн хохирно гэж ойлгон байнгын айдас, түгшүүртэй амьдардаг. Сурлага, бие, сэтгэхүйн хоцрогдолд хүргэдэг.

Илрэх шинжүүд: Бэлгийн хүчирхийлэлд өртсөн сургуулийн бага насны хүүхдэд дараах шинж тэмдгүүд ажиглагдаж болно.

ГАДНА БАЙДАЛ, ЗАН ҮЙЛИЙН ШИНЖҮҮД	БИЕ МАХБОД, СЭТГЭЛ ЗҮЙН ШИНЖҮҮД
Сургуульдаа явахаас айх айдас, самбарын өмнө гарч асуултад хариулахаас айх, эдгээр шалтгаанаар сургуулиасаа зугтах	Айх, нойр хулжих, дотор муухайрах, чичирч салгалах
Анхаарал сарних эмгэг: хэт хөөрлийн байдлаас болж анхаарал хэт сарних	Анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байх, сэтгэл хөдлөлөө барьж чадахгүй байдалд хүрэх
Суралцах үйл ажиллагаа доголдох: унших, бичих, тооны үйлдэл хийх г.м бүх тал дээр чадваргүйтэл илэрдэг	Түгших, зовних, цочих, байнгын айдас, ууртай, бухимдуу байх
Анхаарал төвлөрөлт муу, үеийнхнээсээ сурлагаар хоцрох	Өөрийгөө буруутгадаг, хэн ч тусалж чадахгүй гэж боддог
Өөртөө үл итгэх, бүрэг зожиг зантай болох	Биед ил харагдах бэртэл, гэмтэл анзаарагдах
Нэр төрөө хамгаалахын тулд худлаа онгирах, тусгаарлах	Орондоо шээх, өмдөндөө хүндрэх гэх мэт энэ насны хүүхдийн гаргахгүй шинж тэмдгүүд дараалан ажиглагдах
Уур уцаартай, зэрэг зан үйлийн сөрөг чанарууд илрэх гэх мэт	Босож суухад болон явахад зовиуртай, гүйж харайж чадахгүй байдал ажиглагдах

5.3.2 Хүүхдэд өгөх зөвлөгөө

Энэ насны хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөхдөө дээр дурдсанчлан дөрөвдүгээр бүлэгт танилцуулсан бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга зүйг хүүхэд бүрийн онцлогийг харгалзан хэрэглэнэ. Энэ насны хүүхэдтэй аль болох өөртэй нь болон гэр бүлийн гишүүдтэй нь тусад нь уулзвал хүүхэд айж ичихгүй ярилцах боломжтой болно. Мөн нөгөө талаар хохирогчийн дэргэд түүний түүхийг сэргээн ярих нь сэтгэлзүйн хувьд хүнд байдалд оруулдаг.

Зөвлөгч хамгийн түрүүнд бэлгийн хүчирхийллийн ямар хэлбэрт өртөж хохирсон байгааг тодорхой мэдэх шаардлагатай. Манай улсын хувьд үйлчлүүлэгчдийн дийлэнх хувь нь хүрэлцэх хэлбэрийн, түүн дотроо хүчингийн гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд л туслалцаа хүсэж хандах нь түгээмэл байдаг.

Хүүхэдтэй ярилцахдаа дотоод мэдрэмжийг гадагшлуулах тал дээр илүү ажиллавал үр дүнтэй. Хүүхдийн айдсыг таньж мэдэх, хүчирхийлэгчээс үү, эсвэл учирч болох аюулаас уу, нууцыг нь өөр хүмүүс мэдэхээс үү? гэх мэт бодит айдсыг ил гаргуулах шаардлагатай. Ингэснээр цаашдын итгэлцэл бий болж, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа үр дүнд хүрнэ.

Энэ насны хохирогч хүүхдэд ойлгуулах ёстой хамгийн гол асуудал нь *“чиний буруу биш”, “энэ үйлдлийг таслан зогсоход бид чамд тусална”, “болсон явдлыг нууснаараа энэ асуудал хэзээ ч зогсохгүй”, “өөрийнхөө ирээдүйн төлөө чи маш сайн тэмцэж чадаж байна”* зэрэг юм.

Өмнөх бага болон сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн нэгэн адил хамгийн түрүүнд эрүүл мэндийн туслалцаа үйлчилгээнд хамруулахад анхаарлаа хандуулах шаардлагатай. Дараагийн алхам цагдаад даруй мэдэгдэнэ. Дээр дурдсанчлан *Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу, бага насны буюу 0-14 насны хүүхдийг хүчиндсэн, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн бол хүнд төрлийн гэмт хэрэг учраас Зөвлөгч нь хохирогч болон гэр бүлийн гишүүд зөвшөөрсөн эсэхээс үл хамааран даруй заавал цагдаагийн байгууллагад мэдээлэх үүрэгтэй.*

5.3.3 Гэр бүлийн гишүүдэд нь өгөх зөвлөгөө

Зөвлөгөө өгөхдөө гэр бүлийн гишүүдтэй тусгайлан уулзах шаардлагатай. Ингэхдээ хэзээ энэ асуудлыг мэдсэн, хүүхэдтэйгээ хэрхэн ярилцсан, ямар хариу үйлдэл үзүүлсэн, одоо ямар харилцаатай байгаа зэргийг дэлгэрэнгүй асууж тодруулах хэрэгтэй. Гэр бүлийн гишүүдийн хохирогч хүүхдийг дүрслэн хэлж буй зан төрх, сэтгэл хөдлөл, мэдрэмжийн хариу үйлдлүүд таныхтай хэр нийцэж байгаад анхаарлаа хандуулж, зөрүүтэй мэдээллийг баталгаажуулах үүднээс баталгаажуулах асуултыг тавьж болно. Гэхдээ дахин сануулахад *“Яагаад”* гэдэг асуултаас зайлсхийхээ хэзээ ч мартаж болохгүй.

Болсон явдлын талаар хэзээ ч хохирогч хүүхдийн дэргэд ярьж болохгүй, хуулийн болон эрүүл мэндийн бусад үйлчилгээ туслалцаа авахдаа хүүхдийг заавал тусдаа байлгаж энэ тухай ярихыг гэр бүлийнхэнд сануулах шаардлагатай.

Мөн хүүхдээ буруутгахгүй байх, санаатай болон санамсаргүйгээр хүүхдийн эмзэг асуудлыг бусдад ярихгүй байх, хуулиар асуудал шийдвэрлэгдсэн ч хүүхдээ хэвийн байдалдаа ортол хамгийн сайн найз, хамгаалагч гэдгийг мэдрүүлэх шаардлагатайг ойлгуулах хэрэгтэй.

Цаашид хүүхдэд үзүүлэх үйлчилгээний талаар Зөвлөгч нь хүүхэд, гэр бүлийн гишүүдтэй хамтарч шийдвэрийг гаргана. Хүүхэд, гэр бүлийн гишүүд санал зөрөлдөн, шийдвэр



гаргахад бэрхшээл учирвал хүүхдийн эрх ашгийг нэн тэргүүнд авч үзэж, Гэр бүл хүүхэд залуучуудын асуудал хариуцсан газарт хүсэлт тавин хууль ёсны төлөөлөгч томилуулан хуулийн байгууллагаар асуудлыг шийдвэрлүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

Дээр дурдсанчлан зөвлөгч нь хүүхдийн бэлгийн хүчирхийллийг цагдаагийн байгууллагад заавал мэдээлэх үүргийг хуулиар хүлээдгээ гэр бүлийнхэнд тайлбарлаж өгөх хэрэгтэй.

Хүүхдийг заавал нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт оруулж, сэтгэл заслын мэргэшсэн эмчид хандах ёстойг тайлбарлаж гэр бүлийн гишүүдэд сайн ойлгуулах хэрэгтэй. (Бусад үйлчилгээнд холбон зуучлахад өгөх мэдээлэл зөвлөгөөг долоодугаар бүлгээс харна уу).

5.4 ӨСВӨР НАСНЫ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ, ТЭДНИЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ НЬ

5.4.1 Бэлгийн хүчирхийлэлд өртсөн өсвөр насны хүүхдийн онцлог

Өсвөр насанд (13-18) бие махбод физиологийн болон сэтгэл зүйн хувьд олон өөрчлөлтүүд гардаг. Энэ үе нь хүүхэд үеэс насанд хүрэгч болох шилжилтийн хамгийн төвөгтэй үе бөгөөд хүүхдүүд өөрийгөө “том хүн”, “насанд хүрсэн” мэтээр мэдэрч, асуудлыг бие даан шийдвэрлэхийг оролдож эхэлдэг.

Энэ насны хүүхдийн хүртэхүй нь юмс үзэгдлийг өрөөсгөл нэг талаас, хамгийн ерөнхий байдлаар тусгаж авдаг онцлогтой. Бас нэг онцлог нь насанд хүрэгчид шиг биеэ авч явах гэж хичээдэг боловч хийж буй үйлдлүүдээрээ бусдаас “хүндлэл, шагнал, урамшуулал, магтаал” авах дуртай. Бусдын хайр халамжийг авах, анхаарлын төвд байхыг илүүтэй хүсэх хүсэл биелэхгүй тохиолдолд сэтгэлээр унаж, өөртөө сэтгэл ханамжгүй болдог.

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бэлгийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэргийн хохирогчдын 40 орчим хувь нь өсвөр насны хүүхдүүд байдаг боловч мэдээлэгдээгүй гэмт хэргийн тоо үүнээс хамаагүй их байх магадлалтай. Ихэнх хохирогчид, тэдний гэр бүлийн гишүүд энэ тухай хуулийн байгууллагад мэдээлэхээс татгалзах, чимээгүй өнгөрөөх сонирхолтой байдаг нь гэмт хэргийг улам даамжруулдаг. Эдгээр онцлогийг дараах тохиолдлын жишээнээс харж болно.

Тохиолдол Хохирогч О.Э-гийн өгсөн мэдүүлгээс: ...Би 11 настай байхад хойд аав Б.Э нь 2016.11.26-ны өдөр ээж төрсөн өдрөө тэмдэглэхээр гадагшаа гарчихсан, 2 дүү унтсаны дараа 23 цаг өнгөрч байхад миний оронд орж ирж хувцас тайлаад “чи орилоод хэн ч чамд туслахгүй шүү” гээд хүчиндсэн. Энэ үйлдэл болсноос хойш 3 хоногийн дараа би ээжид болсон зүйлийн талаар хэлэхэд ээж шууд Б.Э-ын аав, ээж рүү залгаад “манай охиныг хүчиндсэн байна” гэж хэлсэн. Эмээ, өвөө 2 ирээд “насанд хүрээгүй хүүхэд хүчиндсэн” гээд өвөө Б.Э-ыг зодоод намайг тусдаа байлгана гээд эмээ, өвөөгийн гэрт байлгах болсон. 7 хоногийн дараа ганцаараа хичээлээ хийгээд байж байхад Б.Э цайны цагаараа орж ирээд миний нүдийг юмаар таглаж боогоод ёс бусаар хүчиндсэн. Б.Э “би чамд гоё юм өгч байгаа биз дээ?” гээд нүдний боолтыг аваад намайг орон дээр шидсэн. “би чамд хэлсэн зүйлээ олон хэлэхгүй шүү. Чи ээжгүй болно гэж мэдээрэй. Би чамайг байхгүй болгоно шүү” гэж заналхийлсэн. Энэ үйлдэл болсны дараа ангийн багшид хэлэхэд багш ээжийг дуудаад цагдаад хэлье гэхэд ээж хэрэггүй гээд намайг эмнэлэгт үзүүлсэн. Би төрсөн аавдаа утсаар болсон зүйлийн талаар хэлээд аав Улаанбаатараас ирээд цагдаад өргөдөл гаргаж өгөөд буцсан. Энэ хооронд ээж надаас мэдүүлгээ өөрчилж өг гэж гуйгаад, ээжгүй амьдрахыг хүсэж байвал бүх зүйлийн талаар хэл гээд уурлахаар нь би мэдүүлгээ өөрчилж өгсөн (www.shuukh.mn)

Илрэх шинжүүд: АНУ-ын Манчестрийн Их сургуулийн сэтгэл зүйч Шери Дирестэрийн хүчингийн гэмт хэргийн хохирогч хүчиндүүлсний дараах үедээ доорх 5 процесс явагдсаны дараа тайвширдаг гэж үзсэн байна. Эдгээр өөрчлөлтүүд хүчингийн хохирогч өсвөр насны хүүхдэд мөн түгээмэл илэрдэг байна. Үүнд:

Бусдыг болон өөрийгөө үгүйсгэдэг	•Хүчингийн хэрэг болоогүй, болох ёсгүй байсан гэдэгт итгэдэг.
Сэтгэлдээ болж өнгөрсөн үйл явдлыг нуух гэж оролддог.	•Энэ үедээ өөрийгөө өршөөх гэсэн хандлага гарч, өөртөө туслах хүнийг эрдэг
Жинхэнэ уур хилэн үүсэх процесс явагддаг	•Эрчүүдийг үзэн яддаг. Энэ нь түүний өөртөө биш гадагш чиглэсэн уур хилэн юм
Сэтгэлийн дотоод уур хилэн	•Сэтгэлийн дарамтад орж хямардаг тул өөрийгөө сайн ойлгох хүнийг дахин хайж эхэлдэг
Өөрт тохиолдсон уг үйлдлийг хүлээн зөвшөөрөх	•Энэ үед нь сэтгэлийн дэм өгөх хэрэгтэй. Тэд өөрсдийгөө тодорхой хэмжээгээр буруутган ирээдүйгээ өөдрөгөөр харах явдал нь багасдаг

Хэрэв тухайн үе шатуудад тохирсон зөвлөгөө, тусламжийг авбал цаашид учрах хор хохирол, үр дагавар тэр хэмжээгээр багасдаг.

Илрэх шинжүүд: Бэлгийн хүчирхийлэлд өртсөн өсвөр насны хүүхдэд доорх шинж тэмдгүүд дангаараа болон хавсран ажиглагдаж болно, эсвэл ажиглагдахгүй байж ч болно. Сэтгэл зүйн гэмтэл авсан өсвөр насны хүүхдийн өөртөө итгэх итгэлд мэдэгдэхүйц өөрчлөлтүүд илэрдэг. Түүнээс гадна хүүхдийн сэтгэл санааны байдал огцом өөрчлөгддөг. Зөвлөгч энэ насны хохирогчдод зөвлөгөө өгч байх явцдаа тэдний зан төрх, биеэ авч яваа байдал, бие махбодын болон сэтгэл зүйн талаар дараах шинж тэмдгүүд илэрч байгаа эсэхийг сайтар ажиглах хэрэгтэй.

ГАДНА БАЙДАЛ, ЗАН ҮЙЛИЙН ШИНЖҮҮД	БИЕ МАХБОД СЭТГЭЛ ЗҮЙН ШИНЖҮҮД
Байнга уур, бухимдалтай, стресс ихтэй байдал ажиглагдана.	Уур бухимдлаа тайлахдаа түрэмгий авирлах, томчуудыг эсэргүүцэх, сөргөлдөх, нийгмийн хэв журам зөрчих зэргээр илрэх магадлал нэмэгдэнэ
Гэр бүлийнхэн, үе тэнгийнхэнтэйгээ харилцах харилцааны хүрээлэл эрс өөрчлөгдөнө	Нойр, хооллох дуршлын эмгэгүүд (Хоолны дуршилгүй болох, бөөлжис цутгах, эсвэл хоолонд хэт дурлах, хэт турах, таргалах эмгэг) болон зүрх судасны өвчинд өртөмхий болно.
Найрсаг байсан хүүхэд түрэмгий, танхай, идэвхтэй байсан нь идэвхгүй, үл үзэгдэгч болох зэрэг зан аашны огцом хувирал цөөнгүй ажиглагдана.	Өөрийгөө “золигт гаргах” буюу эсэргүүцлээ сөрөг зан үйлээр илэрхийлж архи уух, мансуурах, гадуур тэнэх, хулгай хийх, биеэ үнэлэх, сүнс, хий үзэгдэл, мухар сүсэг гэх мэт бодит бус юманд итгэх г.м
Өмнө нь нийцгүй, эсэргүүцэж байсан хүмүүстэйгээ нийлэх, эсвэл зожирч ганцаардах, өөрийгөө бусдаас тусгаарлах	Өсвөр насны жирэмслэлт болон нөхөн үржихүйн өвчлөл, БЗДХ тусах, өвчин нь эмчлээгүй, буруу дутуу эмчилснээс архагшсан байх



Өөрийгөө үнэлэх үнэлэмжгүй болж бусдын дунд зохистой байр суурь эзлэх чадваргүй гэж чамлах	Бэлгийн хэвийн бус төрх үйлдэл гаргах, аарцгийн эрхтнүүдийн цусан хангамж, булчин, ясжилтын тогтолцоо, гэмтэл, хууль бус үр хөндөлтийн ул мөр үлдсэн байх
Архи тамхи, мансууруулах бодис хэрэглэх	Сэтгэл гутралд орох, сэтгэцийн хөнгөн, хүнд хэлбэрийн эмгэгтэй болох
Суралцах сонирхолгүй, анхаарал төвлөрөл тааруу, нийгмийн харилцаанаас зайлсхийх	Амиа хорлохыг оролдох, зарим тохиолдолд амиа егүүтгэх

5.4.2 Өсвөр насны хүүхдэд өгөх зөвлөгөө

Өсвөр насны бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүд өмнөх насны хүүхдүүдтэй харьцуулахад өөрсдийгөө илэрхийлэх чадвар сайтай, өөрт нь тохиолдож буй зүйлд хэн туслах, аюулгүй байдлаа хэрхэн хангах, асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой хэмжээний мэдээлэлтэй байдаг онцлогтой. Иймд өсвөр насны хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөхдөө Зөвлөгч нь маш **МЭДРЭМЖТЭЙ**, мэргэжлийн өндөр түвшинд ажиллах шаардлагатай.

Анхны уулзалт хийхдээ: Олон шалтгааны улмаас өсвөр насныхан гэр бүлийнхнийхээ хажууд болж өнгөрсөн асуудлын талаар бүрэн мэдээлэл өгч чаддаггүй. Иймд энэ насны хүүхдэд зөвлөгөө өгөхдөө гэр бүлийн гишүүдээс нь тусдаа уулзах нь илүү үр дүнтэй байдаг.

Зөвлөгч нь өсвөр насны хүүхэдтэй анх уулзахаас л эхлээд өөрийн үг хэл, биеийн хэлэмж, үйл хөдлөлөөрөө хохирогчийг үл хүндэтгэсэн, үл тоомсорлосон, тохуурхсан байдал гаргахгүй байхад маш их анхаарах хэрэгтэй. Хохирогчийн өөрийгөө доромжлогдсон гэж эмзэглэж байгаа үед нь ийм байдал гаргах аваас тэд: “Энд хэрэггүй л ирлээ”; “Би бас л буруу зүйл хийчихлээ” гэж эмзэглэн мэдүүлэг өгөх үйл явцаас няцахад хүргэдэг.

Иймд зөвлөгч анхны уулзалтаас л тэдэнд **ИТГЭЛ ТӨРҮҮЛЭГЧ** байх ёстой. Таны дуу хоолой, харц, өөрийг нь сонсох хүсэлтэй, тусалж чадах хүнээ олоод ирлээ гэх сэтгэгдлийг анхны уулзалтаар төрүүлэх ёстой. Гэхдээ хуурамч дүр гаргаж болохгүй. Бүх зүйлд үнэн сэтгэлээсээ хандвал зөвлөгч, өсвөр насны хохирогчийн хооронд итгэлцэл бий болдог.

Болсон явдлын талаар яриулахдаа: Анхны холбоо тогтоож, танилцсаны дараа өсвөр насны хохирогч хүүхдээр болсон явдлын талаар яриулж, түүнийг маш анхааралтай сонсох хэрэгтэй. Ингэхдээ хохирогч хүүхдэд өөрт нь тохиолдсон явдлыг өөрийн дүрслэл, хэмнэлээрээ ярих боломжийг олгоход анхаараарай. Анхны ярилцлагаар хэргийн бодит байдлын талаар аль болох их зүйл олж мэдэхийг хичээх хэрэгтэй. Ингэснээр хүүхэдтэй дахин энэ асуудлыг сэргээж ярьж, сэтгэлийн хямралд оруулахаас зайлсхийж чадна.

Хүчин, бэлгийн халдлагаас хохирогч сэтгэлийн гүн шарх авсан учир дахин дахин яриулах, олон байцаагч, олон шат дамжлаг дамжин мэдээлэл авах нь хохирогчийг үл хүндэтгэн сэтгэлийн шархыг нь хөндсөн давхар хүчирхийлэл, сэтгэлийн дарамт болдог. Тухайн болсон явдлын талаар хохирогчоор яриулах нь **НЭГ УДААГИЙНХ БАЙХ** нь маш чухал.

Өсвөр насны хохирогчоор болсон явдлын талаар яриулж мэдээлэл авч байхдаа тэдний дараах онцлогуудыг тооцоорой. Үүнд:

- Өсвөр насныхны болсон явдлыг нарийвчлан ярих үг хэллэг нь томчуудтай адилгүй бөгөөд тойруу замаар илэрхийлэх, эсвэл өөрийн ойлгоцоороо өөр үг хэллэг хэрэглэдэг.
- Болсон явдлын талаар ярихдаа хохирогч зарим нэг зүйлийг огт ярихыг хүсдэггүй.
- Ярилцлага амжилттай болж байгаа тохиолдолд хохирогч хамгийн хэцүү муухай санагдсан зүйлээ ярианыхаа эцэст хэлдэг.
- Тэд маш эмзэг. Хэрэв ярилцлагын явцад буруутгах, шоолох хандлага гаргах болон ийм маягийн асуулт тавихад ярихыг хүсэхгүй болдог тул хохирогч дахин ирэх хүсэлгүй болдог.
- Өсвөр насны хохирогч хүүхдээр болсон явдлын талаар яриулахдаа дараах зүйлүүдийг анхаараарай. Үүнд:
- Тэднээс хэтэрхий дэлгэрэнгүй болон ямар нэгэн дэс дараатай ярихыг бүү шаард.
- Тэд хэлэх гэсэн зүйлээ өөрийнхөөрөө ярьж дууссаны дараа тодруулах асуултуудаа тавиарай.
- Тэдэнд өөрийнхөөрөө ярьж дуусгах боломжийг олгоод ярилцлагыг идэвхжүүлэх үүднээс дэмжсэн үг хэллэг хэрэглэж болно. “аан тийм үү”, “тэгээд яасан билээ”, “... чинь найз нь билүү” гэх мэтээр яриаг нь анхааралтай сонсож байгаагаа өөрт нь харуулбал хүүхдэд зөвлөгчид улам бүр итгэлтэй болдог.
- Ураг төрлийн хүчингийн гэмт хэргийн үед хохирогч өсвөр насныхан танихгүй хүнд хүчиндүүлсэн хүчингийн гэмт хэргээс илүү их сэтгэлийн дарамт, шоконд орсон байдаг тул хэрэг гарсан тухайн үеийн цаг хугацаа болон бусад зүйлсийг санаж үнэн зөв мэдүүлэг өгөх нь тэдэнд бэрхшээлтэй байдаг. Ийм үед зөвлөгч дараах санаануудыг хүүхдэд хэлж, дэм өгөх хэрэгтэй.
- “Энэ болж өнгөрсөн хэрэг явдал чамаас болоогүй, хүчирхийлэл үйлдэгч чамайг өөрийн эрхэндээ байлгах гэсэн хүслээс болсон”;
- “Хүчирхийлэл үйлдэгч чамд хайртайдаа гэж хэлж байгаа ч үнэн хэрэгтээ хүн хайртай хүндээ муу зүйл хийдэггүй. Хэрвээ сайн зүйл байсан бол тэр хүн нууцлах шаардлагагүй байсан”;
- “Чиний эсэргүүцэл үзүүлсэн чинь сайн байна. Чи өөрийгөө чадах чинээгээрээ хамгаалан түүнийг эсэргүүцсэн байна” гэх мэт. Энэ бүхний дараа хохирогч тодорхой хэмжээгээр тайвширч хэвийн байдалдаа ордог.
- Зарим хүчирхийлэл үйлдэгч хүүхдэд “чамд хайртай, чамд дурласан, бүх л охид адилхан ингэж байгаа” зэргээр хохирогчийг төөрөлдүүлдэг. Ингэж ятгаснаас “сайн хүнийхээ эсрэг муу зүйл хийж байгаа юм шиг сэтгэгдэл” өсвөр насныханд төрдөг учраас “хуулийн байгууллагад хандмааргүй байна”, “шоронд явуулмааргүй байна” гэх зэргээр асуудалд хандаж төөрөлддөг. Энэ тохиолдолд Зөвлөгч хохирогчийг буруутгах бус, “энэ асуудал бол хүнд гэмт хэрэг, таслан зогсоохгүй бол үргэлжилсээр байх болно” гэдгийг сайн ойлгуулах шаардлагатай.



ПРАКТИК ЗӨВЛӨМЖ

- Өсвөр насны хохирогчтой ярилцаж байхдаа Зөвлөгч та өөрийн сэтгэлийн хөдөлгөөнөө хэтэрхий ил бүү гаргаарай. Хэрэв та уйлах, хэт хямрах, инээх зэрэг мэдрэмжүүдийг үзүүлбэл хүүхэд зөвхөн нэг талаас нь хүлээж авч, өөрийнхөөрөө дүгнэлт хийдэг сөрөг талтай. Жишээ нь: Та кейсийг сонсох явцдаа уйлбал “надад өөр хэн ч тусалж чадахгүй юм байна”, “энэ зөвлөгч хүртэл уйлж байхад” гэх мэт сөрөг үр дагавар гардаг.
- Хэрэв хохирогч түүхээ ярих явцдаа маш эмзэг, уйлж, хямарч байвал цай кофе уухыг санал болгох зэргээр түр завсарлаад үргэлжлүүлэх эсэхийг өөрөөс нь дахин лавласны дараа шийдвэрээ гаргаарай.
- Мөн хамт ирсэн гэр бүлийн гишүүнтэй ярилцах эсэх талаар хохирогч хүүхдийн саналыг заавал сонсох хэрэгтэй байдаг.
- Зөвлөгч нь ямар үед ярилцлагаа үргэлжлүүлэх, хэзээ түр завсарлах, зогсоох талаар мэргэжлийн маш нарийн мэдрэмжтэй байхыг шаарддаг. Тиймээс ярилцлагын явцад хохирогчийн сэтгэл хөдлөл, мэдрэмжийг байнга анхаарч байх шаардлагатай.

Ярилцлагаар өсвөр насны хохирогчоос **ЮУ ХҮСЭЖ БАЙГААГ** олж мэдэх нь маш чухал. Иймд хохирогч ярилцлагадаа зөвлөгчөөс юу хүсэж байгаагаа хэлсэн эсэхэд анхаарлаа хандуулах шаардлагатай. Жишээ нь:

- Ихэнх хохирогч ярилцлагын явцад *“..би тантай уулзвал ... шийдэгдэнэ гэж бодсон”* гэх мэтээр хүсэж буй зүйлээ хэлсэн байдаг. Хэрэв хохирогч хүүхэд хүсэж байгаа зүйлээ хэлсэн бол түүнийг нь эргэн сануулаад *“өөр хүсэлт юу байна”* гэдгийг дахин тодруулах шаардлагатай.
- Жишээ нь хохирогч хуулийн байгууллагад хандах талаар туслалцаа хүсэхээр ирсэн бол яг ямар үр дүн хүсэн хүлээж байгааг нь олж мэдэх хэрэгтэй. Ихэнх тохиолдолд хохирогч асуудлыг таслан зогсоох, нөхөн олговор авах, хүчирхийлэгчийг өөрийнх нь амьдралд дахин хэзээ ч орж ирүүлэхгүй байхыг хүсдэг. Хуулийн байгууллагад хандахад туслалцаа хүсэж буй хохирогчийг энэ чиглэлээр ажилладаг мэргэшсэн төрийн бус байгууллага, өмгөөлөгчтэй холбож өгснөөр хохирогч хуулийн бүх шатанд эрхээ хамгаалах боломжийг нээж өгнө.
- Хэрэв хохирогч эрүүл мэндийн байгууллагад хандахад туслахыг хүсэж ирсэн бол холбогдох байгууллагуудтай нь холбон зуучилж туслах шаардлагатай. Гэхдээ Зөвлөгч өөрийн хийж чадахгүй, хийх боломжгүй зүйлийг худлаа амлаж болохгүй. Бүх зүйл бодитой, хэрэгжиж буй хууль, дүрэм журмын хүрээнд байх шаардлагатайг мартаж болохгүй. Учир нь бодитой бус амлалтаас үүдэн гарах сөрөг үр дагаврыг тооцоолох боломж хязгаарлагдмал байдаг. Зөвхөн шүүхийн шийдвэр гарснаар л биелэгдэх зүйлүүдэд Зөвлөгч ямар нэгэн амлалт өгөх боломжгүй.

5.4.3 Гэр бүлийн гишүүдэд нь өгөх зөвлөгөө

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн өсвөр насны хүүхдийн гэр бүлд маш сайн дүн шинжилгээ хийх хэрэгтэй. Гэр бүлийнхний талаар аль болох тодорхой, бодитой, тоо мэдээгээр илэрхийлж болохуйц мэдээлэл авахыг хичээх хэрэгтэй (Гэр бүлд дүн шинжилгээ хийх талаар илүү дэлгэрэнгүйг дөрөвдүгээр бүлгээс харна уу).

Хүүхэд цаашид энэ гэр бүлд амьдрахад аюултай юу, эмзэг, эрсдэлтэй байдалд нөлөөлөх хүчин зүйлүүд нь юу байна, хүүхдийг хэн хамгаалах боломжтой, цаашид гэр бүлээс хүүхдийг тусгаарлах, эсвэл гэр бүлийн орчинд нөхөн сэргээх боломжтой эсэхийг тогтоох зэрэг мэдээллийг маш сайн цуглуулахад анхаарах шаардлагатай. Гэхдээ цагдаагийн байцаалт шиг байж болохгүйг анхаараарай.

Цөөн тохиолдолд хохирогчийн гэр бүлийн гишүүд *“гэр бүлийн нэр төрөө бодож байна”, “манай гэрийн тэжээгч, асуудлыг гадагш нь задруулахгүй”, “хүүхдийн маань ирээдүйд сөрөг нөлөөтэй”* гэх зэрэг шалтгаанаар хохирогч хүүхдийг хэргийн талаар аль болох

яриулахгүй байх, өмнөөс нь ярих, өөрсдөө шийдвэр гаргах зэргээр оролцдог. Цагдаагийн байгууллагад битгий мэдээлээч гэж гуйдаг. Ийм тохиолдолд Зөвлөгч нь мэргэжлийн ёс зүйн журмаа баримталж, **ХҮҮХДИЙН ЭРХ АШГИЙГ НЭН ТЭРГҮҮНД** тавьж ажиллавал зохино.

Ярилцлагын төгсгөлд хохирогч, түүний гэр бүлийн гишүүдэд цаашид ямар арга хэмжээг, ямар үе шатаар авах, ойролцоогоор ямар хугацаа зарцуулах, ямар бичиг баримт шаардлагатай талаар сайтар ойлгуулж, хамтарсан шийдвэр гаргах хэрэгтэй. Шийдвэр гаргах явцад хохирогчийн гэр бүлийн гишүүдийг хамт байлцуулна (Бусад үйлчилгээнд холбон зуучлахад өгөх мэдээлэл зөвлөгөөг долоодугаар бүлгээс харах).



БҮЛЭГ 6. УРАГ ТӨРЛИЙН ХҮЧИН, БЭЛГИЙН МӨЛЖЛӨГ, ЦАХИМ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД ӨГӨХ ЗӨВЛӨГӨӨ

6.1 УРАГ ТӨРЛИЙН ХҮЧИНГИЙН ХОХИРОГЧ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ГЭР БҮЛД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ НЬ

Хүүхдийн ураг төрлийн бэлгийн хүчирхийллийн талаар бид хоёрдугаар бүлэгт цухас дурдсан билээ. Энэ төрлийн бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд болон тэдний гэр бүлийн гишүүдтэй ажиллахад хамгийн ээдрээтэй байдаг талаар мэргэжилтнүүд олонтой ярьдаг. Иймд ураг төрлийн хүчингийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх асуудлыг энэ бүлэгт нэлээд дэлгэрэнгүй авч үзсэн болно.

6.1.1 Хүүхдийн ураг төрлийн бэлгийн хүчирхийллийн онцлог

Гэмт этгээдүүд энэ гэмт хэргийг үйлдэхдээ хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх аргаар үйлдэхээсээ илүү хохирогч хүүхдэд сэтгэл зүйн дарамт үзүүлэх, ятгах, итгүүлэх, хууран мэхлэх аргыг ихэвчлэн ашигласан байдаг. Тэд буруу зүйл хийж байгаагаа сайн мэддэг учраас хэрэг үйлдсэнийхээ дараа хариуцлага хулээхгүйн тулд гэмт үйлдлээ бусдад мэдэгдэхгүй, цааш үргэлжлүүлэх зорилгоор сайтар **НУУЦАЛДАГ**. Тухайлбал: “Зөвхөн бид хоёрын нууц шүү, хүнд хэлж болохгүй, аав болгон л охинтойгоо үүнийг хийдэг, чамайг үнэхээр сайхан болохоор өөр хүнд алдахаасаа айгаад, би чамд хайртай болохоороо” г.м төөрөгдүүлэх зүйлийг ярихаас гадна “Дүүг чинь ийм болгоно, та нарыг бүгдийг алчихаад өөрийгөө ална, ээжийг чинь ална” гэх мэтээр хохирогчийг айлган сүрдүүлдэг. Ингэж хэргийг нууцлах нь хэрэгтэнд үйлдлээ олон дахин **ДАВТАН ҮЙЛДЭХ** боломж олгодог.

Ураг төрлийн бэлгийн хүчирхийлэл үйлдэгч бүх зүйлийг хяналтдаа байлгаж, төлөвлөж үйлддэг тул илрэх боломж маш байнга байдаг ба мэдээлэгдэхгүй удаан **НУУГДМАЛ** явагддаг. Ихэнх тохиолдолд хохирогч БЗДХ авсан, жирэмсэн болсон, бэртэж гэмтсэн, улмаар амь нас, эрүүл мэндэд нь аюул тохиолдсон эсвэл гарцаагүй байдлаар хэн нэгэн мэдсэн, эсвэл хохирогч хүүхэд хэн нэгэнд хэлж, туслалцаа хүссэн тохиолдолд илэрдэг. Улсын Ерөнхий Прокурорын Газраас хийсэн судалгаагаар ураг төрлийн хүчингийн гэмт хэрэг дунджаар 4 жилийн дараа хохирогч жирэмсэлж, үгүй бол өөрөө цагдаагийн байгууллагад мэдүүлснээр илэрсэн байдаг.

6.1.2 Ураг төрлийн бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг ойлгох нь

Уг гэмт хэргийн дээрх өвөрмөц байдлаас үүдэн дараах онцлогууд ажиглагддаг:

- Хүчирхийлэл удаан үргэлжилснээс хохирогч удаан хугацааны сэтгэлзүйн дарамтад автсан байдаг.
- Нэг талаас гэмт этгээдийн айлган сүрдүүлэлт, заналхийлэл, нөгөө талаас самгардалт, эргэлзээ, өөрийгөө буруутгах гэмшил, төөрөгдөл, гэр бүлийнхээ гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалж байна гэж бодох, айж ичих зэргээс хохирогч хүчирхийллийг нууж тэвчсээр ирсэн байдаг.
- Нуугдмал, далд орчинд үйлдэгддэг энэ гэмт хэргийн халдлагад дахин өртөх эрсдэл

маш өндөр бөгөөд хохирогчид бие махбодын болон сэтгэл зүйн хүнд хор уршиг бий болох өндөр эрсдэлтэй.

- Зарим хохирогч хүчирхийллийн талаарх дурсамжаа хүчээр мартахыг оролддог. Ингэснээрээ сэтгэл зүйн дарамт нь түр хугацаанд амсхийх боловч удах тусам энэ нь сэтгэцийн илүү ноцтой өөрчлөлтөд хүргэх магадлалтай.
- Зарим хүүхдэд зан үйлийн мэдэгдэхүйц өөрчлөлт илрэхгүй, тэдний хувьд яг юу болоод байгааг ойлгож ухаараагүй байх нь бий. Эдгээр онцлогуудын заримыг дараах тохиолдлын жишээнүүдээс харж болно.

Тохиолдол ... Миний ээж намайг 3 настай байхад Х-тэй гэр бүл болсон, энэ хүнтэй суугаад 3 хүүхэд төрүүлсэн. 2017.8.11-ний өдөр ээж 3 дүүгийн хамт 15 цагийн орчим үсний найранд явчихсан би хойд аавтай гэрт хоёулхнаа үлдсэн байсан. Орой 19 цагийн үед хойд аав архи уучихсан орж ирээд хажууд суугаад хөх, хүзүү, цээж хэсэгт үнсээд, болиоч гээд гараараа түлхсэн чинь миний 2 гарыг бариад авсан. Хажууд байсан гар утсыг авах гэсэн чинь утсыг аваад шидчихсэн. Арайхийж болиулахад өөрийнхөө хажууд суу гэхээр нь үгүй гэсэн чинь сандал далайхаар нь айгаад хажууд нь суусан. Тэгсэн би чамд хайртай ээж, охин хоёрын хэнд нь их хайртай гэдгээ мэдэхгүй байна гэхдээ би чамд хайртай болсон болохоор орой болгон чамтай унтаж байна гэж зүүдэлдэг гээд сонин сонин юм яриад байсан. Би үнэхээр их айгаад юу ч хэлж чадахгүй, айгаад аясаар нь хажууд нь суугаад байсан. Тэгсэн аавынхаа орыг засаад өгөөч, ээждээ энэ тухай битгий хэлээрэй, өөрт нь хайргүй чамд хайртай болсныг мэдвэл гомдоно, аав нь унтаж амарлаа гэхээр нь гэрт орж орыг нь засаж байхад орж ирээд хүчиндсэн. Тэр үед яг юу болсныг сайн ойлгоогүй, ухаан алдсан ч юм шиг болсон байсан (www.shuukh.mn).

Ураг төрлийн хүчингийн гэмт хэргийн хохирогч хүүхдэд наснаас нь хамаарч өөр өөр шинж илэрдэг ба үр дагавар нь ч өөр байдаг. Мөн тэдний бэлгийн боловсролын талаарх мэдлэг мэдээлэл хомс байдал ихээхэн нөлөөлдөг. Хэрэв хохирогч бага насны хүүхэд бол уг үйлдэл нь түүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байх эрхэнд халдаж байгааг ойлгох чадваргүй байна. Мөн хайр энхрийлэл, хүчирхийлэл хоёрын ялгааг мэдэхгүй, мэдсэн ч болсон явдлыг илэрхийлэх чадваргүй байдаг нь доорх тохиолдлын жишээнээс харагдаж байна.

Тохиолдол ... Би тухайн үед 11 настай байсан...2014 оны хавар...би дүүтэйгээ унтаж байхад хойд аав миний бэлэг эрхтэн рүү хуруугаа хийгээд, дээр гарч хөдлөөд байсан... миний бэлэг эрхтэн өвдөөд би ээжээ гээд дуудсан чинь ээж сэрээгүй, заваан нялцгай юм гаргаад аав босоод явчихсан. Үүнээс хойш бараг 3 жил гаруй үргэлжилсэн. Миний сарын тэмдэг ирэхээ больчихоор нь ээжид хэлэхэд ээж, намайг Эх нялхас дээр аваачиж үзүүлэхэд 1 сартай жирэмсэн байна гэж хэлсэн. Миний сарын тэмдэг 12 настай байхад ирж байсан ба ааваасаа өөр ямар нэгэн хүнтэй унтаж үзээгүй, ганцхан аав л надтай унтсан юм. ... аав надтай бэлгийн харьцаанд орохдоо ... ээждээ хэлбэл ална шүү, бүгдийг нь алчихаад өөрийн амиа хорлоно шүү гээд байдаг болохоор хүнд хэлж чадаагүй. (www.shuukh.mn)

Энэ тохиолдлоос харахад гэмт этгээдийн заналхийлэл, сүрдүүлгээс айгаад хохирогч энэ тухай хэнд ч хэлж чаддаггүй, чимээгүй байснаар гэр бүлээ хамгаалж байна гэж ойлгодог нь харагдаж байна.



Тохиолдол ... Б нь дагавар охиноо 13 настайгаас нь, өөрийн төрсөн охиноо 11 настайгаас нь эхлэн хөхийг нь барьж үзэх, бэлэг эрхтнийг нь үнсэж, хэлээрээ оролдох зэргээр байнга удаа дараагийн давтан үйлдлээр бэлгийн дүр хүслээ ёс бусаар хангаж, охидыг 7 хоногт 4-5 удаа буюу байнга, хүч хэрэглэн давтан үйлдлээр хүчиндсэн...- Ааваа та яагаад байгаа юм бэ? болиоч гэхээр энэ чинь амьдрал, чи том болоод ийм зүйлтэй учрах болно, танай найзуудын аав нар ч гэсэн ийм зүйл хийдэг гэж хэлсэн. Эсэргүүцээд ээжид хэлнэ гэж уурлахад хацар, чих рүү алгадах, гар утасны цэнэглэгчийн нарийн утсаар ороолгох, идэж байсан хоолоо авч шидэх, сандал, цүнх ном авч шидээд ор руу нуруугаар шидэх, тархи толгой, бөгсийг гаргаж цохиж зодон аймаар уурладаг. Охид 2 биеэ хүчиндүүлж байгааг мэдээгүй, дүүг чинь, эгчийг чинь ингэнэ гэж зоддог учир бие биээ хамгаалахын тулд тэвчиж байсан. Мөн хутга хаана байна, би ээжийг чинь алаад өөрийгөө алаад та нарыг бас хутгалж ална барина гэдэг байсан (www.shuukh.mn).

Энэ тохиолдол нь зарим хэрэгтэн хохирогчийг чимээгүй байлгахын тулд зодох, хүлэх гэх мэт хүч хэрэглэн удаан хугацаанд бие махбодын хүчирхийлэл давхар үйлдсээр байдгийн бодит жишээ юм.

Илрэх шинжүүд: Ураг төрлийн бэлгийн хүчирхийлэл нь удаан хугацаанд үйлдэгддэг тул хохирогч хүүхдийн сэтгэл зүйн ноцтой гэмтэл, сэтгэцийн эрүүл мэндийн ноцтой үр дагаварт хүргэх өндөр эрсдэлтэй. Хохирогчид илрэх гадаад шинж тэмдэг нь харилцан адилгүй байна.

УРАГ ТӨРЛИЙН БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧИД ҮҮСЭЖ БОЛОХ СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУДЛУУД

- Сэтгэл гутрал
- Сэтгэл түгшүүр
- Хүнд гэмтлийн дараах дарамтат эмгэг
- Өөртөө итгэлгүй болох
- Архи, мансууруулах бодис хэрэглэх
- Нойрны хямрал
- Хоол идэх дуршлын эмгэг
- Сандрах эмгэг
- Нийгмээс өөрийгөө тусгаарлах
- Амиа хорлох бодол тээх, оролдлого хийх гэх мэт

Хүчингийн хохирогч өсвөр насныхны сэтгэл зүйн талаас дараах эргэлзээ, ичгүүр, гомдол хорсол, айдас илэрдэг байна.

ЯАГААД БИ ГЭЖ?

Хохирогч яагаад энэ явдал чухамхүү түүнд тохиолдов хэмээн өнгөрсөн явдлын учир шалтгааныг олохыг эрмэлздэг. Энэ нь өөрийнхөө амьдралд ямар нэгэн хяналт, эмх журам тогтоох гэсэн оролдлого юм. Ийм явдал гаргуулахгүйн тулд миний зүгээс хийж чадах зүйл байв уу? Хэрвээ... хэмээн хохирогч өөрөөсөө асуудаг. Ийм зүйлийг дахин давтагдуулахгүйн тулд би юу хийх, юуг хийхгүй байх ёстой вэ? гэдэг дээр байнгын санаа зовж эхэлдэг.

ИЧГҮҮР

Хүчингийн хохирогчдын үзүүлэх ердийн хариу урвал нь тэднийг дорд үзсэн, хэн ч биш болгосон, ямарваа нэгэн зүйлийг нь булаагаад авчихсан, өөрсдийгөө бузарлагдсан гэж үздэг. Энэ нь хохирогч өөрийгөө өөрчлөгдсөн ба түүнийг нь бусад хүмүүс харж ажиглаж байна гэсэн мэдрэмжтэй хосолдог. Түүнээс гадна олон хохирогчид гэмт хэргээс зугтаж,

зайлуулж чадаагүйдээ өөрсдийгөө буруутгах ч явдал гардаг. Хүн бүр өөрийг нь мэдээд шоолж, гадуурхаж байгаа мэт санагдан, ичгүүрийг мэдэрч өөрийгөө бусдаас тусгаарлаж эхэлдэг.

ГОМДОЛ- ХОРСОЛ

Бэлгийн хүчирхийллийн хохирогчийн гомдол, хорсол нь гэмт хэрэгтэн өөрөөс нь давуу байдалтай, эрх мэдэлтэй, хүч чадалтай байсанд, эсвэл хэн ч өөрийг нь хамгаалж чадаагүйд, цаашдаа хэн ч өөрийг нь хамгаалж чадахгүйд, амьдарч буй амьдралдаа, гэр бүлийн гишүүддээ, заримдаа хохирогчид өөрөө өөртөө гомдож, хорсдог. Энэ нь сэтгэл санаанд болж буй зөрчилдөөнтэй холбоотой үүсдэг.

АЙДАС

Хүчингийн дараа хохирогчийн хувьд ертөнц хэзээ ч өмнө нь байсан шигээ болдоггүй. Ердийн нөхцөл байдал ч аюултай санагддаг. Энэ нь хохирогчийн гэр орон ба орчин тойронд хамааралтай юм. Болж өнгөрсөн явдлыг байнга бодох нь аймшигтай хар дарсан зүүд, сэтгэл гутрал, гүн айдас, сэтгэлийн шаналалд хүргэж болдог.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн бүх хохирогчдод сэтгэл санааны хувьд дараах өөрчлөлтүүд ажиглагддаг:

- Багтрах, хэт сандрах, уймрах, салгалах, унах, татах
- Байнгын айдас, түгшүүр, сэтгэл зүйн хэт хөдлөл
- Хүмүүст итгэх итгэл алдрах эсвэл хүмүүстэй хэт задгай харилцах
- Хүчирхийллийн тухай бодлыг зайлуулах, өөрөөсөө холдуулах, мартах, тайвшрах чадваргүй.

6.1.2 Ураг төрлийн бэлгийн хүчирхийллийн хохирогчийн гэр бүлийнхний онцлог

Энэ гэмт хэргийн хохирогч хүүхдийн ойр дотны хүмүүс нь хохирогч хүүхдийг аюултай байдлаас даруй тусгаарлаж, хамгаалахын оронд буруутгаж, цагдаагийн байгууллагад мэдэгдэхэд өргөдөл гомдлоо буцаахыг шаардан хүчирхийлэл үйлдэгчийг “батлан даалтанд” гаргуулахыг мэрийдэг. Зарим тохиолдолд мэргэжлийн байгууллага, хүмүүст хандаж, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулж, хэл ам шуугиан “сенсац” дэгдээлгүй нууцлаг байдлаар шийдэх гарц хайдаг. Цаашилбал болсон явдлын талаар мэдмэгц тэдний зүгээс дараах сөрөг хандлага, хариу үйлдэл гаргах нь түгээмэл байдаг. Үүнд:

1) Хуулийн байгууллагад хандахаас цааргалах: Хүчингийн хэрэг үйлдэгч нь хохирогчийн төрсөн болон хойд эцэг байгаа тохиолдолд ээждээ хэлсэн боловч итгээгүй байх, эсвэл нөхрийнхөө үгэнд түлхүү итгэх, эсвэл эмэгтэй хүний үүргээ гүйцэтгэж чаддаггүй гэх мэт доромжлолоос шалтгаалан хүн бүхэн өөрийг нь “арчаагүй, муу эмэгтэй” гэж үзнэ гэсэн айдсаасаа шалтгаалан хохирогчийн эх хуулийн байгууллагад хандахаасаа цааргалдаг. Мөн гэр бүлийн хүчирхийлэлд байдаг эмэгтэйчүүд хэдийгээр тухайн байдлыг мэдсэн ч амь насаа алдахаас айх, хүчирхийлэл үйлдэгч гэр бүлийн тэжээгч, орлогыг бүрдүүлэгч байх тохиолдолд хуулийн байгууллагад хандахаас зайлсхийдэг.

2) Хохирогчийг буруутгах: “Чи яагаад өдий болтол хэлэхгүй нуусан юм”; “Чамаас л болсон”; “Чи л эхэлж өдөж хоргоосон байх”; “Чамд мөнгөний хэрэг болоод ингээд байна уу”; “Чи дургүй болохоороо л ингэж байгаа юм, төрсөн эцэг чинь байсан бол ингэж хандахгүй байсан” гэх мэтээр хохирогчийг буруутгах хандлага гаргадаг.



3) Хохирогчид үл итгэх: “Ийм юм байх ёсгүй”; “Чи худлаа хэлж байна”; “Чи энэ хүнд дургүй болохоороо л тэгж хэлж байгаа биз дээ”; “Өөр хүнээс л жирэмсэн болчихоод хэлж чадахгүй болохоороо бид хоёрыг муудуулцуулах гэж ингэж байгаа”; “Яагаад ч ийм юм хийхээр хүн биш, Би өөрөөс нь асуусан, Үгүй л гэж байна лээ” гэх мэтээр хохирогчид үл итгэдэг.

4) Хохирогч хүүхдийг шийтгэх: Гэрээсээ хөөх, зодох, хичээлд нь явуулахгүй, бусадтай уулзуулахгүй байх, бүх харилцаа холбоог нь тасалж ганцаардуулах, хүчээр үр хөндүүлэх, гэрээсээ явуулах зэргээр хохирогчийг шийтгэх үйлдэл гаргадаг.

5) Хохирогчид сэтгэлзүйн дарамт үзүүлэх: “Энэ тухай мэдээгүй байсан нь дээр байсан юм”; “Өөр хүмүүст хэлж яриагүй биз дээ”; “Гэр бүлийн нэр хүнд унагалаа, манайх ч одоо хүн болгоны амны бай боллоо, яаж хүний нүүр харна, цаашаа хэн орлого олж, энэ гэр бүлийг тэжээх юм” гэх мэтээр хохирогчийг дарамталдаг.

6) Хохирогчийг гэмт хэрэгтэнтэй хүчээр нүүрэлдүүлэх: Төрсөн болон хойд аавтай нь (хүчин үйлдэгчтэй) нүүрэлдүүлэх зэргээр гэмт хэрэгтэн өөрийнхөө буруугүй байсан гэдгийг батлахыг оролддог.

7) Хохирогчид бухимдлаа гаргах: Болсон явдлын тухай ярих, уг хэрэг болсноос хойш цаг үргэлж уурлаж бухимдан сэтгэлээр унасан байдлаа илэрхийлэх, “Чамаас болж энэ бүх асуудал үүсэж байна, чи л хамаг зүйлийн буруутан” гэж буруутгах, эсвэл хэнд юунд уурлаад байгаа нь ойлгомжгүй бүх хүн рүү бухимдаж хашхичиж, загнах; “Би энэ тухай яримааргүй байна, чамайг харахыг ч хүсэхгүй байна, чи хүсвэл энэ гэрээс явж болно шүү, нэгэнт болоод өнгөрсөн явдлыг ингээд мартаад зүгээр амьдар” гэх мэтээр бурууг хохирогчоос хайдаг.

8) Хохирогчийг шахалтад оруулах: Яг юу болсныг нэгд нэгэнгүй ярихыг дахин дахин шаардах, эсхүл “худлаа гэж хэл” гэж шахах гэх мэт үйлдлүүдийг гаргадаг.

Зөвлөгч нь дээр дурдсан түгээмэл онцлогуудыг хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдтэй ярилцах, зөвлөгөө өгөх явцдаа сайтар ажиглаж, шийдвэр гаргахдаа тооцож үзвэл зохино.

6.1.3 Ураг төрлийн хүчингийн хохирогч хүүхдэд өгөх зөвлөгөө

Ураг төрлийн хүчингийн хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөхөд дөрөвдүгээр бүлэгт танилцуулсан бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх нийтлэг арга барилуудыг нэгэн адил хэрэглэнэ. Үүний сацуу зөвлөгч дараах зүйлүүдийг зөвлөгөө өгөхдөө анхаарч ажиллавал зохино. Тухайлбал,

- Хэзээ ч ямар ч шалтгаан байсан хохирогч хүүхдийг буруутгаж огт болохгүй.
- Зөвлөгч нь уг гэмт хэргийг илрүүлэх, мэдээлэх, хохирогчийг хамгаалахад, хохирогч хуулийн байгууллагад хандсан бүх үе шатанд мэргэжлийн сэтгэл зүйчийн зөвлөгөөгөөр хангаж, сэтгэл зүйн хувьд тогтвортой, хэвийн болоход нь туслах хэрэгтэй.
- Дан ганц сэтгэл зүйн дэмжлэг гэлтгүй энэ гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдэд тухайн нөхцөл байдлыг мартахад тус болох орчин нөхцөл нэн чухал.
- Зөвлөгч нь ураг төрлийн хүндээ хүчиндүүлсэн хүүхдэд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөхийн зэрэгцээ удаан хугацааны сэтгэл заслын эмчилгээ, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжлийн тусламжид холбон зуучилж хамтран ажиллах шаардлагатай.

ПРАКТИК ЗӨВЛӨМЖ

- Ураг төрлийн хүчингийн гэмт хэргийн тохиолдолд нийгмийн ажилтан болон сэтгэлзүйч хэн ч байсан хохирогч хүүхдийг ээж, эсвэл хамт ирсэн асран хамгаалагчаас нь тусгаарлан тусад нь зөвлөгөө өгч, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийснийхээ дараа шийдэлд хүрэх нь илүү үр дүнтэй.
- Зөвлөгчийн баримтлах гол зарчим нь хүүхдийн эрх ашгийг дээдэлж, хамгаалах явдал юм. Иймээс хүүхдийн хүсэлт, хүүхдийн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн үйлчилгээний төлөвлөгөөг хийж, асран хамгаалагчид нь танилцуулах хэрэгтэй.
- Зөвлөгч нь асуудлыг энгийн хэлбэрээр илэрхийлэх, ижил хүйсийн хүн харилцан ярилцах нь чухал.
- Хүүхэдтэй алдаатай ойлголтын талаар тодруулж ярилцах. Ингэснээр буруу, эргэлзээтэй ойлголтыг залруулж, нэгдсэн ойлголттой болоход дөхөм болно.
- Холбоо тогтоох үеэс л хохирогч хүүхдийн илтгэлийг олох нь хамгийн чухал. Үүнээс зөвлөгөө өгөх үйл явц эхлэх ба үр дүн хамаарна.

Болсон явдал нь хохирогчийн хувьд хамгийн эмзэг сэдэв учраас тэр бүр танихгүй хүнд нарийн ширийн зүйлүүдийг ярихаасаа зүрхшээж, ичиж байж магадгүй тул шавдуулж, яаруулалгүйгээр чөлөөтэй, тайван ярилцах боломжийг бүрдүүлж өгсний үндсэн дээр хүчиндүүлсэн болон хүчиндүүлсэн байж болзошгүй хүүхдээс доорх зүйлүүдийг маш болгоомжтойгоор нарийвчилж асууна. Үүнд:

- Дотуур хувцас чинь урагдсан, толбо болсон юм уу, цустай байгаа юу? Эсвэл ийм зүйлүүд байсныг би чи угааж арилгасан тал бий юу?
- Бэлэг эрхтнийх нь орчимд хөндүүрлэж өвдөх буюу загатнах шинж тэмдэг илэрч байна уу?
- Гадна бэлэг эрхтэн орчимд чинь цус хурсан ч юм уу ямар нэг хэвийн бус байдал мэдрэгдэж байгаа юу?
- Болсон явдлаас хойш бэлгийн замын халдварт өвчин авсан шинж тэмдэг мэдрэгдэж байна уу?
- Жирэмсэн болсон эсэх талаар өөрөө юу гэж бодож байна вэ?
- Биеийн хэсгүүдэд чинь зодуулж, цохиулсны ямар нэг ул мөр бий юу?
- Болсон явдлын дараа шууд цагдаагийн байгууллагад очсон уу? эсвэл очихоосоо өмнө ул мөрийг арилгасан зүйл бий юу?

Хэрэв дээрх асуултуудын аль нэгэнд хохирогч “тийм” гэж хариулж байвал зөвлөгөө өгөхдөө Зөвлөгч нь дараах хариу үйлдлүүдийг хэрэгжүүлээрэй.

- **Хүүхдийг дэмжиж урамшуул.** Тохиолдсон зүйлээ ярьсных нь төлөө хүүхдийг дэмжиж, урамшуул.
- **Хүүхдэд итгэ.** Хүүхдүүд бэлгийн хүчирхийллийн талаар худал ярих нь ховор байдаг болохоор түүний хэлсэн ярьсан зүйлд итгэ.
- **Чи буруугүй гэдгийг ойлгуул.** Хүүхдийн хувьд хамгийн том бэрхшээл бол болсон явдалд тэр өөрөө буруутай, хариуцлага хүлээх болно гэсэн айдас юм. Өөрөө өөрийгөө буруутгах энэхүү байдлыг багасгах нь тэргүүн зэргийн ач холбогдолтой.
- **Эмнэлгийн болон шүүх эмнэлгийн үйлчилгээг яаралтай авахад тусал.**
- **Цагдаад мэдэгд.** Цагдаад мэдэгдэхийнхээ өмнө яагаад заавал мэдэгдэх ёстой талаар үйлчлүүлэгчдээ хэлж тайлбарлаарай.
- **Хуулийн зөвлөгөө, туслалцаа авахыг санал болго.** Үйлчлүүлэгчтэйгээ зөвлөлдсөний үндсэн дээр хуулийн байгууллагад буюу хуулийн зөвлөгөө өгөх төв, мэргэжлийн хуульчид хандахыг санал болгоорой. Ингэхдээ хуулийн байгууллагад

хэрхэн хандах, процесс хэрхэн явагддаг талаар тайлбарлаж өгөх шаардлагатай.

- **Үйлчилгээнд зуучилж тусал.** Туршлагатай эмчид үзүүл. Хүүхдийг эмнэлгийн тусгай үзлэгт оруулснаар бэлгийн хүчирхийллийн талаар илүү ихийг олж мэдэх болно. Шаардлагатай бол хүүхдийг хамгаалах, бэлгийн хүчирхийллийн хохирогчид туслалцаа үзүүлэх чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагыг олж холбоо тогтоож тэдэнтэй хамтарч ажиллаарай.
- **Тохиолдол бүрийн онцлогт тохирсон арга барилаар ажилла.** Ойролцоо, төстэй тохиолдлууд байж болох ч яг ижил тохиолдол гэж байхгүй. Иймд зөвлөгч үйлчлүүлэгчийнхээ сайн сонсогч байх төдийгүй, өмнөх кейсүүдтэй адилтгахгүй, тохиолдол тус бүрийг шинээр хүлээн авч сурах нь маш чухал.
- **Эргэх холбоотой бай.** Ярилцлагынхаа төгсгөлд хүүхэдтэй дахин ямар байдлаар, хэзээ, хэрхэн холбоо тогтоож болохыг асууж тохиролцоорой. Дахин ийм асуудал гаргуулахгүй байх аюулгүйн төлөвлөгөөг хамтран боловсруулаарай.

Хүүхдийн ураг төрлийн бэлгийн хүчирхийлэл нь манай нийгмийн сэтгэл зовоосон хамгийн том асуудлуудын нэг учраас түүнтэй тэмцэхэд таны хувь нэмэр маш чухал. Юу ч хийхгүй амаа хамхисаар байвал бусад олон хүүхэд хохирсоор байх болно.

ПРАКТИК ЗӨВЛӨМЖ

- Хүчингийн хохирогч болсон хүүхдэд дараах зүйлүүдийг заавал мэдүүлэх хэрэгтэй. Үүнд: (i) Усанд орохгүйгээр шүүх эмнэлэгт үзүүлэх; (ii) Болсон явдлын тухай ээждээ, эсвэл нийгмийн ажилтан, хүүхдийн байгууллага, өөрийн итгэлтэй хүндээ заавал мэдэгдэх; (iii) Өөрийгөө хамгаалах аюулгүйн хамгаалалтыг хийж эхлэх.
- Хүчин, бэлгийн халдлагаас хохирогч сэтгэлийн гүн шарх авсан учир дахин дахин яриулах, олон байцаагч, олон шат дамжлаг дамжин мэдээлэл өгүүлэх нь хохирогчийг үл хүндэтгэн сэтгэлийн шархыг нь хөндсөн давхар хүчирхийлэл, сэтгэлийн дарамт үзүүлэхгүй байх хэрэгтэй. Хэргийн талаар нэг удаа яриулдаг байх нь маш чухал!!!
- Хохирогч өөрийгөө доромжлогдсон гэж эмзэглэж байгаа үед нийгмийн ажилтан, цагдаагийн албан хаагч үг хэлээрээ болон биеийн хэлэмж хөдөлгөөнөөрөө үл хүндэтгэсэн, үл тоомсорлосон, тохуурхсан, сонирхсон байдал гаргах нь хохирогчид давхар дарамт болдгийг анхаараарай.

6.2 БЭЛГИЙН МӨЛЖЛӨГИЙН ХОХИРОГЧ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ГЭР БҮЛД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ НЬ

6.2.1 Бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхдийг ойлгох нь

Хүн худалдаалах гэмт хэргийн хамгийн түгээмэл үйлдэгддэг хэлбэр нь бэлгийн мөлжлөг юм. Бэлгийн мөлжлөг гэдэгт ашиг олох зорилгоор бэлгийн харилцаанд албадан оруулж, биеийг нь үнэлүүлэхийг ойлгоно. Дэлхийн улс орнуудад болон манай улсад үйлдэгдэж байгаа хүний наймааны гэмт хэргийн 70 орчим хувь нь бэлгийн мөлжлөгийн зорилгоор үйлдэгдсэн байдаг.

Бэлгийн мөлжлөгийн хохирогчид нь дийлэнхдээ охид, залуу эмэгтэйчүүд байдаг бөгөөд нас бага байх тусам хууртагдах, гэмт этгээдийн эрхшээл дарамтад нь орох, хүний наймаанд өртөх өндөр эрсдэлтэй гэж үздэг.

Энэ гэмт хэргийн хохирогчид нь удаан хугацаанд бусдын эрхшээл дарамтан дор амьдарснаасаа шалтгаалаад зан авирын өөрчлөлтөд орсон байх, гадагшаа чиглэсэн сөрөг зан үйл гаргах, өөрийгөө тайвшруулах зорилгоор архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг болсон байх магадлалтай байдаг.

Бусдын эрхшээл, дарамтад байж бие махбодын, бэлгийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамтад өртсөнөөр хохирогчийн бие махбод, нөхөн үржихүй, сэтгэцийн эрүүл мэндэд удаан хугацааны үр дагавар, хор уршиг илрэхэд хүргэдэг.

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН БИЕ МАХБОД, СЭТГЭЛЗҮЙД ГАРАХ ҮР ДАГАВРУУД⁵¹

Бие махбодын хүчирхийлэл <ul style="list-style-type: none"> • Бие махбодыг гэмтээх • Тамлах, тарчлаах • Хоол хүнс, нойргүй байлгах, байнга шөнийн цагаар амралтгүй ажиллуулах • Эмнэлгийн үйлчилгээ үзүүлэхгүй байх • Хууль бусаар хорих • Хүчээр шивээс, тэмдэг тавих • Амь насыг нь хохироох 	Бие махбодод учрах хор хохирол <ul style="list-style-type: none"> • Бие махбодын хүнд гэмтэл авах • Гэмтэл бэртлээс шалтгаалан хөдөлмөрийн чадвараа алдах • Хөгжлийн бэрхшээлтэй болох • Нойр солигдох, нойргүйдэх • Хоол тэжээлийн дутагдалд орох • Хууч өвчин, гэмтэл нь сэдрэх, хүндрэх • Шивээсээр дамжсан арьсны өвчлөл, халдвар • Амь насаа алдах
Бэлгийн хүчирхийлэл <ul style="list-style-type: none"> • Бэлэг эрхтнээр, амаар болон анусаар хүчирхийлэх • Хүчээр биеийг нь үнэлүүлэх • Хамгаалалтгүй бэлгийн хавьталд оруулах • Хүсээгүй жирэмслэлт • Хүчээр үр хөндөлт хийх • Сарын тэмдгийн үеэр хүчээр бэлгийн харилцаанд оруулах • Бэлэг эрхтнийг эрэмдэглэх (персинг, зүүлт зүүх, мэс заслын аргуудыг ашиглах) 	Бэлгийн эрүүл мэндэд учрах хохирол <ul style="list-style-type: none"> • Бэлгийн замын халдвар авах • Бэлэг эрхтэн нь гэмтэх • Нөхөн үржихүйн эрхтнүүд нь гэмтэх • Жирэмслэх чадваргүй үргүй болох • Хүүхэд тээж, төрүүлэх боломжоо алдах • Сарын тэмдгийн хямралд орох • ХДХВ-ийн халдвар авах
Сэтгэл зүйн хүчирхийлэл <ul style="list-style-type: none"> • Нийгмийн амьдарлаас бүрэн тусгаарлах • Доромжлох, доог тохуу хийх • Байнгын сүрдүүлэг, айдас дарамтад байлгах • Ар гэрийнхнийг нь заналхийлэх • Өөрийн хяналтаа бүрэн тогтоосноо байнга мэдрүүлэх • Эрх мэдэлтэн, албан тушаалтнаар сүрдүүлж айлгах • Бусдаас туслалцаа авах боломжгүй болгох • Эрх чөлөөг нь хязгаарлах, мөрдөж мөшгөх • Хүчирхийлнэ, ална гэж сүрдүүлэх • Дуу, дүрсний бичлэгийг хийх, цахимаар тараахаар сүрдүүлэх • Гэмт этгээдийн өөрийнх нь хэлснээр байх нь л амьд үлдэх эцсийн боломж гэж итгүүлэх 	Сэтгэцийн эрүүл мэндийн хохирол <ul style="list-style-type: none"> • Гэмтлийн дараах сэтгэл зүйн хямрал эмгэгүүд • Хүнд хэлбэрийн сэтгэл гутралд орох, хар дарж зүүдлэх • Өөрийгөө бусдаас тусгаарлах, хүнд итгэхээ болих • Ой санамжаа алдах, марталт ихтэй болох • Тайвшруулах эм, бодис зэргээс хамааралтай болгох • Сэтгэлийн хөдөлгөөнөө удирдах чадвараа алдах • Архаг ядаргаа, нойргүйдэлд орох • Хүнтэй харилцаа тогтоох чадамжгүй болох • Гэмших, ичгүүртэй байдалд орсон мэт санагдах • Хүн бүр өөрийг нь буруутгаж байгаа юм шиг сэтгэгдэл төрөх • Архи, тамхи, мансууруулах бодисоос хамааралтай болох • Амиа хорлох магадлалтай байх, амиа хорлохыг оролдох

Бэлгийн мөлжлөгөөс шалтгаалсан сэтгэл зүйн болон эрүүл мэндийн үр дагавар нь бидний төсөөлснөөс өндөр байдаг. Гэмт хэрэгтнүүд охидыг өдөрт хамгийн багадаа 2-оос дээш хүнд хүчээр биеийг нь үнэлүүлэн мөлжиж байдаг.

⁵¹ ОУШХБ, “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх шууд тусламжийн гарын авлага”, 2010 он



6.2.2 Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдэд өгөх зөвлөгөө

Энэ гэмт хэргийн хохирогч хүүхдэд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа нь дөрөвдүгээр бүлэгт танилцуулсан бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд зөвлөгөө өгөхтэй ижил зарчмаар явагдана. Гэхдээ уг гэмт хэргийн онцлогоос шалтгаалаад Зөвлөгч доорх зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй.

1) Нэн тэргүүнд аюулгүй байдлыг хангах: Хохирогчийн мэдүүлэг нь гэмт этгээдийн хууль бус үйлдлийг илчлэх, тэдний эрх, эрх чөлөөнд заналхийлж байдаг учраас гэмт этгээдүүдийн зүгээс хохирогчийн болон тэдний гэр бүлийн гишүүд, дотнын хүмүүсээс нь өшөө авах эрсдэлтэй байдаг. Тийм учраас Зөвлөгч нь хохирогчийн аюулгүй байдал хангагдсан эсэхийг тодруулж, нэн тэргүүнд хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хэрэв эрсдэлтэй байна гэж үзвэл яаралтай хуулийн байгууллагатай холбож өгөх шаардлагатай.

2) Эрсдэлийг урьдчилан тооцох: Бүх эрсдэлийг урьдчилан тооцож, бүгдийг нь арилгах боломжгүй гэдгийг Зөвлөгч байнга анхаарах нь зүйтэй. Гэхдээ бэлгийн мөлжлөгийн хохирогч болсны дараа гэр бүл, ойр дотнынхон, таньж мэддэг хүмүүс нь хохирогчийг буруутгаж, гутаан доромжилсноор өөрөөр амьдрах сонголтгүй болгож, хүн худалдаалах гэмт хэргийн илүү хүнд хэлбэрийн хохирогч дахин болох эрдлийг бууруулахад зөвлөгч боломжтой бүх арга хэмжээг авах шаардлагатай.

3) Итгэл төрүүлэх: Ихэнх хохирогчид бусдад итгэл итгэлээ алдсан байдгаас тусламжаас татгалзах, дургүйцэх, өөрийнхөө талаар бүрэн мэдээлэл өгөхөөс татгалзах хандлагыг гаргадаг. Тиймээс тухайн хүнд итгэл төрүүлэн, туслалцаанд хамруулах нь зөвлөгчөөс ихээхэн ур чадвар, уйгагүй ажиллах шаардлагатай.

4) Уулзаж ярилцахдаа энгийн нөхөрсөг орчинг бүрдүүлэх: Боломжтой бол хохирогчтой уулзахаасаа өмнө тухайн кейсийн талаар мэдээлэл авсан байвал сайн. Ярилцлагын уур амьсгалыг аль болох энгийн нөхөрсөг байлгах, цаг агаар, орчны байдал гэх мэт энгийн зүйлээс яриагаа эхлэх.

5) Маш анхааралтай ажиглах: Олон хохирогч байнгын айдас, сүрдүүлгээс шалтгаалан сэтгэцийн өөрчлөлтөд өртсөн байх магадлал өндөр байдаг. Тиймээс Зөвлөгч нь ярилцлагын эхэнд хохирогчоо маш анхааралтай ажиглаж, хэрэв сэтгэцийн эмгэгийн шинж илэрвэл шууд сэтгэцийн эмнэлэг, мэргэшсэн сэтгэцийн эмчид холбон зуучлах шаардлагатай.

6) Үл буруутгах: Ямар ч тохиолдолд хохирогч хүүхдийг буруутгахгүй харьцах нь маш чухал.

7) Хүндрэлтэй асуудлыг олж мэдэхийг хичээх. Үүний тулд хохирогчтой ярилцахдаа дараах тодруулах асуултуудыг ашиглаж болно.



ТОДРУУЛАХ АСУУЛТУУД БА ЗҮЙЛҮҮД	ХЭРЭГЦЭЭ БА ГАРАХ ҮР ДҮН
Одоо яг хэнээс юунаас айж байна? Айдаст хүргэж буй хүчин зүйл шалтгааныг тодруулах	Үйлчлүүлэгчийг тайвшруулахын тулд айдсын хүчин зүйлийг таньж мэдсэн байх хэрэгтэй. Гэмт хэрэгтнүүдийн зүгээс учруулж байсан хохирол нь айдсыг бодит болгоход нөлөөлсөн байдаг тул учирч болзошгүй гэж үзэж байгаа айдсыг өөрөөр нь тодорхойлуулах нь чухал байдаг.
Өөрийг нь зовоож байсан хүмүүсээс хохирогчид хамгийн хүндээр туссан зүйл юу болох? (бие махбод сэтгэлзүй зовуурь шаналгаа гэх мэт)	Гэмт хэрэгтний зүгээс хэрхэн хяналтаа тогтоож байсан, эрхшээлдээ оруулахын тулд хэрэглэдэг байсан хяналтуудыг мэдэж авснаар сэтгэлзүйн зөвлөгөө үзүүлэх төлөвлөгөө гаргахад нэмэр болдог.
Ажлын цаг амралт хоол ундаа хэрхэн зохицуулдаг байсан?	Энэ талаар мэдсэнээр тухайн үйлчлүүлэгчийн туулсан хүнд үеийг тодорхойлон гаргахад тустай.
Өмнө нь энэ байдлаас гарахаар хийж байсан оролдлогууд байгаа эсэх, байсан бол хэрхэн төгсөж байсан?	Тухайн асуудлыг даван туулах чадвартайг нотлох, үйлчлүүлэгчийг дэмжих, өөрийгөө хамгаалах чадвар, чадамжтайг нь итгүүлэх
Хэрхэн аврагдсан? Тухайн үед сэтгэлзүйд гарч байсан өөрчлөлтүүдийг өмнөх амьдралын түүхтэй нь харьцуулж яриулах	Үр дүнд тулгуурлан үйлчлүүлэгчийн хийсэн эерэг үйлдлүүдийг дэмжих замаар цаашдын хэвийн амьдралд орох үйл явцыг дэмжих
Мэргэжлийн байгууллагын тусламжийг урьд нь авч байсан эсэх? Үр дүн?	Илүү сайн мэргэшсэн байгууллага, мэргэжилтний тусламжийг авах талаар үйлчлүүлэгчид зөвшилцөж төлөвлөхөд хэрэгтэй.

Хохирогчид эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээг хамтад нь үзүүлэх нь илүү үр дүнтэй. Иймд Зөвлөгч нь хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд шаардлагатай бөгөөд боломжтой үйлчилгээний талаар танилцуулан, зөвшилцсөний үндсэн дээр холбогдох мэргэжлийн байгууллагуудад холбон зуучлах үйлчилгээг нэн даруй хэрэгжүүлэх ёстой. Зөвлөгчийн нэг гол үүрэг нь яг хаана хандсан, асуудал ямар шатандаа яваа, одоо хаана хандуулах ёстой талаар бүрэн мэдээлэлтэй байж, дараа дараагийн зайлшгүй үйлчилгээнд холбон зуучилж өгөх явдал юм.

Хохирогч насанд хүрээгүй тохиолдолд гэр бүлээсээ тусгаарлагдсан, бүтэн өнчин, асрамж, халамжийн төвд байрладаг эсвэл ар гэрийг тогтоох, гэртээ очих ямар ч боломжгүй нь цагдаагийн байгууллагаар тогтоогдсоноос бусад нөхцөлд заавал эцэг эх, асран хамгаалагчид нь мэдэгдэх ёстой.

6.3 ЦАХИМ БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХЭД, ТЭДНИЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮДЭД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ НЬ

6.3.1 Цахим бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг ойлгох нь

Хүүхэдтэй бэлгийн хүчирхийллийн зорилгоор холбоо тогтоогчид ихэвчлэн удаан хугацаанд санаатайгаар, нарийн төлөвлөж, тодорхой арга зүй ашиглаж олон аргаар хүүхдийг хууран мэхэлж урхидаж залилан аргандаа оруулдаг педафилууд (бэлгийн гаж донтонууд) байдгийг тодорхойлдог болсон⁵².

Ийм бэлгийн донтонууд боловсон, ятгаж үнэмшүүлэх харилцан ярианы нарийн стратеги ашиглан хохирогчтой ойр зуурын яриа өрнүүлэх, магтах, дөвийлгөх зэргээр итгэлийг нь хурдан хугацаанд олж авч улмаар маш хурдтай лавшруулж бэлгийн харилцааны талаар


⁵² Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс хамгаалахтай холбоотой нэр томъёоны тайлбар (Люксембургийн зааварчилгаа), 2016 он See, for instance, [http:// www.europeanonlinegroomingproject.com/home.aspx](http://www.europeanonlinegroomingproject.com/home.aspx)



зурвас илгээх, санал тавихуйц хэмжээнд хүрдэг байна⁵³.

Иймээс цахим бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдэд зөвлөгөө өгөхийн тулд гэмт этгээдийн зүгээс хүүхдийг эрхшээлдээ оруулдаг алхмуудыг Зөвлөгч сайн мэддэг байх ёстой. Энэ нь хохирогчийн эрхийг хамгаалах, хохирогчид туслалцаа үзүүлэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохион байгуулахад маш чухал.

Хүүхэдтэй бэлгийн хүчирхийллийн зорилгоор цахим холбоо тогтоох алхмууд



Эдгээр алхмуудыг гэмт этгээд хэрхэн ашиглаж хүүхдийг уруу татдагийг доорх тохиолдлыг жишээнээс харж болно.

Тохиолдол: ...Насанд хүрээгүй 300 хүүхэдтэй чат бичиж нүцгэн зургийг нь авчээ.

Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс бага насны охидыг хууран мэхэлж, нүцгэн зургийг нь авдаг байсан этгээдийг илрүүлжээ. Сүхбаатар дүүргийн XIV хороонд оршин суух, эрхэлсэн ажилгүй 21 настай этгээд нь фэйсбүүк орчинд хуурамч хаягаар олон тооны насанд хүрээгүй охидтой харилцаж, хуурч мэхлэх замаар нүцгэн зургийг нь авдаг байсныг илрүүлэн шалгалтын ажиллагаа үргэлжилж байна.

Уг этгээд нь фэйсбүүкийн “10-16 насныхан”, “Хосоо олъё”, “Зугаатай залуус” гэх мэт олон гишүүнтэй группүүдэд нэвтэрч, өөр хүний зураг нэрийг ашиглан өөрийгөө 16 настай гэж бусдад танилцуулж байжээ. Улмаар 13-14 насны 300 орчим хүүхэдтэй тогтмол мессеж бичиж, харилцаж байсан ба дөрвөн хүүхдээс цээж нүцгэн зургийг нь авсан талаараа урьдчилсан байдлаар мэдүүлсэн байна. Тиймээс бага насны хүүхдүүд фэйсбүүк орчинд болгоомжтой байх, эцэг эхчүүдийг бага насны хүүхдүүдийнхээ фэйсбүүк хэрэглэх хэрэглээнд нь хяналт тавьж байхыг цагдаагийн байгууллагаас анхааруулж байна (<https://gogo.mn/r/229233>).

6.3.2 Цахим бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд өгөх зөвлөгөө

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид зөвлөгөө өгөхдөө дөрөвдүгээр бүлэгт танилцуулсан бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлд нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө

⁵³ <http://www.ekids.mn/Home/newsdetail?dataID=21664>

өгөх ерөнхий арга барилуудыг хэрэглэнэ. Үүний сацуу дараах асуудлуудыг тодруулж, доор санал болгосон стратегиудыг хэрэглэвэл зохино.

Зөвлөгөө өгөхдөө тодруулах асуудлууд:

АСУУДАЛ	АГУУЛГА
Баримтжуулалт	Гэмт этгээдийн зүгээс холбогдож байсан чат, зураг, бичлэг, дуу дүрсний бичлэгүүдийг баримтжуулж авсан эсэхийг тодруулах
Холбоо тогтоосон байдал	Холбогдоод хэр удсан, анх ямар байдлаар холбогдсон талаар олж мэдэх
Итгэлийг олох, өөртөө татах	Гэмт этгээдийн зүгээс ямар байдлаар анхаарал тавьдаг байсан талаар, өөрийнх нь талаар хэлдэг байсан үг, үйлдэл, хүүхэд тухайн гэмт этгээдийг юу гэж үзэж байгааг тодруулах
Дундын нууцын талаар	Хэзээнээс эхлээд ямар нууцтай болсон, чиний ямар нууцыг мэдэх, хүүхэд тухайн этгээдийн ямар нууцыг мэдэх талаар, Асуулт асуухдаа: Та надад санаа зовоож буй асуудлынхаа талаар илүү ихийг хэлж чадах уу? гэх мэт асуулт тавих
Хяналтаа тогтоох	Гэмт этгээдийн сүрдүүлгийн талаар тодруулах, хэзээнээс, ямар байдлаар сүрдүүлэх болсон, хэдийд бэлгийн харьцаанд орсон гэх мэтийг тодруулах
Хүүхдийн хүсэлт	Хүүхэд яг юу хүсэж, асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг хүсэж байгааг тодруулах, гаргасан шийдвэрийг баталгаажуулж асуух, шаардлагатай нэмэлт мэдээлэл, эрсдэлийн талаар холбогдох мэдээллийг өгөх

Цахим бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэдтэй харилцах стратегиуд

СТРАТЕГИ	АГУУЛГА
Бие махбодын аюулгүй байдлыг хангах	<ul style="list-style-type: none"> Хүүхдэд аюултай, аюулгүй орчинг мэдрүүлж сургах Хүүхэд өөрийгөө эрсдэлтэй байдалд оруулахаас хамгаалах Аюулгүйгээр биеэ авч явах дадлуудыг суулгахад чиглэсэн зөвлөгөө өгөх хэрэгтэй.
Сэтгэл хөдлөлийн аюулгүй байдлыг хангах	<ul style="list-style-type: none"> Биеэ зохисгүй авч явааг нь үл хайхран хүүхдэд сайн сайхан үйлдлийг дэмжих Хүүхдүүд анхаарал хүсэж байдаг учраас тэдний хийсэн сайн зүйлүүдэд анхаарлаа хандуулснаар илүү сайн зүйлсийг илүү хийхэд түлхэц болно.
Урамшуулан дэмжих замаар биеэ авч явах эерэг байдлыг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> Хүүхдийг сайшааж магтах Эсвэл хүүхдийн насны онцлогт тохирсон амттан, тоглоом, хичээлийн хэрэгсэл, хувцас гэх мэт зүйлээр урамшуулж болно.
Өөрийг нь биш үйлдлийг нь шүүмжлэх	<ul style="list-style-type: none"> Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд өөртөө итгэлгүй, өөрийгөө үнэлэх үнэлэмж нь унасан байдгаас шүүмжлэлийг шууд хүндээр тусгаж хүлээж авдаг. Иймээс өөрийг нь биш үйлдлийг шүүмжилж буйгаа ойлгуулбал өөрсдийгөө муугаар бодон, бусдаас тусгаарлагдсан мэтээр үзэж, өөрийнхөө талаарх муу бодлоо даван туулахад нь тусална.
Алдаанаас бүү ай, нуух шаардлагагүй гэсэн эерэг үзлийг бий болгох	<ul style="list-style-type: none"> Хүн бүр алдаа гаргадаг, энэ нь байж болох үйлдэл, бидний харьцаанд нөлөөлөхгүй гэдгийг хүүхдэд харуулах. Хүүхдүүдийн сайн хийж чадаж буй зүйлийг нь тэмдэглэж, тодотгон хэлж байх нь хүүхдийг өөртөө итгэх итгэлтэй болоход нь тусална.
Нэг зангаараа байх	<ul style="list-style-type: none"> Хүүхэд танд итгэлтэй байх хэрэгтэй. Таны хүүхэдтэй харьцаж буй зан ааш, үйлдэл, хандлагын байдал нь огцом өөрчлөгдөж байвал хүүхэд танд итгэж чадахгүйд хүрнэ.
Нөхцөл байдал хурцдахаас өмнө анхаарлыг нь сарниулах	<ul style="list-style-type: none"> Зөрчилдөөнөөс зайлсхийх нь түүнийг арилгахаас амар Хүүхэд хямарч, асуудал хурцдахаас өмнө шийдвэрлэх, анхаарал сарниулах арга замуудыг хайж олсон байх ёстой.



Юу хүлээж байгаага ойлгоулах	<ul style="list-style-type: none"> Таны бодлыг хүүхэд мэдэх боломжгүй учраас “Юу” хийгээсэй гэж хүсэж байгаа тухайгаа ойлгомжтой, тодорхой илэрхийлж бай. “Чи юу болсон тухайгаа бидэнтэй ярилцвал үнэхээр их баярлана” гэх мэт
Эерэг хэллэг ашиглах	<ul style="list-style-type: none"> Энэ нь хүүхдийг урамшуулж, эерэг харилцах боломжийг олгон өөртөө итгэх итгэлийг дээшлүүлдэг.
Тэдэнд үгээ хэлэх боломж олгох	<ul style="list-style-type: none"> Хүүхдүүд томчуудаас айж чадал муутай, дээрэлхэгдэж буй мэт санагддаг. Тиймээс хүүхэдтэй ярилцан, тэдний санаа бодлыг сонсож, томчуудтай харилцаж болно гэдгийг мэдрүүлэх хэрэгтэй байдаг.
Хүүхдэд насанд нь тохирсон даалгавар өгч, бусдын сайн сайхны төлөө хариуцлага хүлээхийг нь зөвшөөрөх	<ul style="list-style-type: none"> Энэ нь хүүхдэд зорилгодоо хүрсэн, бусдад хэрэгцээтэй байгаага мэдэрэх мэдрэмжийг төрүүлдэг бөгөөд өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлнэ.
Шударга үнэнч байгаага харуулах	<ul style="list-style-type: none"> Хэрвээ та хүүхэд байсан бол үүнийг шударга гэж үзэх байсан уу гэж өөрөөсөө асуу (Үнэнч бай)
Байдлыг зөөллөхийн тулд хошин шогийн чадвараа ашиглах	<ul style="list-style-type: none"> Гэхдээ энэ нь хэзээ ч хүүхдээр доог тохуу хийх эсвэл түүнийг доромжилсон байдлаар байж болохгүй.
Буруу зүйл дээр хүүхдээс уучлал гуйх	<ul style="list-style-type: none"> Хэрвээ таны буруу байсан бол хийсэн үйлдлээ тайлбарлах (Энэ нь тохиромжтой бол) Энэ нь алдаа гаргаж болно гэхдээ түүнээсээ суралцах хэрэгтэй гэдгийг хүүхдүүдэд харуулдаг. Мөн итгэл, хүндлэлийг бий болгоход тусална.

Хохирогч хүүхдийн сэтгэлзүй маш эмзэг, өөрийгөө буруутгасан хандлага нь гүйцэд арилаагүй байдаг тул хүүхдийн өөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, нийгэм, хамт олны дунд оруулснаар өөрийгөө бусдаас тусгаарлахаас сэргийлэхэд нь тусалж чадна.

6.3.3 Цахим бэлгийн хүчирхийллийн хохирогчийн гэр бүлд өгөх зөвлөгөө

Энэ гэмт хэргийн хохирогч хүүхдийн гэр бүлийн гишүүд, эргэн тойрны ихэнх хүмүүс цахим бэлгийн хүчирхийллийн талаар бүрэн мэдээлэлгүй мэдлэггүй байдлаасаа шалтгаалан яагаад хүүхэд энэ гэмт хэрэгт өртсөнийг бүрэн ойлгодоггүй, хохирогч өөрийн буруугаас энэ гэмт хэрэгт өртөж хохирсон гэж үзэх хандлагатай байдаг.

Хүүхдийн аюулгүй байдлын шинжээчид цахим орчинд хүүхдийг уруу татах үйл явцын гол хэв маягуудыг тодорхойлсон байдаг. Эдгээрээс хүүхдэд нь илэрч байгаа эсэхийг олж мэдэхийг эцэг эхчүүдэд зөвлөдөг. Иймд эцэг эхчүүдэд хүүхдэд доорх шинж тэмдэг илэрч байгаа эсэхэд анхаарлаа хандуулахыг хүсээрэй. Үүнд⁵⁴:

- Онлайн орчинд юу хийж байгаага нууцлах;
- Олон цагаар, ялангуяа шөнө оройн цагаар интернэт, ухаалаг утас ашиглах;
- Таны өмнө огт сонсож байгаагүй найз нөхөдтэй уулзахаар өмнө нь сонирхож байгаагүй хачирхалтай гэмээр газрууд руу явах;
- Нойр, хоолны асуудал, орондоо шээх зэрэг сэтгэл зүйн өөрчлөлттэй болох;
- Чөлөөт цагаараа хийх өөр бусад ажлуудад сонирхол нь буурах;
- Хувцас, гар утас зэрэг шинэ эд юмстай болох, хаанаас, хэнээс авснаа тайлбарлаж чадахгүй байх;
- Зожиг, сэтгэл түгшсэн, сэтгэл санааны дарамтад орсон, уур уцаартай болох;
- Өөрөөсөө ахмад найз охин, найз хөвгүүнтэй болох;

54 <http://www.ekids.mn/Home/newsdetail?dataID=21664>

- Эцэг, найзуудтайгаа байнга зөрчилдөх, хөндийрөх;
- Байнгын айдас, сэтгэл зовнилтой явах;
- Хоол идэх, унтах зуршилд өөрчлөлт орж, өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанаас зайлсхийх;
- Танин мэдэхүйн өөрчлөлтөд орж, анхаарал төвлөрөл буурч, мартамхай байдал болон/эсвэл хайхрамжгүй байдал ажиглагдах зэрэг байдлууд ажиглагдаж магадгүй.

Эцэг эхийн хувьд хүүхдээ цахим бэлгийн хүчирхийллээс бүрэн төгс хамгаалах хамгийн найдвартай арга гэсэн зүйл байдаггүй. Гэхдээ тохиолдож болох зүйлсийн талаар зөв мэдлэгтэй байх хэрэгтэй.



БҮЛЭГ 7. БУСАД ҮЙЛЧИЛГЭЭНД ЗУУЧЛАХАД ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ ЗӨВЛӨГӨӨ

Зөвлөгч нь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудад хандахад туслах, холбон зуучлах үйлчилгээг нэн даруй үзүүлэх үүрэгтэй. Иймд энэ бүлэгт бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд эрүүл мэндийн тусламж, эрхзүйн туслалцаа бусад үйлчилгээг авахад нь Зөвлөгчийн зүгээс өгөх шаардлагатай мэдээлэл зөвлөгөөг товч танилцуулна. Шаардлагатай үед хавсралтад дурдсан нэмэлт лавлагааг үзэж ашиглаж болно.

Зөвлөгч нь бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг зөвхөн тухайн байгууллагуудад илгээгээд зогсохгүй асуудал яг хаана ямар шатандаа яваа талаар бүрэн мэдээллийг гэр бүлийн гишүүдээс цуглуулж, зуучилсан байгууллагатайгаа эргэх холбоотой ажиллах хэрэгтэй. Холбон зуучлах үйлчилгээг үзүүлэхдээ хохирогчийн мэдээллийн нууцыг сайтар хангах шаардлагатай.

Холбон зуучлах үйлчилгээг үзүүлэхдээ Зөвлөгч дараах мэргэжлийн байгууллагууд, мэргэжилтнүүдтэй хамтарч ажиллана: Үүнд:

- Цагдаагийн байгууллага, цагдаагийн албан хаагчид
- Мэргэшсэн өмгөөлөгч
- Шүүх эмнэлэг, шүүхийн шинжээч эмч нар
- Гэмтлийн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн гэмтлийн эмч нар
- Сэтгэцийн эрүүл мэндийн эмнэлэг, хүүхдийн сэтгэцийн эмч, сэтгэл засалчид
- Өсвөр үеийн эрүүл мэндийн төвүүд, эмч, зөвлөгч нар
- Оршин суугаа газрын хамтарсан баг, нийгмийн ажилтан бусад.

7.1 ХУУЛИЙН БАЙГУУЛЛАГАД ХОЛБОН ЗУУЧЛАХАД ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ ЗӨВЛӨГӨӨ

Бэлгийн хүчирхийллийн хохирогч насанд хүрээгүй хүүхэд байгаа тохиолдолд зөвлөгч гэмт хэргийн талаар цагдаагийн байгууллагад заавал мэдээлэх үүрэгтэй талаар бид дээрх бүлгүүдэд сануулсан. Иймд цагдаагийн байгууллагад мэдээлэх нь таны хуулиар хүлээсэн үүрэг болохыг мэдээлэхээсээ өмнө хохирогч хүүхдэд болон гэр бүлийн гишүүдэд нь тайлбарлаж хэлэх ёстойг анхаараарай. Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл нь хүнд гэмт хэрэг тул хохирогчид хуулийн байгууллагын зөвлөгөө, туслалцаа, үйлчилгээ зайлшгүй шаардлагатай болдог. Энэ талаар мэдээлэл зөвлөгөө өгөхдөө дараах зүйлүүдийг анхаараарай. Үүнд:

- Хохирогч насанд хүрээгүй (18 нас хүрээгүй) бол заавал асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байх ёстой.
- 0-14 насны хүүхдийг Эрүүгийн хуульд бага насны хүүхэд гэж үзэж буй тул зөвлөгч эцэг эхийн зөвшөөрлийг үл харгалзан шууд хуулийн байгууллагад мэдээлэл үүрэгтэй.
- 14-18 насны хохирогчийг заавал эцэг эх, асран хамгаалагчийн хамтаар хуулийн болон бусад байгууллагад хандаж тусламж авах ёстойг сануулаарай.
- Хэрэв эцэг, эх, асран хамгаалагч оролцох боломжгүй нь тогтоогдвол харьяа аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газарт хандаж хохирогч хүүхдэд

хууль ёсны төлөөлөгч томилуулахад туслаарай.

- Хохирогч цагдаагийн байгууллагад мэдүүлэг өгөхдөө нууцлал хангах нөхцөлийг бүрдүүлсэн “тусгай өрөө”-нд мэдүүлэг өгөх эрхтэй тул энэ талаар хүсэлтээ илэрхийлэх боломжтойг хэлж өгөөрэй.
- Эмэгтэй цагдаагийн ажилтантай уулзуулж, хэргийг шалгуулах хүсэлтэй байгаагаа цагдаагийн байгууллагад илэрхийлээрэй. Энэ талаар хохирогчид ч сануулаарай.
- Сэжигтэн баривчлагдсан, баривчлах захирамж гарсан эсэхийг цагдаагаас тодруулаарай. Энэ талаар хохирогч мэдэж байгаа эсэхийг лавлаарай.
- Хэрэв сэжигтнийг баривчлаагүй бол хохирогчид энэ талаар тайлбарлаж өгөхийг цагдаагийн албан хаагчаас хүсэх хэрэгтэй.
- Хэрэв хохирогч хүүхэд цаашдаа бэлгийн хүчирхийлэлд дахин өртөх үндэслэлтэй, айдас түгшүүртэй байгаа бол энэ тухай мэдэгдэж, аюулгүй байдлыг хангах яаралтай арга хэмжээ авахыг зөвлөөрэй.
- Өмгөөлөгчийн туслалцаа авч буй эсэхийг тодруулаарай. Авч чадаагүй байгаа бол бэлгийн хүчирхийллийн хохирогчид үнэ төлбөргүй өмгөөллийн туслалцаа үзүүлдэг байгууллага хүмүүстэй холбож өгөхийг хичээгээрэй.
- Нотлох баримтуудаа хангалттай гаргаж өгч чадсан эсэхийг тодруулаарай.
- Гэмт хэрэгтний зүгээс үзүүлж буй дарамт байгаа эсэхийг лавлаарай.
- Хэрэв шүүгдэгч шүүх хурал болохоос өмнө суллагдах бол өмгөөлөгчөөрөө дамжуулан мөрдөгч, прокуророос мэдээлэл авах талаар хохирогч болон гэр бүлийнхэнд сануулаарай.

7.2 ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИД ИЛГЭЭХЭД ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ ЗӨВЛӨГӨӨ

Хэрвээ хохирогч хүүхдэд эмнэлгийн яаралтай тусламж авах шаардлагатай нөхцөл байдал үүссэн бол нэн даруй харьяалал үл харгалзан эмнэлгийн түргэн тусламж эсвэл 24 цагийн үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагад хандана. Хохирогчийг яаралтай бус журмаар эмнэлгийн тусламжид илгээх тохиолдолд хүүхдэд болон гэр бүлийн гишүүдэд мэдээлэл зөвлөгөө өгөхдөө дараах зүйлүүдийг анхаараарай:

- Эрүүл мэндийн тусламж авах шийдвэр нь хохирогчийн эрхийн асуудал гэдгийг тайлбарлаж өгөөрэй.
- Аль ч эмнэлэг эрүүл мэндийн байгууллага гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчид харьяалал харгалзахгүйгээр үнэ төлбөргүйгээр эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх үүргийг хуулиар хүлээсэн байдгийг сануулаарай.
- Хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийнхэн эмнэлгийн тусламж авах боломжтой газар мэдэж байгаа эсэхийг лавлаж, тусламж авах боломжтой эрүүл мэндийн байгууллагуудын нэр, байршил, хаяг, үйлчилгээний цаг зэрэг шаардлагатай мэдээллийг өгөөрэй.
- Хохирогч хүүхэд ямар нэгэн гэмтэл бэртэл авсан тохиолдолд гэмтлийн эмнэлэгт болон шүүх эмнэлэгт хурдан хандаж эмчийн дүгнэлт гаргуулах, эмчилгээ хийлгэх шаардлагатайг анхааруулаарай.
- Бэлгийн хүчирхийллийн хохирогч охид жирэмслэх, ХДХВ-ийн халдвар, БЗДХ авах эрсдэл өндөр байдаг тул бэлгийн замын эмч, эмэгтэйчүүдийн эмчийн үзлэг, шинжилгээг заавал хийлгэхийг санал болгоорой. Ингэснээр хүсээгүй жирэмслэлтээс яаралтай сэргийлэх боломжтойг тайлбарлаж өгөөрэй.



- Сэтгэлзүйн хямрал, сэтгэцийн эмгэг өөрчлөлтийг мэргэжлийн сэтгэцийн эмч, эмнэлэг, сэтгэлзүйч, сэтгэл засалчид хандан оношлуулах, удаан хугацааны зөвлөгөө, нөхөн сэргээх тусламжийг тууштай авах шаардлагатайг анхааруулаарай.
- Эмнэлэгт хандахдаа өөрийн итгэлтэй хүн, гэр бүлийн гишүүд эсвэл найзтайгаа хамт очих, мөн боломжтой бол өмгөөлөгчтэйгөө хамт очихыг сануулаарай.
- Хохирогчийн сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэрийг шүүхээр гаргуулахад шаардагдах шүүхийн шинжээч эмчийн болон сэтгэцийн эмчийн тодорхойлолтыг гаргуулж авах талаар зөвлөөрэй.

7.3 ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ҮЗЛЭГ ШИНЖИЛГЭЭ ХИЙЛГЭХ ТАЛААР ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ ЗӨВЛӨГӨӨ

Хохирогч шүүхээр асуудлаа шийдвэрлүүлэхэд нотолгоо болох нотлох баримтыг бүрдүүлэхийн тулд шүүх эмнэлгийн үзлэг шинжилгээг 24 цагийн дотор яаралтай хийлгэх нь маш чухал болохыг анхааруулж, дараах мэдээлэл зөвлөгөө өгөөрэй.

- Нотлох баримтыг устгаагүй байхдаа буюу усанд ороогүй, хувцсаа солиогүй байхад шүүх эмнэлгийн үзлэг шинжилгээ хийлгэх нь илүү үр дүнтэй. Иймд шүүх эмнэлгийн үзлэгт хамрагдах бол хувцсаа угааж, хаяж болохгүй гэдгийг хэлээрэй.
- Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журмаас доорх зүйлүүдийг танилцуулах: Үүнд: Шүүх эмнэлгийн үзлэг шинжилгээг нийслэлд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжилгээний газар, орон нутагт аймгуудын шүүхийн шинжилгээний албадууд 24 цагаар үзүүлдэг. Шүүх эмнэлэг нь доор заасан хугацаанд дүгнэлтээ гаргадаг:
 - Хүний биед үзлэг хийсэн бол ажлын 3 хоногт
 - Нэмэлт шинжилгээ хийсэн бол ажлын 5 хоногт
 - Цогцос шинжилсэн бол ажлын 10 хоногт
 - Эд эсийн болон нэмэлт шинжилгээ хийсэн эсхүл хэргийн материалаар шинжилгээ хийсэн бол ажлын 21 хоногт
 - Лабораторийн нарийн шинжилгээ хийсэн бол ажлын 21 хоногт багтаан дүгнэлтийг гаргана.
 - Нэмэлт материал шаардагдах тохиолдолд шинжээч томилсон этгээдэд мэдэгдэж хугацааг сунгаж болно.
- Шинжээч томилсон тогтоолыг хаанаас авах талаар хэлж өгөөрэй. Үүнд: Тухайн хэрэг учрал болсон газрын харьяалах аймаг, дүүргийн цагдаагийн хэлтсээс авна.
- Шинжээчийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй буюу дахин дүгнэлт гаргуулах, нэмэлтээр материал өгч дүгнэлтэд тусгуулах боломжтой гэдгийг сануулж энэ талаар дараах мэдээллийг өгөөрэй.
 - Шинжээч томилсон этгээдэд дахин болон нэмэлт дүгнэлт гаргуулах тухай хүсэлт гаргаж болно.
 - Хохирогч 18 нас хүрээгүй бол бэлгийн гэмт хэргийн үзлэг шинжилгээ үнэ төлбөргүй хийлгэнэ.
 - Амьдралын баталгаажих түвшнээс доогуур орлоготой, нэн ядуу иргэний

холбогдох байгууллагын тодорхойлолт болон бусад нотлох баримтыг үндэслэн үзлэг шинжилгээний төлбөрөөс чөлөөлж болно. Яаралтай тохиолдолд эдгээр бичиг баримтыг шаардахгүй⁵⁵ гэдгийг хэлж өгөөрэй.

7.4 ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦОХ ТАЛААР ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ ЗӨВЛӨГӨӨ

- Хохирогч шүүх хуралд биеэр оролцох тохиолдолд урьдчилан бэлтгэх хэрэгтэй.
- Шүүх хурал гэж юу болох, ямар зохион байгуулалттай, хэн хэн ямар эрх, үүрэгтэй оролцдог талаар товч мэдээлэл өгөөрэй.
- Шүүх дээр хохирогчийг төлөөлж маш сайн ажиллах мэргэшсэн өмгөөлөгч олох боломж байгаа эсэхийг тодруулж, туслахыг хичээгээрэй.
- Хохирогч шүүх хурал дээр мэдүүлэг өгөхийг зөвшөөрсөн бол шүүхэд мэдүүлэх хэргийн товч түүхийг бэлтгэхэд нь туслаарай.
- Гэмт хэрэгтнээс зөвхөн бодит хохирол бус, сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэхийг хохирогчид сануулаарай.
- Хохирогч нь шүүхээс түүнд болон гэр бүлийнхэнд нь шийтгэл хүлээлгэх эсвэл цаашид гэмт этгээд дахин хүчирхийлэх вий гэсэн айдастай байгаа бол энэ талаар холбогдох хуулийн хүмүүст заавал хэлэхийг сануулаарай.
- Хохирогчийн өмгөөлөгчийг шүүхээс гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хохирлыг нөхөн төлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх боломжийг олгох хүсэлтийг тавиулж шийдвэрлүүлэхэд туслаарай.
- Хохирогчоос шүүгдэгч, эсвэл шүүгдэгчийн ар гэрийнхнээс сүрдүүлэг, заналхийлэл, хүчирхийлэл хүлээж авсан эсэхийг асууж, хэрэв тийм бол түүнийг энэ талаар даруй цагдаад мэдээлж, хохирогчийг хамгаалалтад авхуулах, шүүх хуралд оролцуулахгүй байх хүсэлт гаргах талаар мэдэгдээрэй.

⁵⁵ Шүүх эмнэлгийн төлбөрт үйлчилгээний журмын нэмэлт өөрчлөлт, а/263, а/706, 321, 2017.10,31



ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ЗАРИМ ХОЛБОГДОХ ХУУЛИУДЫН ЗААЛТААС

Хуулийн нэр	Бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой заалтууд
Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйл: Хүчиндэх	Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл (хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсан) хийсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйл: Хүчиндэх	Энэ төрлийн гэмт хэргийг 14-өөс дээш 18 нас хүрээгүй хүнийг хүчиндэж, бүлэглэж, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж, хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж, хоёр, түүнээс олон хүнийг хүчиндэж, харгис, хэрцгий аргаар, хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр; бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн (энэ хуульд заасан "бага насны хүүхэд" гэж арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг ойлгоно), энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол 12 жилээс 20 жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.
Эрүүгийн хууль	Бага насны буюу 0-14 насны хүүхдийг хүчиндсэн, бэлгийн хүчирхийлэл үйлдсэн бол хүнд төрлийн гэмт хэрэг учраас Зөвлөгч нь хохирогч болон гэр бүлийн гишүүд зөвшөөрсөн эсэхээс үл хамааран заавал цагдаагийн байгууллагад мэдээлэх үүрэгтэй.
Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага эрх нь зөрчигдсөн хүүхдийг дагнасан үйлчилгээгээр хангах, хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, асрамжийн зэрэг шаардлагатай үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй.
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн	Хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд эмнэлгийн тусламж үйлчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, холбон зуучлан үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг ажиллуулна.
Гэр бүлийн тухай хуулийн 67.2	Тухайн хүнийг асран хамгаалах, харгалзан дэмжих шаардлагатай байгаа тухай мэдээллийг аливаа байгууллага, иргэн холбогдох сум, дүүргийн Засаг даргад өгөх үүрэгтэй.

ХАВСРАЛТ 2. ХОЛБОГДОХ ЖУРАМ, ЗААВАР, СТАНДАРТУУД

Үйлчилгээний төрөл	Үйлчилгээний ангилал	Журам, заавар, стандартууд
Аюулгүй байдлын хамгаалалт	-Түр хамгаалан байрлуулах -Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх -Гэрч, хохирогчийг хамгаалах, хамгааллын арга хэмжээнд хамруулах	-Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам: Улсын ерөнхий прокурор, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны А/22, А/31 тоот тушаалын хавсралт -Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх журам: Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/80, А/132, А/60 тоот тушаалын хавсралт -Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/38 дугаар тушаалын хавсралт -Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 тоот тушаалын хавсралт -Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага: Монгол Улсын Стандарт MNS 6040:2019 -Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам: Гадаад харилцааны сайдын 2013 оны А/91 дүгээр тушаалын хавсралт
Эмнэлгийн тусламж үйлчилгээ	-Хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж баримтжуулах -Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх	-Хохирогчид эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам: Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/394 тоот тушаалын хавсралт -Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах арга хэмжээг сайжруулах тухай Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/399 тушаал -Хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар: Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/151 тоот тушаалын хавсралт -Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар: Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/149 тоот тушаалын хавсралт
Сэтгэл зүйн үйлчилгээ	-Сэтгэл зүйн зөвлөгөө -Сэтгэл заслын үйлчилгээ	-Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх журам: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/74 тоот тушаалын хавсралт -Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам: Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/394 тоот тушаалын хавсралт
Нийгмийн халамжийн үйлчилгээ	-Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	-Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сургалт зохион байгуулах үйлчилгээний чанарт тавих шалгуур: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/374 тоот тушаалын хавсралт
Хүүхэд хамгааллын үйлчилгээ	-Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, -Суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах үйлчилгээ	-Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам: Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/148 тоот тушаалын хавсралт -Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 тоот тушаалын хавсралт -Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам: Боловсрол, шинжлэх ухаан, соёлын сайдын 2018 оны А/612 тоот тушаалын хавсралт



Эрх зүйн туслалцаа	-Эрхзүйн зөвлөгөө -Өмгөөллийн үйлчилгээ	-Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/29 тоот тушаалын хавсралт -Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтыг зохион байгуулах журам: Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/56, А/35 тоот тушаалын хавсралт -Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/190, А/280 тоот тушаалын хавсралт -Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журам: Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/63, А/48, А/106 тоот тушаалын хавсралт -Албадан сургалтад хамруулах шийтгэлийг хэрэгжүүлэх журам: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/73 тоот тушаалын хавсралт
Дэмжин холбон зуучлах үйлчилгээ	-Иргэний бүртгэл, сэтгэл зүй, хууль зүй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн болон бусад шаардагдах үйлчилгээ	-Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журам: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/73 тоот тушаалын хавсралт -Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам: Хөдөлмөрийн сайдын А/135 тоот тушаалын хавсралт - Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/128 тоот тушаалын хавсралт

Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулахаас өмнө

- Аюулын зэргийн үнэлгээ хийх журам: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/83 тоот тушаалын хавсралт
- Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/120, А/178 тоот хамтарсан тушаалын хавсралт
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 тоот тушаалын хавсралт

Үйлчилгээнд баримтлах үндэсний стандарт

- Монгол Улсын Стандарт MNS 6040:2019 Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага
- Монгол Улсын Стандарт MNS 6418:2013 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага
- Монгол Улсын Стандарт MNS 6949:2021 Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага
- Монгол Улсын Стандарт MNS 6948:2021 Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага
- Монгол Улсын Стандарт MNS 5852:2017 Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага

Хүний нөөцийн сургах хөтөлбөр

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий мэргэжилтнийг давтан сургах хөтөлбөр, сургалт зохион байгуулах журам: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/149 дугаар тушаалын хавсралт

Хуулийн этгээдийн магадлан итгэмжлэл

- Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/210 тоот тушаалын хавсралт
- Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам: Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/84, А/59, А/130 тоот хамтарсан тушаалын хавсралт

Санхүүжилтийн журам

- Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23,27 тоот хамтарсан тушаалын хавсралт
- Түр хамгаалах байранд байрлах нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/150 тоот тушаалын хавсралт
- Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын А/173, А/251, А/380 тоот хамтарсан тушаалын хавсралт

Мэдээллийн сан бүрдүүлэлт

Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээлийн сан бүрдүүлэх журам: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/25 тоот тушаалын хавсралт



НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Хууль: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Төрийн мэдээлэл, 2017,
2. Монгол Улсын Иргэний тухай хууль, 2002
3. Монгол Улсын Хууль: Хүүхэд хамгааллын тухай, Төрийн мэдээлэл, 2016 он, №9
4. Монгол Улсын Хууль: Хүүхдийн эрхийн тухай, Төрийн мэдээлэл, 2016, № 9
5. Монгол Улсын Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл, 2016, №7
6. Мягмар О, Сэтгэц заслын зөвлөгөөний онол арга зүй: гарын авлага, 2009
7. Мягмар О, Сэтгэц заслын зөвлөгөөний онол арга зүй: гарын авлага, 2009
8. НҮБ-ын Хүүхдийн сан, Хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх сургалтын гарын авлага, 2003 (Англи хэл дээр хэвлэгдсэн)
9. Олон Улсын Шилжих Хөдөлгөөний Байгууллага, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх шууд тусламжийн гарын авлага, 2010
10. Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромын Дүрэм, Төрийн мэдээлэл, тусгай дугаар, 2005
11. Өнөрмаа Б, Цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөл, эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага
12. Улсын Ерөнхий Прокурорын Газрын Сургалт, судалгааны төвийн Гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлах хүрээлэн, Бага насны хүүхдийн эсрэг чиглэсэн бэлгийн хүчирхийллийн суурь судалгаа, 2018
13. Улсын Ерөнхий Прокурорын Газрын Сургалт, судалгааны төв, Хүүхдийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөл судалгаа, 2018
14. Үндэсний Статистикийн Хороо, НҮБ-ын Хүн амын сан, Жендэрт суурилсан хүчирхийллийн үндэсний судалгааны тайлан, 2017
15. Үндэсний Статистикийн Хороо, Гэмт хэргийн статистик 2020
16. Харилцаа Холбооны Зохицуулах Газар, Цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдлын судалгаа, 2021
17. Хүний Эрхийн Үндэсний Комисс, Гүүд Нэйброс, Хүүхдийн эрх ба хамгаалал үндэсний судалгаа, 2016
18. Хүүхдийг бэлгийн мөлжлөг, бэлгийн хүчирхийллээс хамгаалах тухай конвенц буюу "Ланзаротын конвенц" Европын холбоо, 2007
19. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгөөс хамгаалахтай холбоотой нэр томъёоны тайлбар (Люксембүргийн зааварчилгаа), 2016
20. ХТЭТ, Бэлгийн хүчирхийлэл гарын авлага, Улаанбаатар, 2019
21. Хүүхдийн эрхийн тухай Конвенц, Нэмэлт протокол
22. Эрүүл Мэндийн Яам, ДОХ, Сүрьеэ өвчинтэй тэнцэх Глобал сан, ХТЭТ, Хүчирхийллийн нөлөөгөөр охид, эмэгтэйчүүдийн БЗДХ, ХДХВ-ийн халдварт өртөлтийн байдлыг үнэлэх судалгааны тайлан, 2018
23. Эрүүл Мэндийн Яам, Боловсрол, Шинжлэх Ухааны Яам, НҮБ-ын Хүн амын сан, Бэлгийн боловсрол 1" гарын авлага, Улаанбаатар хот